

# Олон нийттэй харилцах бодлого 2011

Мэдээллийг олон нийтэд  
ил гаргах ба солилцох

Азийн Хөгжлийн Банк

**ADB**

Asian Development Bank

# Олон нийттэй харилцах бодлого 2011

Мэдээллийг олон нийтэд  
ил гаргах ба солилцох

2011 Азийн Хөгжлийн Банк

Бүх эрхийг хамгаалсан. 2011 онд хэвлэв.  
Филиппин улсад хэвлэв.

ISBN 978-92-9257-795-7  
е-ISBN 978-92-9257-796-4  
Хэвлэлийн дугаар TIM178736-2

Каталогт орох мэдээлэл

Азийн Хөгжлийн Банк.

Олон нийттэй харилцах бодлого 2011: Мэдээллийг олон нийтэд ил гаргах ба солилцох  
6 АХБ өргөн чөлөө, Мандалуёнг хот, 15550, Метро манила, Филиппин улс

1. Мэдээллийг олон нийтэд ил гаргах.      2. Мэдээлэл солилцох.      3. Азийн Хөгжлийн Банк.  
I. Азийн Хөгжлийн Банк.

Тухайн газар нутаг эсвэл газар зүйн нутаг дэвсгэрийг дурьдахдаа эсвэл “улс орон” гэсэн нэр томъёог ашиглахдаа АХБ нь аливаа газар нутаг, нутаг дэвсгэрийн эрх зүйн болон бусад статусын талаар шүүмж гаргахыг зориогүй болно.

Хэрэв аливаа материал өөр эх сурвалжтай холбоотой бол түүнийг дахин хэвлэх, хуулбарлах зөвшөөрлийг хүсэхийн тулд тухайн эх сурвалж бүхий зохиогчийн эрхийг эзэмшигч эсвэл хэвлэгч нарт хандана уу. АХБ тухайн материалыг хэн нэгэн ашигласны дүнд гарсан аливаа шаардлагыг үл хариуцна.

Тайлбар: Энэхүү нийтлэлд “\$” нь ам.долларыг илэрхийлсэн тэмдэг болно.

Азийн Хөгжлийн Банк  
Азийн Хөгжлийн Банкны өргөн чөлөө 6, Мандалуёнг хот  
Метро Манила 1550, Филиппин Улс  
Утас +63 2 632 4444; Факс +63 2 636 2444  
[www.adb.org](http://www.adb.org)

Илүү их мэдээлэл авахыг хүсвэл, доорх хаягаар холбоо барина уу:  
Мэдээллийг олон нийтэд ил гаргах асуудал хариуцсан нэгж (Мэдээллийн нэгж)  
Гадаад харилцааны газар  
Факс +63 2 636 2649  
[disclosure@adb.org](mailto:disclosure@adb.org)

Унших: <http://www.adb.org/Disclosure>

Энэ бол АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр 2011 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан албан ёсны бодлогын баримт бичгийн хэвлэмэд хувилбар.

 Дахин боловсруулсан цаасан дээр хэвлэв.

Товчилсон үгсийн тайлбар	v
Нэр томъёоны тайлбар	vi
Хянан шалгасан хүмүүс	viii
Хураангуй	1
1 Оршил	6
2 АХБ-ны олон нийттэй харилцах туршлага	7
Бодлогын зорилго	7
Бодлогын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ	8
3 Олон нийттэй харилцах салбар дахь олон улсын шинэ чиг хандлагууд	11
4 2005 оны бодлогод оруулахаар санал болгосон шинэчлэлүүд	12
5 Олон нийттэй харилцах бодлого	14
6 Мэдээллийг олон нийтэд ил гаргах тухай	16
Улс оронтой хамтран хэрэгжүүлэх стратеги болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратеги	16
Төсөл, хөтөлбөрүүд	17
Төсөл, хөтөлбөрүүдэд хамаарах бусад мэдээлэл	22
Бодлого ба стратеги	23
Үйл ажиллагааны дүрэм журам	24
Бусад мэдээлэл	24
Мэдээллийг олон нийтэд ил гаргах бодлогод үл хамаарах онцгой тохиолдлууд	27
7 Олон нийттэй харилцах арга барил	31
Зорилтот харилцагч талууд	31
Зорилтот харилцагч талуудад хүрэх арга барил	31
Орчуулга	31
8 Хэрэгжүүлэх арга зам	33
Үүрэг ба хариуцлага	33
Мэдээллийг авах журам	36
Эргэн хянах, тайлагнах	39
Бодлого хүчин төгөлдөр болох өдөр болон бодлогыг эргэн дүгнэх	39
9 Нөөцийн үзүүлэлт	40
10 Хэрэгжилтийг эргэн хянах	41

Хавсралт

1. Гадны харилцагч талуудтай зөвлөлдөх үйл явц	42
2. Олон талт хөгжлийн бусад банкуудын мэдээллээ олон нийтэд ил гаргаж буй байдал	44
3. 2005 оны Олон нийттэй харилцах бодлого, Олон нийттэй харилцах бодлогыг эргэн хянасан баримт бичиг болон Дэлхийн Банк, Америк дундын Хөгжлийн Банкны Мэдээлэл авах тухай бодлогуудын харьцуулалт	50
4. Олон нийттэй харилцах бодлогын үр дүнгийн хүрээ	57

# Товчилсон үгсийн тайлбар

Олон нийттэй  
харилцах  
бодлого 2011

АХБ	–	Азийн Хөгжлийн Банк
АХС	–	Азийн хөгжлийн сан
АфХБ	–	Африкийн Хөгжлийн Банк
УТС	–	Улс оронтой хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги
ХҮДХ	–	Хөгжлийн үр дүнгийн хороо
ГХГ	–	Гадаад харилцааны газар
ХБГО	–	Хөгжиж буй гишүүн орон
ЕСБХБ	–	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
БОНУ	–	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
ЕХОБ	–	Европын Хөрөнгө Оруулалтын Банк
СГХАХБХ	–	Санал гомдол хүлээн авах хараат бус хороо
АХХБ	–	Америк Дундын Хөгжлийн Банк
ХБҮГ	–	Хараат бус үнэлгээний газар
БОАШҮ	–	Байгаль орчны анхан шатны үнэлгээ
ОСК	–	Олон Улсын Санхүүгийн Корпораци
УИТТ	–	Уугуул иргэдийн тухай төлөвлөгөө
ЯНАШШ	–	ядуурал, нийгмийн анхан шатны шинжилгээ
ОТХОБДА	–	Олон талт хөрөнгө оруулалтын батлан даалтын агентлаг
ТББ	–	Төрийн бус байгууллага
ОАИ	–	Авилгын эсрэг ёс зүйн алба
ТМТ	–	Төслийн мэдээллийн тайлан
МНХЗХ	–	Мэдээллийг нийтэд хүргэх зөвлөлдөх хороо
БНХАС	–	Бүс нутгийн хамтын ажиллагааны стратеги
ЕТЗ	–	Ерөнхийлөгчийн тайлан зөвлөмж
ТТ	–	Техникийн туслалцаа

# Нэр томъёоны тайлбар

Нөлөөлөлд өртсөн иргэд	– Азийн Хөгжлийн Банкны (АХБ) туслалцаатай хэрэгжиж буй төслийн нөлөөлөлд эерэг эсвэл сөрөг байдлаар өртсөн байх боломжтой иргэд
Зөвлөл	– өөрөөр тусгаагүй бол АХБ-ны Захирлуудын зөвлөлийг хэлнэ
Зээлдэгч	– Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх төслийн хувьд АХБ-ны туслалцааг авч буй байгууллагыг хэлнэ
Харилцагч	– Засгийн газартай бус хэрэгжүүлэх төслийн хувьд АХБ-наас зээл, батлан даалт эсвэл хөрөнгө оруулалт авч буй зээлдэгч, батлан даалт гаргуулагч, сангийн менежер, хөрөнгө оруулалт хүлээн авагч буюу ижил төстэй аж ахуйн нэгжийг хэлнэ
Дуусгавар болох	– баримт бичгийн хувьд уг баримт бичгийг боловсруулах үүрэгтэй АХБ-ны газрын шаардлагыг хангах хүртэл болон хангах үе шатыг оролцуулан боловсруулахыг хэлнэ
Эцсийн тайлан	– (i) АХБ-нд эцсийн тайлан хэмээн албан ёсоор хүлээлгэж өгсөн, (ii) АХБ-ны туслалцаатай хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг бэлтгэх зорилгоор ашиглагдахад шаардлага хангахуйц хэмээн АХБ үзсэн, (iii) цаашид ямар нэг засвар өөрчлөлт хийх шаардлагагүй баримт бичиг
Засгийн газрын бус хүрээн дэх төсөл	– (i) гишүүн орон эсвэл засгийн газар баталгаа гаргаагүй эсвэл (ii) баталгаа гаргагч нь гэрээг үл биелүүлэх тохиолдолд АХБ болон холбогдох гишүүн орны хоорондох аливаа зээл эсвэл баталгааг хурдасгах, түр зогсоох, эсвэл цуцлах эрхийг АХБ-нд олгохгүй нөхцөлтэйгөөр гишүүн орон эсвэл засгийн газраар баталгаа гаргасан ямарваа нэг зээл, баталгаа эсвэл өөрийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл

Засгийн газрын  
төсөл

- (i) гишүүн оронд олгосон эсвэл (ii) гишүүн орон баталгаа гаргасан зээл, буцалтгүй тусламж эсвэл санхүүжилтийн бусад хэрэгслээр санхүүжсэн аливаа төсөл.

Дараа

- батлагдах, тараах, дуусгах, нотлох, хэлэлцэх, нийтлэн гаргах, хүлээж авах эсвэл хүлээлгэн өгсний “дараа” гэдэг нь батлагдах, тараах, дуусгах, нотлох, хэлэлцэх, нийтлэн гаргах, хүлээж авах эсвэл хүлээлгэн өгсөн өдрөөс хойш боломжийг харгалзан аль болох хурдан бөгөөд 2 долоо хоногоос хэтрэлгүй (хуанлигийн 14 хоног) гэсэн утгатай



# Хянан шалгасан хүмүүс

## Удирдах хохоо

Р. М. Наг, Удирдах хорооны дарга, Ерөнхий дарга  
Р. Л. Т. Даусон, Ерөнхий нарийн бичгийн дарга,  
Нарийн бичгийн даргын алба  
Ж. Х. Ховланд, Ерөнхий консул, Ерөнхий консулын  
алба  
К. Сакай, Захирал, Стратеги бодлогын газар  
П. С. Эркига, Захирал, Хувийн хэвшлийн үйл  
ажиллагааны газар  
Ж. Миранда, Захирал, Төв болон баруун Азийн газар  
Ш. Яао, Захирал, Бүс нутаг, тогтвортой хөгжлийн газар  
А. Квон, Ерөнхий захирал, Гадаад харилцааны газар

## Хянан шалгасан

### Дарга Зөвлөх

А. Квон, Ерөнхий захирал, Гадаад харилцааны газар  
С. Хо, Гадаад харилцаа хариуцсан тэргүүлэх  
мэргэжилтэн, ГХГ

### Багийн ахлагч

Д. Рош, Харилцааны мэргэжилтэн (Мэдээллийг ил  
гаргах), ГХГ

### Багийн гишүүд

Л. Т. Назарбекова, Ахлах консул, ЕКА  
К. Малкини, Ахлах консул, ЕКА  
С. Хуупэр, Олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн,  
ГХГ  
Н. А. С. Виллалуз, Олон нийттэй харилцах ажилтан  
(Мэдээллийг ил гаргах), ГХГ  
Р. П. С. Маманонг, Олон нийттэй харилцах зохицуулагч  
(Мэдээллийг ил гаргах), ГХГ

**А**зийн Хөгжлийн Банкны (АХБ) Олон нийттэй харилцах бодлого нь энэ байгууллагын хүрч үйлчилдэг хүмүүсийн өмнө хариуцан тайлагнах, мэдээлэл ил тод байх хүчин чармайлтыг заан чиглүүлэх үүрэгтэй өөрчлөн хувьсах баримт бичиг юм. Бодлого нь ил тод байдал, хариуцан тайлагнах нь хөгжлийн үр нөлөөнд хүрэхэд амин чухал гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Харилцагч талуудынхаа хэрэгцээ шаардлагыг АХБ мэдэхгүйгээр, мөн нөгөө талдаа харилцагч талууд АХБ-ны бүс нутагт гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг ойлгон дэмжихгүйгээр ядуурлаас ангид Ази Номхон далайн бүс нутаг гэсэн алсын хараандаа хүрэх боломжгүй билээ.

2005 онд баталсан Олон нийттэй харилцах бодлого нь мэдээллийг олон нийтэд ил гаргах болон гадаад харилцааны асуудлыг хамарсан төдийгүй АХБ-ны гишүүн орнууд, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаач нар, хэвлэл мэдээлэл болон АХБ-ны үйл ажиллагааны нөлөөлөлд орж болзошгүй хүмүүст мэдээлэл өгөх, тэдэнтэй харьцахад чиглүүлдэг цогц баримт бичиг болсон. АХБ-ны институцийн засаглалын нэг хэсэг болох уг бодлого нь хүмүүс АХБ-ны үйл ажиллагааны талаар мэдээлэл хайх, авах, татах эрхийг хүлээн зөвшөөрдөг. Мөн үүнээс гадна ил тод байдал, хариуцан тайлагнах, эцэст нь АХБ-ны хөгжилд оруулж буй үр нөлөөг сайжруулахад олон нийттэй харилцах харилцаа нэн чухал ач холбогдолтой.

**2005 оны бодлогыг эргэн хянах.** 2005 оны бодлогын дагуу уг бодлого хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараа эргэн хянана

хэмээн заасан байна. Үүний дагуу АХБ 2010 оны 2 дугаар сард бодлогын үр дүнг үнэлэх, цаашид шаардлагатай шинэчлэл засварыг санал болгох ажлыг эхэлсэн. Уг үйл явцад сонирхсон хувь хүмүүс, байгууллагууд оролцсон. Зөвлөлдөх явцын эхний төслийг 2010 оны 6, 11 дүгээр саруудад ил гаргасан. Ази Номхон далайн бүс нутаг дахь болон бүс нутгийн бус АХБ-ны хэд хэдэн гишүүн оронд олон талт харилцагч талуудтай өргөн хүрээний яриа хэлэлцээр явуулсан. АХБ мөн өөрийн гүйцэтгэл болон харилцаа холбооны талаар бусад талуудын санал бодлыг авахаар олон улсын хэмжээний хоёр судалгааг авсан. Энэхүү баримт бичигт гадна, дотроос хүлээж авсан санал болон судалгааны ололтоос оруулсан.

**2005 оны бодлогын туршлага.** Олон нийттэй харилцах бодлогыг 2005 оны 4 дүгээр сард батлах үед уг бодлого нь олон талт санхүүгийн бусад байгууллагуудын тэргүүн эгнээнд буюу дэвшилтэт хэмээн тооцогдож байв. Энэ цаг үеэс хойш АХБ олон нийттэй харилцах үйл ажиллагаандаа томоохон ахиц дэвшил гаргасан байна. Мэдээллийг олон нийтэд ил гаргах нь АХБ-ны бүх төслүүдийн хувьд заавал хийгдэх ёстой үйл ажиллагааны нэг хэсэг гэсэн цоо шинэ ухагдахууныг АХБ-ны дотор нэвтрүүлсэн. Нэг дэлхий сангаас гаргадаг 2007 оны Хариуцан тайлагнах байдлын олон улсын тайланд АХБ ил тод байдлын хувьд 100% гүйцэтгэлтэй гэсэн оноо авсан. Уг бодлогыг дэмждэг АХБ-ны гадаад харилцааны бодлого нь АХБ-ны нэр хүндийг өргөх, үйл ажиллагааны талаар мэдээлэл хуваалцах илүү идэвх санаачлагатай арга барилтай болоход түлхэц өгсөн. Томоохон олон

улсын хурал зөвлөлгөөний үеэр АХБ-ны Удирдлага болон албан хаагчид оролцож, илтгэл тавьж байгаа нь АХБ-ны нүүр царайг хэвлэл мэдээллийн тэргүүлэх хэрэгслүүдээр өргөсөн. Үүний дээр, 2005 оноос хойш АХБ-ны цахим хуудсанд тавигдсан баримт бичгүүдийн хэмжээ 145%-р нэмэгдсэн. Гаднаас ирсэн 6000 гаруй мэдээлэл авах хүсэлтээс АХБ 95 %-д нь тухайн мэдээллийг олгосон байна.

**Өөрчлөгдөж буй нөхцөл байдал.** АХБ мэдээллийг ил гарган мэдээлэх тал дээр өдгөө ихээхэн ахиц дэвшил гаргасан хэдий ч, цаашид ил тод байдлыг илүү ихээр бий болгох үүрэг амлалт авсан. Олон нийтийн байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлсэн ил тод байдлыг хөгжүүлэх ажил нийтийн хүлээлтийг дээшлүүлсэн. Сүүлийн үед олон талт хөгжлийн бусад банкууд ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор мэдээллийг олон нийтэд хүргэх салбарт шинэ бодлого боловсруулсан эсвэл боловсруулах ажлыг эхлүүлээд байна. АХБ нь мэдээллийг олон нийтэд ил гарган мэдээлэх салбарт олон талаараа тэргүүн эгнээнд явж байсан хэдий ч зарим тал дээр ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын түвшинд хүрээгүй бөгөөд тэдний түвшинд дүйж очих шаардлагатай байгаа юм. Нөгөөтэйгүүр, олон нийтэд ил болгож байгаа мэдээлэл холбогдох хүмүүстээ хүрч байгаа эсэхийг баталгаажуулахаар АХБ хүчин чармайлтаа нэмэгдүүлэх хэрэгтэй. Сошиал сүлжээ болон гар утасны аппликэшнууд нь зорилтот хүмүүстээ хүрэх шинэ боломжуудыг АХБ-нд нээж өгч байна. Үүний зэрэгцээ техник технологийг ашиглах боломжгүй хүмүүсийн тоо их байгаа учир харилцаа холбооны илүү уламжлалт арга хэрэгсэл чухал хэвээр байгаа гэдгийг АХБ хүлээн зөвшөөрч байгаа. 2008 онд батлагдсан АХБ-ны урт хугацааны стратегийн хүрээ болох “Стратеги 2020” баримт бичиг нь хариуцан тайлагнах, оролцоо болон ил тод байдал нь АХБ-ны үйл ажиллагаанд чухал болохыг нотолж байна.

**Ерөнхий чиглэл болон хэрэгжилт баталгаажсан.** Олон нийттэй харилцах бодлогыг эргэн хянах ажлын үр дүнд уг бодлого нь үндсэндээ зөв зүйтэй бөгөөд сайн хэрэгжиж ирсэн хэмээн тодорхойлжээ. Ийм учраас бодлогын гол цөм өөрчлөгдөхгүй хэвээр үлдэнэ.

**Бодлогод орох өөрчлөлтүүд.** АХБ-ийг шилдэг туршлагуудын тэргүүн эгнээнд байлгахын тулд таван салбарт өөрчлөлт хийх шаардлагатай байгаа хэмээн хяналтын ажлын хэсгээс тодорхойлсон. Гол өөрчлөлтүүд нь:

- (i) **Санал гомдол хүлээн авах хараат бус хороог нэмсэн.** Няцаасан хүсэлтүүдийг авч хэлэлцэх байгууллага доторх санал гомдлын механизм болох Мэдээллийг олон нийтэд ил гаргах асуудлыг хариуцсан зөвлөх хорооноос гадна санал гомдолтой холбогдолтой үйл явц, итгэлцлийг сайжруулах үйл явцыг дэмжих Санал гомдол хүлээн авах хараат бус хороог байгуулна.
- (ii) **Олон нийттэй харилцах бодлогын доор зохицуулагдахгүй тохиолдлуудыг тодорхой болгосон.** Мэдээллийг олон нийтэд ил гарган мэдээлэх бодлогын доор зохицуулагдахгүй онцгой асуудлуудын жагсаалтыг тодорхой болгосон. Олон нийтэд ил болгохгүй мэдээллийн 7 төрлийг тодорхойлсон ба эдгээрийг тодотгох зорилгоор гарчиг өгөв. Мэдээллийг олон нийтэд ил болгохгүй байснаар хамгаалж байгаа зарим ашиг сонирхлуудад учирч болзошгүй хохирлыг тодорхойлох замаар бодлогод хамаарахгүй онцгой тохиолдлуудын хүрээг нарийн тогтоосон.
- (iii) **Захирлуудын зөвлөлийн (Зөвлөл) шийдвэр гаргах үйл ажиллагаа илүү нээлттэй болсон.** Захирлуудын зөвлөлийн баримт бичгүүдийн дийлэнхийг Зөвлөл болон олон нийтэд

нэгэн зэрэг ил гаргана. Үүнд Засгийн газрын төслүүдийн зээлийн саналууд, бүс нутгийн хамтын ажиллагааны стратегийн эцсийн саналууд, улс оронтой хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегиуд (холбогдох гишүүн орон баримт бичгийг ийнхүү эрт шатанд олон нийтэд ил гаргахыг зөвшөөрсөн тохиолдолд) болон олон нийттэй зөвшилцөж дууссан бодлого, стратегийн баримт бичгүүдийн саналууд зэрэг багтана. Ингэснээр холбогдох талууд АХБ-ны шийдвэр гаргах үйл ажиллагаанд илүү ихээр оролцох боломжтой болох юм. Зөвлөлийн хурлын үгчлэн буулгасан протокол мөн энэхүү бодлогоор зохицуулагдахгүй тохиолдлуудыг оруулаагүй эсвэл тэдгээрийг дурьдаагүй бол 10 жилийн дараа олон нийтэд нээлттэй болно.

- (iv) **Олон нийттэй харилцах арга барил шинэчлэгдсэн.** Бодлогыг дэмжих зорилгоор 2005 оны бодлогод тусгагдсан гадаад харилцааны стратегийг олон нийттэй харилцах ажилд төвлөрүүлэх замаар илүү оновчтой болгосон. Ази Номхон далайн бүс нутгийн хувьсан өөрчлөгдөж буй хөгжлийн хэрэгцээтэй уялдан АХБ-ны олон нийттэй харилцах арга барилд харилцаа холбоогоо эрчимжүүлэх шаардлагыг онцлон авч үзсэн байна. Шинэ арга барил нь АХБ-ны олон нийттэй харилцах харилцаа илүү үр дүнтэй бөгөөд Стратеги 2020-той бүрэн дүүрэн уялдсан байдлыг баталгаажуулна. АХБ нь мөн холбогдох талуудын хүсэн хүлээлт өөрчлөгдөж байгааг харгалзан ажиллах юм. Олон нийттэй харилцах арга барил нь тодорхой бүлгүүдийн хэрэгцээ шаардлагад илүү сайн нийцсэн байна. Олон нийттэй харилцах болон мэдээлэл хуваалцах ажлыг АХБ-ны

дэмлэгтэйгээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн нэг хэсэг болгон оруулснаар төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон сонирхлоо илэрхийлсэн бусад холбогдох талуудтай илүү бат бэх, нягт холбоо харилцаатай болно. Үүний зэрэгцээ, мэдлэгэд суурилсан эдийн засгийн хөгжлийг бүс нутагт дэмжих зорилгоор АХБ өөрийн гаргасан мэдлэгийн бүтээгдэхүүнүүдээ цахим болон биет байдлаар тараах ажлыг нэмэгдүүлнэ.

- (v) **Бусад өөрчлөлтүүд.** Дээр дурьдсанаас гадна хэлний тодруулга, шинэчлэлүүд, АХБ-ны шинэчилсэн бизнесийн үйл ажиллагаатай уялдуулах, онцгой тохиолдлуудад мэдээллийг ил гаргахгүй байх АХБ-ны тусгай эрх болон АХБ-ны төслүүдийг улс орнууд дахь холбогдох талууд илүү сайн ойлгоход дөхөм болох зорилгоор тухайн улс орны хэл рүү төслийн мэдээллийн хуудсыг орчуулах гэх зэргээр мэдээллийг илүү хүртээмжтэй болгох, аудит хийгдсэн төслийн дансыг ил болгох, байгууллагын удирдлага болон Зөвлөлийн гишүүдийн суурь цалинг ил гаргах зэрэг өөрчлөлтүүд багтаж байгаа болно

**Олон нийттэй харилцах бодлого.** Бодлогын зорилго нь холбогдох талуудын итгэлцэл болон АХБ-ны үйл ажиллагаанд оролцох чадварыг сайжруулах замаар АХБ-ны үйл ажиллагааны хөгжлийн үр нөлөөг дээшлүүлэхэд оршино. Бодлогын суурь зарчмууд бол:

- (i) **Мэдээллийг ил болгох ажлыг идэвх санаачлагатайгаар явуулах.** АХБ нь өөрийн мэдлэг, хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээлэл болон санал бодлыг холбогдох талууд болон олон нийттэй хуваалцах ажлыг идэвх санаачлагатай хийх болно. АХБ-ны цахим хуудас нь үүнийг хэрэгжүүлэх

гол хэрэгсэл байх бөгөөд хэрэгцээтэй тохиолдолд мэдээллийг мөн бусад арга хэрэгслээр дамжуулан ил болгож болно. Мэдээллийг идэвх санаачлагатайгаар ил болгохдоо тодорхойлсон цагийн хуваарийн дагуу АХБ-ны шийдвэр гаргах ажиллагаанд холбогдох талуудын оролцоог хангах юм. АХБ хувь хүмүүсийн хүсэлтийн дагуу мөн мэдээллийг ил гаргана. Энэхүү бодлогын бусад зүйл заалтаар хязгаарлагдаагүй бол Захирлуудын зөвлөлд танилцуулсан мэдээллийг Зөвлөлд өргөн барьсантай нэгэн зэрэг АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Захирлуудын зөвлөлийн хэлэлцэн шийдвэрлэх баримт бичгийн ихэнхийг АХБ-ны цахим хуудсанд Зөвлөлийг батлахаас өмнө тавигдах юм. Бусад баримт бичгүүдийг Зөвлөлийг баталсны дараа АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

(ii) **Мэдээллийг ил гаргахыг илүүд үзэх.** Олон нийттэй харилцах бодлогын дагуу мэдээллийг ил гаргахыг илүүд үзнэ. Ийм учраас АХБ-ны гаргаж байгаа эсвэл гаргах шаардлагатай байгаа бүх баримт бичгийг бодлогод хамаарахгүй онцгой тохиолдлуудаас бусад үед олон нийтэд ил гарган мэдээлж болно.

(iii) **Санаа болон мэдээ мэдээллийг авах, хуваалцах эрх.** АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа үйл ажиллагааны тухай мэдээ мэдээлэл, санааг иргэд эрэн хайх, хүлээж авах болон хуваалцах эрхийг АХБ хүлээн зөвшөөрдөг. АХБ мэдээллийг цаг тухайд нь, ойлгомжтой болон зохимжтой байдлаар хүргэнэ. Төслийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад АХБ-ны үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад холбогдох хүмүүс болох эмэгтэйчүүд, ядуу иргэд зэрэг эмзэг бүлгүүд ач холбогдолтой санал бодлоо оруулах боломж олгохуйц эрт шатанд мэдээллийг олгоно.

АХБ мэдээллийг олон нийтэд ил гаргахдаа шилж сонгохгүй. Бодлогын дагуу олон нийтэд ил гарч байгаа мэдээллийг иргэд авахдаа тэгш эрхтэй байна.

(iv) **Улс орон удирдан залах.** Хөгжиж буй гишүүн орнуудад АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа үйл ажиллагаанд тухайн улс орон эзэн нь байж, өөрөө удирдан явуулах нь чухал гэдгийг АХБ хүлээн зөвшөөрдөг. Иймээс тодорхой баримт бичгүүдийг ил гаргахын өмнө тэдгээрийн агуулга болон ил гаргах цаг хугацааны талаарх хөгжиж буй гишүүн орны санал бодлыг бодолцож үзнэ.

(v) **Мэдээллийг олон нийтэд ил гаргахгүй байх онцгой тохиолдлууд хязгаартай.** Мэдээллийг олон нийтэд ил гаргахдаа тодорхой зааг хязгаар бүхий онцгой тохиолдлуудыг бодолцон үздэг. АХБ-ны гаргаж байгаа эсвэл гаргах шаардлагатай байгаа бүх баримт бичгийг бодлогын дагуу ил гаргахгүй байх онцгой тохиолдлуудаас бусад үед олон нийтэд ил гарган мэдээлж болно. Мэдээллийг ил гаргахад учирч болзошгүй гарз хохирлоос тухайн мэдээллийг ил гаргах олон нийтийн ашиг сонирхол давамгайл байна хэмээн үзвэл эдгээр онцгой тохиолдлуудыг хэрэгсэхгүй байх эрх АХБ-нд байдаг. Үүнтэй ижил, энгийн үед олон нийтэд ил гаргадаг мэдээллийг ил гаргаснаас болж учирах эсвэл учирч болзошгүй гарз хохирол тухайн мэдээллийг ил гаргаснаас гарах үр ашгаас давамгайл байна хэмээн үзсэн онцгой тохиолдлуудад тухайн мэдээллийг ил гаргахгүй байх эрх мөн АХБ-нд байдаг.

(vi) **Гомдол гаргах эрх.** Иргэдийн мэдээлэл авах хүсэлтийг АХБ няцаахдаа энэхүү бодлогыг зөрчсөн хэмээн үзвэл тухайн иргэн гомдлоо хоёр үе шаттайгаар гаргах эрхтэй хэмээн бодлогоор

хүлээн зөвшөөрсөн. Гомдол гаргах ажиллагааг илүү итгэмжтэй болгох зорилгоор хоёр дахь үе шатыг АХБ-наас гадна хараат бус болгосон. Авахыг хүссэн мэдээллийг хязгаарладаг онцгой тохиолдлуудыг үл хэрэгсэхийн тулд гомдлыг мэдээллийн зөвлөлдөх хороотой хамтран гаргаж мөн болно.

Бодлогыг хэрэгжүүлэх дотоодын арга хэрэгсэл өөрчлөгдөхгүй хэвээр үлдэх юм. Гэсэн хэдий ч олон нийттэй харилцах шинэчилэн сайжруулсан үйл ажиллагаа болон хараат бус гомдлын хороог дэмжихийн тулд нэмэлт нөөц гаргах шаардлагатай байна. ■

# 1

## Олон нийттэй харилцах бодлого 2011

# Оршил

1. Энэхүү баримт бичиг нь Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны 2005 онд баталсан Олон нийттэй харилцах бодлогын<sup>1</sup> шинэчилсэн хувилбар юм. 2011 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлагдаж, 2012 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн энэхүү баримтанд тусгагдсан бодлого нь 2005 онд батлагдсан бодлогын заалтуудыг хүчингүй болгон орлож байгаа болно.

2. Ил тод болон идэвх санаачлагатайгаар олон нийттэй харилцах нь одоогийн бодлогын тулгуур зарчим юм. Мэдээлэл болон мэдээллийг олон нийтэд ил гаргах талаарх хоёр тусдаа бодлоготой байсныг 2005 оны энэхүү бодлогод нэгтгэснээрээ АХБ-ны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд илүү бат бэх, төвлөрсөн арга барилыг нэвтрүүлсэн. Үүний зэрэгцээ энэхүү бодлого нь АХБ-ны хөгжлийн үр нөлөөг дэмжихэд мэдээллийг олон нийтэд ил гаргах болон гадаад харилцааны үүргийн талаарх АХБ-ны байр сууринд гарсан томоохон өөрчлөлтийг илэрхийлж байсан юм. 2005 оны бодлогод

тусгагдсаны дагуу 2010 онд бүхэл бодлогыг эргэн хянах ажил эхэлсэн.

3. Эргэн хянах ажлыг Ерөнхий удирдах захирлын даргалсан Удирдах хороо чиглүүлэн авч явсан. АХБ нь бодлогыг хэрэгжүүлэх явцад хуримтлагдсан туршлага болон бодлогыг хэрхэн сайжруулах талаар ажилчдынхаа санал бодлыг асуусан. Мөн АХБ нь бодлого болон түүний хэрэгжилтийн талаарх санал шүүмж, сайжруулах зөвлөмжийг гадны холбогдох хувь хүн, байгууллагаас асуусан. Санал шүүмжийг бичгээр авахаас гадна мөн нөлөөлөлд өртсөн хүмүүс болон бусад өргөн хүрээний сонирхсон хүмүүсийн саналыг авах зорилгоор 12 гишүүн орнууддаа 20 гаруй зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан. Эдгээр уулзалтуудад нийт 500 гаруй хүмүүс оролцсон (Байгууллагаас гадуур зохион байгуулсан зөвлөлдөх үйл ажиллагааг Хавсралт 1-ээр тайлбарласан). Энэхүү баримт бичигт тухайн үед хүлээн авсан санал шүүмжийг тусгасан болно. ■

<sup>1</sup> АХБ. 2005. Азийн Хөгжлийн Банкны Олон нийттэй харилцах бодлого: Мэдээллийг олон нийтэд ил гаргах ба солилцох. Манила.

# АХБ-ны олон нийттэй харилцах туршлага

## 2

Олон нийттэй харилцах бодлого 2011

### Бодлогын зорилто

4. АХБ нь хүрээмжтэй эдийн засгийн өсөлт, байгаль орчинд ээлтэй өсөлт болон бүс нутгийн интеграцлалыг дэмжих замаар ядуурлыг бууруулах зорилготой ажилладаг. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд АХБ нь хөгжлийг хөхиүлэн дэмжих төрөл бүрийн төсөл болон бусад үйл ажиллагааг санхүүжүүлдэг. Төслүүд эрэлт хэрэгцээнд нийцэж, үр нөлөөтэй байхын тулд АХБ нь зээлдэгч орнууд болон харилцагч нар, түншүүд болон бусад холбогдох байгууллагуудын үзэл бодлыг сонсох ёстой. АХБ болон харилцагч байгууллагуудын хооронд мэдээлэл хоёр чиглэлд хөрвөж байх нь бат бөх түншлэлийн үндэс суурь болсон харилцан ойлголцол ба итгэлцлийг бий болгоход нэн чухал үүрэгтэй билээ. Төслүүд болон үйл ажиллагаандаа ил тод байдлыг бий болгох нь харилцагч талуудынхаа итгэлийг олж авахад чухал бөгөөд ингэснээрээ төсөл амжилттай хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Үүнээс гадна ямар ч байгууллагын хувьд сайн засаглалын томоохон зарчим бол хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа хариуцан тайлагнах чадвартай байх явдал юм. Ил тод байдал нь хариуцан тайлагнахын урьдчилсан нөхцөл болно.

5. Олон нийттэй харилцах бодлогын ерөнхий зорилго нь харилцагч талуудын АХБ-нд итгэх итгэл, хамтран ажиллах чадварыг дээшлүүлэхэд оршино. АХБ-ны үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг

эрэн хайх, хүлээж авах болон хуваалцах эрхийг энэхүү бодлого хүлээн зөвшөөрдөг юм. Мөн мэдлэг хуваалцах явдлыг хөхиүлэн дэмжиж, нөлөөлөлд өртсөн иргэдтэй харилцах буюу оролцоонд суурилсан хөгжлийг бий болгодог. Мэдээллийг олон нийтэд ил гаргахгүй байх бодит шалтгаан байхгүй тохиолдолд бодлогын дагуу мэдээллийг ил гарган мэдээлэхийг илүүд үзнэ. Мөн бодлогын дагуу АХБ нь байгууллагын институцийн, санхүүгийн болон төсөлтэй холбоотой мэдээллийг цахим хуудаснаа тодорхой цагийн хуваарийн дагуу ил гарган мэдээлэх үүргийг хүлээж, хариу санал гомдол хүлээн авах арга хэрэгслийг бий болгодог. АХБ-ны үйл ажиллагааны хөгжлийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор олон нийттэй харилцах ажиллагаагаа сайжруулах болон гишүүн орнууд дахь шийдвэр гаргагч, оюун санааны удирдагч нартай харилцаагаа хөгжүүлэх замаар АХБ болон түүний үйл ажиллагааны тухай олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлдэг.

6. АХБ-ны авч хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүд нь АХБ-ны энэхүү бодлого болон бодлогын зорилгыг биелүүлэх үүрэг амлалтыг бататгаж байдаг. Стратеги 2020 баримт бичиг нь АХБ-ны үйл ажиллагаанд хариуцан тайлагнах чавдар, оролцоо болон ил тод байдал чухал болохыг хүлээн зөвшөөрдөг.<sup>2</sup> Ил тод байдлыг сайжруулах нь мөн Тусламжийн үр нөлөөний тухай Парисын тунхаглалын зорилгууд дотор чухал байр суурь эзэлдэг юм.<sup>3</sup> Тусламжийн талаарх

<sup>2</sup> АХБ. 2008. Стратеги 2020: Азийн Хөгжлийн Банкны урт хугацааны стратеги, 2008 – 2020. Манила.

<sup>3</sup> 2005 оны 3 дугаар сарын 2-ны өдөр АХБ болон түүний гишүүн 19 хөгжиж буй улс орныг оролцуулан 100 гаруй улс орон, хөгжлийн байгууллагууд баталсан.



мэдээлэлд хүрэх боломжийг хурдасгах олон талт санаачилга болох Олон улсын тусламжийн ил тод байдлын санаачилгад гарын үсэг зурж нэгдсэнээрээ АХБ нь ядуурлыг бууруулах үйл ажиллагаагаа илүү үр нөлөөтэй явуулахын тулд тусламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тогтмол, тогтсон цаг хугацаанд олон нийтэд ил гарган мэдээлэх үүрэг амлалтаа дахин бататгасан билээ.

## Бодлогын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ

7. АХБ нь 2005 онд баталсан Олон нийттэй харилцах бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж байсан ба нийт 4 үнэлгээний тайланг жил бүр гаргав.<sup>4</sup> Эдгээр дэлгэрэнгүй үнэлгээгээр АХБ нь бодлогын заалтуудыг сайн хэрэгжүүлсэн ба ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаагаа дээшлүүлж, харилцагч талууддаа илүү их мэдээллийг авах боломжийг нээж өгсөн хэмээн тусгав. Зөвлөлдөх явцад оролцсон харилцагч байгууллагуудын ихэнх нь бодлогыг нааштай хүлээж авсан бөгөөд АХБ-ны албан хаагчид мөн бодлогын талаар сайн ойлголттой болсон байлаа.

8. АХБ-ны институцийн болон төсөл хөтөлбөртэй холбоотой мэдээлэл илүү нээлттэй, идэвх санаачлагатай болон хүсэлтийн дагуу харилцагч талууд болон олон нийтэд нээлттэй болсон хэмээн ерөнхийд нь дүгнэжээ. Идэвх санаачлагатай гадаад харилцаа болон мэдээллийг олон нийтэд ил гарган мэдээлэх хоёр нь харилцан нэг нэгнийгээ дэмждэг. Бодлогыг баталснаараа АХБ нь өөрийн талаарх мэдлэг ойлголт болон АХБ-нд итгэх итгэлийг нэмэгдүүлэх тал дээр томоохон алхам хийж, засгийн газрын хүрээний болон засгийн газрын бус хүрээний үйл ажиллагааны

талаарх олон нийтэд нээлттэй баримт бичгүүдийн хязгаарыг тэлсэн. Олон нийттэй харилцах болон мэдээллийг ил болгох нь ижил төстэй шинж чанартай боловч хоёр тусдаа ухагдахуун бөгөөд АХБ-ны хөгжлийн тухай мэдлэг мэдээллийг зорилтот бүлгүүдэд хүргэхэд хоёул хувь нэмрээ оруулж, ингэснээрээ АХБ-ны хөгжлийн үр нөлөө болон АХБ-нд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлсэн.

9. АХБ нь ерөнхийдөө мэдээллийг олон нийтэд ил гаргахыг илүүд үздэг боллоо. Мэдээллийг ил гарган цаг тухайд нь мэдээлэх болон гаднаас ирж буй хүсэлтэд хариу өгөх байдал сайжирсаар ирсэн. Нэг дэлхий нийгэмлэгээс 2007 онд гаргасан “Дэлхий нийтийн хариуцлагын тайлан”-д АХБ хариуцан тайлагнах сайн туршлагын үзүүлэлтээр 100 хувь гэсэн оноо авсан.<sup>5</sup>

10. АХБ-ны цахим хуудсан дээр байршуулагдах ёстой ихэнх мэдээлэл тавигдсан байгаа. 2005 оны 9 дүгээр сараас 2010 оны 12 дугаар сарын хугацаанд АХБ-ны цахим хуудсан дээр тавигдсан баримт бичгүүдийн тоо 145 хувиар өссөн. Цахим хуудсан дээр тавигдсан мэдээллийн олон нийтэд хүрэх байдал мөн нэмэгдсэн. Үүний зэрэгцээ АХБ нь мэдээлэл, баримт бичгийг хүссэн 6000 гаруй гадны хүсэлтийг бүртгэн боловсруулсан ба эдгээрийн 95 хувьд нь мэдээллийг хүсэлтийн дагуу олгожээ. Гаднаас ирсэн хүсэлтийн талаас дээш хувь нь төслийн холбогдолтой мэдээлэл байв. Үлдсэн хүсэлтийн ихэнхийг бизнесийн боломжийн талаарх мэдээллийн хүсэлт эзэлж байсан. Төрийн бус байгууллагууд (ТББ)-аас ирсэн хамтран ажиллах болон санхүүжилт авах хүсэлт нийт хүсэлтийн ойролцоогоор 7 хувийг бүрдүүлж байв. Мэдээллийг хүсэлтийн дагуу олгоогүй 5 хувьд АХБ-ны бондын асуудлын талаар тавьсан асуулт хамгийн том бүлэг болж

<sup>4</sup> АХБ. Олон нийттэй харилцах бодлогын хэрэгжилтийн үнэлгээ. <http://www.adb.org/documents/series/assessment-rcp-implementation>

<sup>5</sup> Нэг дэлхий нийгэмлэг. 2007. Дэлхий нийтийн хариуцлагын тайлан. Лондон.

байсан. АХБ нь 2005 оноос өмнөх олон баримт бичгүүдийг авч хэлэлцэн олон нийтэд ил болгосон. Гэсэн хэдий ч мэдээллийг олон нийтэд ил гаргах бодлогын шаардлагыг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхийн тулд АХБ хүчин чармайлтаа үргэлжлүүлэх хэрэгтэй. Жишээ нь, төслийн талаарх эмхэтгэсэн тайлан мэдээ бүгд АХБ-ны цахим хуудсанд тавигдаагүй эсвэл шаардлагатай тохиолдолд шинэчлэгдээгүй байсан ба уг тайлангийн доторх мэдээ мэдээллийг илүү бүрэн гүйцэд болгох хэрэгтэй юм.

11. Бодлого батлагдсанаас хойш АХБ нь гадаад харилцааны ажлын үр дүнд өөрийн үнэлэмж, ил тод байдлыг дээшлүүлсэн хэмээн гадна дотны хяналтын ажил ерөнхийдөө дүгнэжээ. Үүнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хавьгүй их гарч, илүү анхааралд өртөх болсон явдал, мөн цахим хуудсанд зочлох зочдын статистик мэдээ баталгаажуулж байна. АХБ нь олон нийттэй харилцах үйл ажиллагаа болон олон улсын томоохон хурал цуглаанууд дээрх байгууллагын удирдлага, албан хаагчид илтгэл тавих зэргээр дамжуулан тэргүүлэх хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дээрх өөрийн төрхийг нэлээд өргөсөн. АХБ-ны тухай гадны байгууллага, иргэдийн сэтгэгдэл, ойлголтыг хянан шинжлэхээр гурван жил тутамд олон улсын судалгааг АХБ явуулдаг билээ. 2006 болон 2009 онуудад явуулсан судалгааны дүнд АХБ-тай харилцагч ихэнх байгууллагууд болон бодлого боловсруулагч нар АХБ-ны талаар эерэг сэтгэгдэлтэй бөгөөд АХБ нь Ази Номхон далайн бүс нутгийн хөгжилд том хувь нэмэр оруулж байгаа хэмээн итгэдэг гэдгийг тогтоожээ. АХБ-ийг мөн маш найдвартай, итгэл хүлээсэн, чадвартай гэж хүлээж авдаг гэв. Судалгаанд оролцогчдын ихэнх нь АХБ-ийг олон нийттэй харилцах болон мэдээлэл хүссэн хүсэлтэд хариу өгөх ажлыг сайн гүйцэтгэдэг хэмээн үзэж байсан хэдий ч энэ тал дээр илүү сайжрах боломжтой гэж хариуллаа. Тодруулбал, АХБ-ны мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг харилцагч талууд, тэр дундаа хөгжиж буй гишүүн орнууд (ХБГО)-ын засгийн газруудтай хуваалцах тал дээр

илүү чармайлт гаргаж болохоор байна. Олон нийттэй харилцах бодлогыг эргэн хянах ажлын хүрээнд харилцагч талуудтай хийсэн зөвлөлгөөнүүдээс төслүүдийн олон нийттэй харилцах ажил, тэр дундаа төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй харилцаатай байх, тэдэнтэй мэдээлэл хуваалцах явдлыг мөн сайжруулах шаардлагатай байгааг харуулав.

12. АХБ нь 2005 оноос хойш мэдээллийг олон нийтэд ил гаргах гэсэн энэхүү бодлогын шаардлагыг өөрийн ажилтан, албан хаагчид болон бусад харилцагч байгууллагууд ойлгоход туслахаар олон тооны танилцуулах уулзалт, хурал цуглаан, аяллыг зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагаа нь мэдээллийг олон нийтэд ил болгох бодлогын шаардлагад дэмжлэг үзүүллээ.

13. Мэдээллийг олон нийтэд ил болгох бодлогын дүрэм журмын хэрэгжилтийг дэмжих үүднээс АХБ нь ажлын шинэ орон тоо, байнгын сургалт болон орчуулгын төлөвлөгөө зэрэгт нэмэлт хөрөнгө мөнгө төсөвлөн хуваарилсан. Бодлогыг 12 хэлд орчуулж, өргөн хүрээнд тараан түгээсэн. 2005 оны 7 дугаар сард бодлогын хэрэгжилтийг хянах зорилгоор Олон нийтэд мэдээлэл түгээх хэлтсийг Гадаад харилцааны газар (ГХГ)-ын доор байгуулав. Уг хэлтэс нь мэдээллийг олон нийтэд ил гарган мэдээлэх бодлогын шаардлагыг биелүүлэхэд АХБ-ны албан хаагчдыг хэрэгтэй үйлчилгээ, бүтээгдэхүүн болон хэрэгслээр хангадаг бөгөөд өдгөө мэдээллийг олон нийтэд ил гаргахтай холбогдолтой бүхий л асуудлыг зангидсан АХБ-ны төв хэмээн хүлээн зөвшөөрөгдөөд байна.

14. Олон нийттэй харилцаах ажиллагааг идэвх санаачлагатай явуулдаг болох байгууллагын дотоод орчинг бий болгоход АХБ-ны удирдлага нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. Олон нийттэй харилцах ажлыг илүү сайн гүйцэтгэх АХБ-ны чадавхийг дээшлүүлэхийн тулд Гадаад харилцааны албыг Ерөнхийлөгчид шууд тайлагнадаг

газрын статустай болгон шат ахиулсан. Үүний зэрэгцээ АХБ нь улс орнууд дахь олон нийттэй харилцах ажилд хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг гишүүн орнууд дахь төлөөлөгчийн газруудын чадавхийг дээшлүүлэх зорилгоор гадаад харилцааны үйл ажиллагаанд нэмэлт төсөв хуваарилсан. Гишүүн орнуудад идэвхтэй гадаад харилцааг явуулах зорилгоор 2005 оноос хойш гадаад харилцаа эрхэлсэн ажилтны нийт 8 орон тоог бий болгосон.

15. АХБ-ны удирлагын манлайлал доор уг бодлого нь мэдээллийг олон нийтэд ил гаргах талаарх хандлагыг АХБ даяар өөрчилсөн. Ерөнхийдөө ажилчид ил тод байдлын сайн талуудыг хүлээн зөвшөөрч, мэдээллийг олон нийтэд ил гаргах талаар мэдлэг ойлголттой болсон. Гэхдээ мэдээллийг олон нийтэд ил гаргах журмыг өндөр түвшинд даган мөрдөж байгаа хэдий ч тодорхой цагийн хуваарийг

баримтлан ил болгох зэргээр журмыг бүрэн гүйцэд хэрэгжүүлэх тал дээр илүү их ажил хийгдэх шаардлагатай байна.

16. Ази Номхон далайн бүс нутагт АХБ-ны тухай мэдээ мэдээллийг авах боломжийг сайжруулах зорилгоор АХБ-ны олон нийтийн мэдээллийн төвүүд болон гишүүн орнууд дахь номын сангийн хөтөлбөрийг эргэн харж, тэдгээрийн дүрэм журмыг илүү оновчтой болгожээ. 2009 болон 2010 онуудад зарим гишүүн орнууд дахь номын сангуудыг Азийн хөгжлийн нөөцийн төв болгон өргөжүүлэхийн дээр хэдэн орнуудад олон доноруудын хамтарсан олон нийтийн мэдээллийн төвийг шинээр хамтран байгуулсан. Эдгээр шинэ санаа санаачилгуудыг АХБ-ны мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийн хүртээмжтэй байдал, нээлттэй байдлыг сайжруулах тал дээр оруулсан үр нөлөөгөөр үнэлнэ. ■

# Олон нийттэй харилцах салбар дахь олон улсын шинэ чиг хандлагууд

## 3

Олон нийттэй харилцах бодлого 2011

17. Өнгөрсөн 20–30 жилийн хугацаанд мэдээллийн эрх чөлөөний талаарх дэлхий нийтийн чиг хандлага эрс өөрчлөгдсөн. Мэдээллийн эрх чөлөө нь хүний суурь эрхийн нэг гэдгийг Иргэний болон улс төрийн эрхийн хэлэлцээрт хүлээн зөвшөөрсөн байна. Иргэд ил тод байдлыг илүү ихээр шаардаж, төр болон хувийн хэвшлийн хариуцан тайлагнах өндөр хэм хэмжээг баримталж байгаа. Олон улс орнууд Үндсэн хуулиндаа мэдээллийн эрх чөлөөг тусган оруулжээ. Мэдээллийн эрх чөлөө нь хүрч тэмүүлэх гол зорилго биш харин эдлэх ёстой эрх гэсэн энэхүү хандлага сүүлийн жилүүдэд хүчээ авлаа. Олон орнуудын төр засаг иргэддээ төрийн мэдээллийг авах эрхийг баталгаажуулсан чухал хуулиудыг баталлаа. Ийм төрлийн хуулиудыг өдгөө 80 гаруй улс орон батлаад байна.

18. АХБ Олон нийттэй харилцах бодлогыг баталснаас хойш, харилцаа холбооны салбарын техник технологи хувьсан өөрчлөгдөж иржээ. Сошиал медиа зэрэг шинэ төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээ өссөнөөр илүү их мэдээллийг илүү олон хүмүүст илүү олон арга замаар хүргэх боломжтой болсон. Засгийн газар, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудын хангаж буй мэдээллийн хамрах хүрээ, төрөл зүйл болон хүргэх арга замын талаарх олон нийтийн хүлээлт болон ил тод байдал,

түүнд хүрэх шилдэг арга туршлагуудын талаарх ойлголт өндөрссөн юм. Хөгжлийн хөтөлбөрүүдийн зардал болон үр нөлөөг мөн илүү нарийвчлан судлан шинжих болжээ.

19. Африкийн Хөгжлийн Банк, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, Америк Дундын Хөгжлийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпораци болон Дэлхийн Банк зэрэг ихэнх олон талт хөгжлийн банкууд мэдээллийг олон нийтэд ил гаргах өөрсдийн бодлогыг сүүлийн жилүүдэд эргэн хянасан буюу эргэж хянаж байгаа юм (Хавсралт 2-т бусад олон талт хөгжлийн банкуудын мэдээллийг олон нийтэд ил гаргах ажиллагааны талаарх судалгааг оруулсан. Хавсралт 3-т АХБ-ны 2005 онд батлагдсан бодлого, энэхүү баримт бичигт тусгагдсан шинэчилсэн бодлого болон Дэлхийн Банк, Америк Дундын Хөгжлийн Банкны мэдээллийн бодлогын хүртээмжтэй байдлыг тус тус оруулав). Санал болгогдсон болон батлагдсан шинэ бодлогууд олон ижил төстэй талтай. Тодруулбал, эдгээр бодлогууд нь мэдээллийг олон нийтэд ил гаргахыг илүүд үзэх болон мэдээллийг ил болгохгүй тодорхой тохиолдлуудаас өөр үед мэдээллийг хамгийн ихээр хүртээмжтэй болгох гэсэн зарчмууд дээр суурьлагдсан байна. Мэдээллийг ил гаргах тодорхой дүрэм журам болон гомдол хүлээн авах механизм мөн эдгээр бодлогод багтсан. ■

# 4

Олон нийттэй  
харилцах  
бодлого 2011

## 2005 оны бодлогод оруулахаар санал болгосон шинэчлэлүүд

20. АХБ-ны Олон нийттэй харилцах бодлого нь ач холбогдолтой хэвээр үлдэж, мэдээллийг ил гаргах шилдэг туршлагаудын хувьд бусад олон талт хөгжлийн банкуудтай эн зэрэгцэж байгаа гэдгийг 2005 оны бодлогыг эргэн хянах ажлаар тогтоогдсон юм. Гэсэн хэдий ч 2005 оны бодлогыг илүү бат бэх болгож болох 5 салбарын тодорхойлсон. Эдгээр салбарыг 21–25 дугаар догол мөрүүдэд оруулсан.

21. **Гомдол хүлээн авах хараат бус хороо.** 2005 оны бодлогын дагуу мэдээллийн хүсэлтийг няцаасан хэргүүдийг хянах Мэдээллийг олон нийтэд ил гаргах талаарх зөвлөлдөх хороо (МОНИГЗХ) нэртэй хороо АХБ-ны дотор байгуулагдсан. МОНИГЗХ-нд ердөө таван хэргийг хүргүүлсэн. Гэсэн хэдий ч бодлогыг эргэж хянах үеэр гомдол хүлээн авах хараат бус, гадны байгууллага байхгүй байгааг харилцагч талууд сул тал хэмээн тодорхойлжээ. Шилдэг туршлагаудын тэргүүн эгнээнд үлдэхийн тулд, АХБ нь МОНИГЗХ-ны гаргасан шийдвэрүүдийг хянахаар Санал гомдол хүлээн авах хараат бус хороо (СГХАХБХ)-г байгуулна.

22. **Онцгой тохиолдлуудыг тодорхой болгох.** 2005 оны бодлогод мэдээллийг ил гаргахгүй байх онцгой тохиолдлуудын жагсаалт багтсан байдаг боловч энэхүү жагсаалтын бүтэц тодорхой биш учир ойлгоход бэрхшээлтэй гэсэн санал иржээ. Ийм учраас жагсаалтыг багцлан зохион байгуулж, багц болгонд гарчиг өгсөн. Мэдээллийг ил гаргаснаар зарим онцгой тохиолдлуудаар хамгаалагдсан талуудад учирах хохирлыг тодорхойлох замаар эдгээрийн хүрээг хязгаарласан юм.

23. **Захирлуудын зөвлөлийн баримт бичгийг шийдвэр гаргах явцаас өмнө ил гаргах.** 2005 оны хяналтын ажлын хүрээнд баримт бичгийг холбогдох талуудтай хуваалцах хугацааг илүү сайжруулах шаардлагатай хэмээн дүгнэжээ. Хамгааллын бодлого (2009) зэрэг холбогдох талуудад шууд нөлөөлөл үзүүлэх баримт бичгүүд болон аливаа салбар, сэдэв хамарсан бодлого, стратегиудын төслийг АХБ өөрийн цахим хуудсанд байршуулан, холбогдох талуудын саналыг авах уулзалтуудыг тухайн улс оронд зохион байгуулдаг. Гэсэн хэдий ч Захирлуудын зөвлөлд шийдвэр гаргах явцад танилцуулсан баримт бичгийн төслүүдийг ийм зөвлөлдөх уулзалт хийсний дараа холбогдох талуудад хүртээмжтэй болгодоггүй, харин зөвхөн эцсийн баримт бичгийг Захирлуудын зөвлөлөөр орсны дараа АХБ-ны цахим хуудсанд байршуулдаг байна. Эдгээр бодлого болон стратегиудын бэлтгэл ажилд талуудын оролцоо ямар чухал болохыг тодотгох зорилгоор Олон нийттэй харилцах бодлогын дагуу олон нийттэй зөвшөлцөх үе шатыг дууссан төсөл болон бодлого, стратегийн эцсийн саналыг Захирлуудын зөвлөлд танилцуулахтай нэгэн зэрэг АХБ-ны цахим хуудсанд байршуулдаг. Үүнтэй адил, Засгийн газрын хүрээн дэх зээлийн төслүүдийн санал, Бүс нутгийн хамтын ажиллагааны стратегиуд (БНХАС) болон Улс оронтой хамтран хэрэгжүүлэх стратегиуд (УОХХС)-ыг холбогдох гишүүн орнууд зөвшөөрсөн тохиолдолд Захирлуудын зөвлөлд танилцуулах үетэй нэгэн зэрэг АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

24. **Олон нийттэй харилцах арга барил.** Бодлогыг дэмжих зорилгоор 2005 оны бодлогод тусгагдсан гадаад харилцааны

стратегийг олон нийттэй харилцах ажилд төвлөрүүлэх замаар илүү оновчтой болгосон. Мэдээллийг олон нийтэд ил болгох нь мэдээлэл зорилтот бүлэгтээ хүрнэ гэсэн баталгаа биш юм. 2005 оны Олон нийттэй харилцах бодлогод төрөл бүрийн сонсогчдод мэдээллийг хүргэх арга хэрэгсэл тусгагдсан байсан боловч тэдгээр нь зарим талаараа амжилттай хэрэгжээгүй. Жишээ нь мэдээлэл хуваалцахад зарим тохиолдолд техник технологиос илүүтэйгээр нүүр тулсан амьд харилцаа илүү шаардлагатай байдаг. Гадаад харилцааны стратегийг дэмжихэд юу хэрэгтэй байгаагаас цаашлан уг стратегийг ерөнхийд нь тайлбарлахын оронд стратегийн ерөнхий зорилгуудыг бататгах үүднээс мэдээлэл хуваалцахад илүү практик арга барилыг чухалчлах болжээ. Олон нийттэй харилцах болон мэдээлэл хуваалцах ажлыг АХБ-ны дэмлэгтэйгээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн нэг хэсэг болгон оруулснаар төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон сонирхлоо илэрхийлсэн бусад холбогдох талуудтай илүү бат бэх, нягт холбоо харилцаатай болно. Үүний зэрэгцээ, мэдлэгэд суурилсан эдийн засгийн хөгжлийг бүс нутагт дэмжих зорилгоор АХБ өөрийн

гаргасан мэдлэгийн бүтээгдэхүүнүүдээ цахим болон биет байдлаар түгээх ажлыг нэмэгдүүлнэ. Үүний зэрэгцээ АХБ мэдлэгийн бүтээгдэхүүнээ хуваалцах, Засгийн газар болон бусад гол талуудтай санал солилцох зорилгоор бүс нутаг ба үндэсний хурал чуулган, арга хэмжээ зэрэг өөр арга хэрэгслүүдийг ашиглана.

**25. Илүү их мэдээллийг олон нийтэд ил гаргах.** 2005 оны Олон нийттэй харилцах бодлогын дагуу Захирлуудын зөвлөлийн хурлын үгчлэн буулгасан протоколыг олон нийтэд ил гаргадаггүй байсан бол одоогийн бодлогын дагуу хурлын үгчлэн буулгасан протоколыг энэхүү бодлогод хамаарахгүй онцгой тохиолдлуудыг оруулаагүй эсвэл тэдгээрийг дурьдаагүй бол 10 жилийн дараа хүсэлтийн дагуу олон нийтэд нээлттэй болно (84 дүгээр зүйл). Мөн уг бодлого нь аудит хийгдсэн төслийн данс (62 дугаар зүйл), байгууллагын удирдлага болон Зөвлөлийн гишүүдийн суурь цалин (90 дүгээр зүйл) болон холбогдох улсын хэл рүү хөрвүүлсэн төслийн мэдээллийн тайланг (42 дугаар зүйл) ил гаргахаар заасан байна. ■

# 5

Олон нийттэй  
харилцах  
бодлого 2011

## Олон нийттэй харилцах бодлого

26. Олон нийттэй харилцах бодлогын зорилго нь холбогдох талуудын итгэлцэл болон АХБ-ны үйл ажиллагаанд оролцох чадварыг сайжруулах замаар АХБ-ны үйл ажиллагааны хөгжлийн үр нөлөөг дээшлүүлэхэд оршино. Уг бодлого нь ил тод байдал, хариуцан тайлагнах чавдар болон оролцоог хангасан хөгжлийг хөхиүлэн дэмжиж байгаа бөгөөд АХБ-ны боловсруулсан эсвэл боловсруулбал зохих баримт бичгүүдийг олон нийтэд ил гаргах журмыг багтаана. 27-с 33 дугаар зүйлд уг бодлогын суурь зарчмуудыг тайлбарлав.

27. **Мэдээллийг ил болгох ажлыг идэвх санаачлагатайгаар явуулах.** АХБ нь өөрийн мэдлэг, хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээлэл болон санал бодлыг холбогдох талууд болон олон нийттэй хуваалцах ажлыг идэвх санаачлагатай хийх болно. АХБ-ны цахим хуудас нь үүнийг хэрэгжүүлэх гол хэрэгсэл байх бөгөөд зорилтот хүн эсвэл бүлэг болон мэдээллийг ил гаргах зорилгоос хамааран мэдээллийг мөн бусад арга хэрэгслээр дамжуулан ил болгож болно. Мэдээллийг идэвх санаачлагатайгаар ил болгохдоо тодорхой цагийн хуваарийн дагуу гаргаж, АХБ-ны шийдвэр гаргах ажиллагаанд холбогдох талуудын оролцоог хангах нь чухал юм. АХБ хувь хүмүүсийн хүсэлтийн дагуу мөн мэдээллийг ил гаргана.

28. Энэхүү бодлогын бусад зүйл заалтаар хязгаарлагдаагүй бол Захирлуудын зөвлөлд танилцуулсан мэдээллийг Зөвлөлд өргөн барьсантай нэгэн зэрэг АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Захирлуудын зөвлөлийн хэлэлцэн шийдвэрлэх баримт бичгийн ихэнхийг АХБ-ны цахим хуудсанд

Зөвлөлийг батлахаас өмнө тавигдах юм (38, 58 болон 72 дугаар зүйлс). Бусад баримт бичгүүдийг Зөвлөлийг баталсны дараа АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

29. **Мэдээллийг ил гаргахыг илүүд үзэх.** Олон нийттэй харилцах бодлогын дагуу мэдээллийг ил гаргахыг илүүд үзнэ. Ийм учраас АХБ-ны гаргаж байгаа эсвэл гаргах шаардлагатай байгаа бүх баримт бичгийг бодлогод хамаарахгүй 97 болон 101 дүгээр зүйлсэн заасан онцгой тохиолдлуудаас бусад үед олон нийтэд ил гарган мэдээлж болно.

30. **Санаа болон мэдээ мэдээллийг авах, хуваалцах эрх.** АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа үйл ажиллагааны тухай мэдээ мэдээлэл, санааг иргэд эрэн хайх, хүлээж авах болон хуваалцах эрхийх АХБ хүлээн зөвшөөрдөг. АХБ мэдээллийг цаг тухайд нь, ойлгомжтой болон зохимжтой байдлаар хүргэнэ. Ингэснээр АХБ-ны үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад холбогдох талуудтай харилцах, сонсох болон тэдний саналыг бодолцон үзэх боломжийг олгох юм. Төслийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад АХБ-ны үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад холбогдох хүмүүс болох эмэгтэйчүүд, ядуу иргэд зэрэг эмзэг бүлгүүд ач холбогдолтой санал бодлоо оруулах боломж олгохуйц эрт шатанд мэдээллийг олгоно. АХБ мэдээллийг олон нийтэд ил гаргахдаа шилж сонгохгүй. Бодлогын дагуу олон нийтэд ил гарч байгаа мэдээллийг иргэд авахдаа тэгш эрхтэй байна.

31. **Улс орон удирдан залах.** Хөгжиж буй гишүүн орнуудад АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа үйл ажиллагаанд тухайн улс

орон эзэн нь байж, өөрөө удирдан явуулах нь чухал гэдгийг АХБ хүлээн зөвшөөрдөг. Иймээс тодорхой баримт бичгүүдийг ил гаргахын өмнө тэдгээрийн агуулга болон ил гаргах цаг хугацааны талаарх хөгжиж буй гишүүн орны санал бодлыг бодолцож үзнэ.

### 32. Мэдээллийг олон нийтэд ил гаргахгүй байх онцгой тохиолдлууд хязгаартай.

Бүх мэдээллийг үргэлж олон нийтэд ил гаргах боломжгүй. Жишээ нь, АХБ-нд дотооддоо болон гишүүн орнуудтайгаа шинэ санаа эрэлхийлэх, мэдээлэл солилцох, илэн далангүй яриа хэлэлцээр хийх болон Төв засгийн газрын бус хүрээн дэх үйл ажиллагааны онцгой хэрэгцээг бодолцон үзэх шаардлага тохиодог.<sup>6</sup> АХБ нь өөрийн ажилтан албан хаагчдын хувийн амьдрал, нууцтай байх эрх мөн өөрийн болон бизнес түншүүдийн хууль ёсны биенесийн ашиг сонирхлыг хамгаалах болно. Гэсэн хэдий ч мэдээллийг олон нийтэд ил гаргахдаа тодорхой зааг хязгаар бүхий онцгой тохиолдлуудыг бодолцон үздэг. АХБ-ны гаргаж байгаа эсвэл гаргах шаардлагатай байгаа бүх баримт бичгийг бодлогын 97 болон 101 дүгээр зүйлст заасан онцгой тохиолдлуудаас бусад үед олон нийтэд ил гарган мэдээлж болно. Мэдээллийг ил гаргахад учирч болзошгүй гарз хохирлоос тухайн мэдээллийг ил гаргах олон нийтийн ашиг сонирхол давамгайл байна хэмээн үзвэл эдгээр онцгой тохиолдлуудыг хэрэгсэхгүй байх эрх АХБ-нд байдаг. Үүнтэй ижил, энгийн үед олон нийтэд ил гаргадаг мэдээллийг ил гаргаснаас болж учирах эсвэл учирч болзошгүй гарз хохирол тухайн мэдээллийг ил гаргаснаас гарах үр ашгаас давамгайл байна хэмээн үзсэн онцгой тохиолдлуудад тухайн мэдээллийг ил гаргахгүй байх эрх мөн АХБ-нд байдаг.

33. **Гомдол гаргах эрх.** Иргэдийн мэдээлэл авах хүсэлтийг АХБ няцаахдаа энэхүү

бодлогыг зөрчсөн хэмээн үзвэл тухайн иргэн гомдлоо хоёр үе шаттайгаар гаргах эрхтэй хэмээн бодлогоор хүлээн зөвшөөрсөн. Гомдол гаргах ажиллагааг илүү итгэмжтэй болгох зорилгоор хоёр дахь үе шатыг АХБ-наас гадна хараат бус болгосон. Мэдээллийг ил гаргахад учирч болзошгүй гарз хохирлоос тухайн мэдээллийг ил гаргах олон нийтийн ашиг сонирхол давамгайл байна хэмээн үзсэний үндсэн дээр авахыг хүссэн мэдээллийг хязгаарладаг онцгой тохиолдлуудыг үл хэрэгсэхийн тулд гомдлыг мөн Мэдээллийн зөвлөлдөх хороонд гаргаж болно.

### 34. Бусад бодлоготой зохицсон байдал.

Олон нийттэй харилцах бодлого АХБ-наас гаргаж байгаа эсвэл гаргах шаардлагатай баримт бичгийг олон нийтэд ил гаргах дүрэм журмыг тодорхойлсон байдаг. Харин уг бодлого тэдгээр баримт бичгийг боловсруулах шаардлагыг тусгаагүй болно. Олон нийттэй харилцах бодлогод АХБ-ны бусад бодлогууд дурьдагдсан байдаг ба ийнхүү дурьдахдаа тухайн бодлогыг АХБ-ны зүгээс үе үе шинэчилсэн хувилбарыг багтаана. Олон нийттэй харилцах бодлогын мэдээллийг олон нийтэд ил гаргах тухай (зөвхөн үүнтэй холбоотой заалт бөгөөд бусад заалтад хамаарахгүй) заалтууд болон Захирлуудын зөвлөлөөс баталсан аливаа нэг бодлогын хооронд зөрчил үүсэх тохиолдолд, Олон нийттэй харилцах бодлогын мэдээллийг олон нийтэд ил гаргах тухай заалтууд давамгайлна. Олон нийттэй харилцах бодлого хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш АХБ-ны гаргасан эсвэл шинэчилсэн ямарваа нэг бодлого эсхүл стратеги нь тухайн бодлого эсхүл стратегийн доор боловсруулагдах шаардлагатай баримт бичиг болон бусад мэдээллийг олон нийтэд ил гаргах журмыг тодорхой тусгана. Эдгээр журмууд нь Олон нийттэй харилцах бодлогын суурь үзэл баримтлалтай нийцэж байна ■

<sup>6</sup> Түншийнхээ бизнесийн нууц мэдээллийг задлахгүй байх хууль ёсны гэрээний үүрэг бол хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагууд болон АХБ-тай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын түншүүдтэйгээ бизнес харилцаанд ороход тавигддаг стандарт шаардлага юм. Бизнесийн нууц мэдээллийг хамгаалах хэрэгцээг мэдээллийн хуулийн эрх чөлөөнд мөн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн байдаг. Үүнд худалдааны мэдээллийг ил гаргах онцгой тохиолдол багтана.



# Мэдээллийг олон нийтэд ил гаргах тухай

35. АХБ хөгжилд чиглэсэн үйл ажиллагаагаа боловсруулах болон хэрэгжүүлэхэд өөрийн зээлдэгч болон түншүүдтэйгээ нягт хамтран ажилладаг. Ингэхдээ АХБ өөрийн дэмжлэгтэйгээр хийгдэж буй үйл ажиллагаануудын талаарх мэдээллийг олон нийтэд ил гаргахыг илүүд үзэх үзэл баримтлалаа тэдэнд мэдэгдэнэ. АХБ зээлдэгч болон түншүүдтэйгээ зөвлөлдсөний дараа бөгөөд 97 болон 101 дүгээр зүйлд тусгагдсан мэдээллийг олон нийтэд ил гаргах журамд хамаарахгүй тохиолдлуудыг харгалзсаны үндсэн дээр доорх баримт бичгүүдийг заагдсан хуваарийн дагуу АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

## Улс оронтой хамтран хэрэгжүүлэх стратеги болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратеги

36. АХБ Улс оронтой хамтран хэрэгжүүлэх стратегийн хүрээнд хөгжиж буй гишүүн орон нэг бүртэй харилцдаг. Улс оронтой хамтран хэрэгжүүлэх стратеги нь улс орны түвшинд хөгжлийн үр дүнг авчрах үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах гол индэр юм. Бүс нутгийн хамтын ажиллагааны стратеги бол бүс нутгийн хамтын ажиллагааны чиглэлээр зорьсон зорилтууддаа хүрэхээр Ази Номхон далайн бүс нутаг дахь АХБ-ны тодорхойлсон бүс буюу дэд бүс юм.

37. АХБ дараагийн жил бэлтгэгдэн гарахаар төлөвлөгдөж буй Улс оронтой хамтран ажиллах шинэ стратегиуд, УОХАС-ийн завсрын шинэчлэлүүд болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратегиудын жагсаалтыг өөрийн цахим хуудсан дээр тухай бүрт нь шинэчлэн байршуулна. Аливаа улс орон болон/эсхүл бүс нутгийн УОХХТС, УОХХТС-ийн завсрын шинэчлэл болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратегийг бэлтгэх явцад холбогдох талуудын<sup>7</sup> саналыг авахаар бэлэн болсон төсөл болон бусад хэрэгтэй холбогдох мэдээллийг тухайн улс орон, бүс нутагт хуваалцана. Ийнхүү хуваалцах нь эдгээр баримт бичгийг боловсруулахад холбогдох талуудтай зөвлөлдөх, тэдний хувь нэмрийг оруулах бололцоог хангах зорилготой

38. Улс оронтой хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги, УОХХТС-ийн завсрын шинэчлэл, болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратегийг холбогдох гишүүн орнууд зөвшөөрсөн тохиолдолд Захирлуудын зөвлөлд танилцуулах үетэй нэгэн зэрэг АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Холбогдох гишүүн орнууд ийнхүү эрт шатанд мэдээллийг ил гаргахаас эсрэг саналтай байх тохиолдолд, тухайн баримт бичгүүдийг Захирлуудын зөвлөл баталсны дараа АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Мэдээллийг Захирлуудын зөвлөл болон олон нийтэд зэрэг ил гаргах энэхүү шаардлага нь удирдлагын хорооны

<sup>7</sup> Холбогдох талууд гэдэгт хөгжиж буй гишүүн орнуудын Засгийн газрууд, хөгжлийн түншүүд, хувийн хэвшил болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд багтана.

уулзалт буюу үүнтэй дүйцэх уулзалт хийгдэж дууссан УОХХТС, УОХХТС-ийн завсрын шинэчлэл болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратегид Олон нийттэй харилцах бодлогын хүчин төгөлдөр болох өдөр буюу өдрөөс хойш хамаарна.

39. УОХХТС болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратегид цахим линкээр тусгагдсан гол холбогдох баримт бичгүүд<sup>8</sup> нь УОХХТС болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратеги АХБ-ны цахим хуудсанд тавигдахтай нэгэн зэрэг байршуулагдана. УОХХТС болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратегийг бэлтгэхэд хэрэглэгдсэн сэдэв болон салбарын дүн шинжилгээ болон үнэлгээнүүд,<sup>9</sup> тэдгээрийн шинэчилсэн хувилбарууд нь эцэслэн бэлэн болсон үедээ АХБ-ны цахим хуудсанд байршуулагдана.

40. УОХХТС, УОХХТС-ийн завсрын шинэчлэл болон Бүс нутгийн хамтын ажиллагааны стратегийг хэлэлцсэн Захирлуудын зөвлөлийн хурлын дүгнэлтийг Захирлуудын зөвлөлд эцэслэн танилцуулах үед АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Хэрэв англи хэл нь холбогдох улс орны зорилтот бүлгүүдийн голлох хэл биш бол АХБ нь УОХХТС болон УОХХТС-ийн завсрын шинэчлэлийг холбогдох улс орны үндэсний хэл рүү Захирлуудын зөвлөл баталснаас хойш 90 хоногт багтаан орчуулж, өөрийн цахим хуудсанд байршуулна.

41. АХБ, Улс орон дахь үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө болон Бүс нутгийн хамтын ажиллагааны бизнес төлөвлөгөө, эдгээртэй холбоотой баримт бичгүүдийг (аливаа нэг Хөгжиж буй гишүүн орон эсвэл бүс нутаг, дэд бүс дэх зээлийн болон зээлийн

бүс төслүүдийн жагсаалт) мөн Захирлуудын зөвлөлд танилцуулах үед өөрийн цахим хуудсанд байршуулна.

## Төсөл, хөтөлбөрүүд

### Төслийн мэдээллийн тайлан

42. Төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад нь гадны холбогдох байгууллагуудад мэдээлэл өгөх үүднээс АХБ төсөл, хөтөлбөрийн тухай хураангуй мэдээллийг агуулсан Төслийн мэдээллийн тайланг<sup>10</sup> (ТМТ) өөрийн цахим хуудсанд байршуулна. ТМТ-г байнга шинэчилдэг. Иймд анхны хувилбарт зарим мэдээлэл ороогүй байж болох бөгөөд бэлэн болох үед нь нэмэгдэнэ. Төсөл, хөтөлбөрийг боловсруулах үед загвар болон хяналтын хүрээг боловсруулдаг ба энэ нь цаашдаа тухайн төслийн гүйцэтгэл, үр нөлөөг үнэлэх суурь болдог. Уг хүрээнд багтсан гол мэдээллийг ТМТ-д тусган оруулна.<sup>11</sup> ТМТ-ийн цахим хуудсан дээр төслийн үед боловсруулагдсан холбогдох баримт бичгүүдийн холбоосыг байргуулна. АХБ нь зээл, буцалтгүй тусламжийн бүх төсөл болон төсөл бэлтгэх техникийн туслалцааны төслүүдийн ТМТ-г төслийн гол үе шатуудад холбогдох үндэсний хэл рүү хөрвүүлэн, хөрвүүлсэн хувилбарыг АХБ-ны цахим хуудсанд байршуулж, зохистой арга хэрэгслийг ашиглан улс оронд хэрэглэхэд нээлттэй болгоно. Үндэсний хэл рүү хөрвүүлэх энэхүү шаардлага нь Олон нийттэй харилцах бодлого хүчин төгөлдөр болсон өдөр эсвэл энэ өдрөөс хойш төслийн анхны концепци батлагдсан зээл, буцалтгүй тусламжийн төслүүд болон төсөл бэлтгэх техникийн туслалцааны төслүүдэд хамааралтай.

<sup>8</sup> Жишээ нь, улс орон болон төсөл хөтөлбөрийн багцын үзүүлэлтүүд.

<sup>9</sup> Жишээ нь, эдийн засаг, ядуурал, жендэрийн дүн шинжилгээ, болон хувийн хэвшил ба засаглалын эрсдэлийн үнэлгээ.

<sup>10</sup> ТМТ нь 2005 онд гарсан Олон нийттэй харилцах бодлогын доорх Төслийн мэдээллийн баримт бичгийг оролно.

<sup>11</sup> Дизайн ба хяналтын эцсийн хүрээ нь Ерөнхийлөгчийн тайлан ба зөвлөмжийн нэг хэсэг бөгөөд АХБ-ны цахим хуудсанд мөн байршуулна.

### **Засгийн газрын хүрээн дэх төслүүдийн Төслийн мэдээллийн тайлан**

43. Засгийн газрын хүрээн дэх төсөл, хөтөлбөрийн хувьд анхны концепци батлагдах үед ТМТ-ийн анхны хувилбарыг АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Олон шатлалт зээлийн шугамын анхан шатны зээлийн ТМТ-г зээлийг анх судлах ажил дууссаны дараа цахим хуудсанд байршуулах ба дараа дараагийн шатны зээлийг мөн тухайн зээлийг анх судлах ажил дууссан цагт байршуулна. Зээлийг анхлан судлах ажил хийгдээгүй тохиолдолд, тухайн шатны зээлийн санхүүжилтийн хүсэлтийг АХБ хүлээн авсны дараа ТМТ-г тавина.

44. Төслийн хэрэгжилтийн байдлыг тусгахын тулд АХБ ТМТ-г жилд багадаа 2 удаа, мөн тухайн шаардлагатай үед нь үйл ажиллагаа, аливаа асуудлуудыг тусгах, үр дүндээ хүрэх чиглэлд гарсан ахиц болон хэрэгжилтийн явцыг тусгах зорилгоор ТМТ-г шинэчилнэ. АХБ, Засгийн газрын хүрээн дэх аливаа нэг төсөл, хөтөлбөрт оролцохоо больсон тохиолдолд, холбогдох ТМТ-д оролцохоо больсон шалтгааныг зайлшгүй мэдэгдэх шаардлагатай. АХБ оролцохоо больсон төслийн мэдээллийн тайланг өөрийн цахим хуудсанд, оролцохоо больсон цагаас эхлэн 12 сарын хугацаанд хадгална.

### **Засгийн газрын бус хүрээн дэх төслүүдийн мэдээллийн тайлан**

45. Засгийн газрын бус хүрээн дэх төслийн анхны мэдээллийг уг төслийг Захирлуудын зөвлөлд оруулах магадлалтай гэж үзсэний дараа бөгөөд Захирлуудын зөвлөлөөр орохоос 30 хоногийн өөрийн цахим хуудсанд байршуулна. Байгаль орчны хамгааллын ангиллаар А үнэлгээтэй төслүүдийн хувьд АХБ Захирлуудын зөвлөлөөр орохоос дор хаяж 120 өдрийн өмнө өөрийн цахим хуудсанд ТМТ-г байршуулна.

46. АХБ нь төслийн явцын талаарх мэдээг оруулан ТМТ-г шинэчилж байх болно. ТМТ-г

төслийн үйл ажиллагаа, асуудал, хөгжлийн зорилтууд болон хэрэгжилтийн явц зэргийг тусган жилд хамгийн багадаа хоёр удаа бөгөөд шаардлагатай тохиолдолд үүнээс илүү хийнэ. Хэрэв АХБ төв засгийн газрын хүрээний бус аливаа нэг төсөлд оролцохоо байвал тухайн ТМТ-д АХБ уг төсөл дэх өөрийн оролцоог зогсоосон хэмээн тусгана. Ийнхүү оролцохоо больсон төслийн ТМТ-г АХБ өөрийн цахим хуудсанд оролцоог зогсоосноос хойш 12 сарын хугацаанд хадгална.

### **Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад сонирхсон талуудад олгох мэдээлэл**

47. Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон эмэгтэйчүүд, ядуус болон бусад эмзэг бүлгийхэн зэрэг сонирхсон талуудтай харилцан яриа өрнүүлэхийн тулд төв зөсгийн газрын хүрээний болон хүрээний бус төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл нь (үүн дотор байгаль орчин болон нийгмийн асуудлууд багтана) эдгээр хүмүүст ойлгомжтой, авах боломжтой байдал, газар, хэлээр байна. АХБ нь энэхүү мэдээлэл хүмүүст нээлттэй олгогдож, санал болгож буй төслийн талаарх саналыг хүмүүсээс авч, нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад сонирхсон талуудтай байнгын харилцаатай байх хүн томилогдон ажиллах тал дээр зээлдэгч буюу үйлчлүүлэгчтэй нягт хамтран ажиллана. Тэдгээр хүмүүсийн саналыг төсөл боловсруулах болон цаашид хэрэгжих явцад хангалттай хэмжээнд оруулахын тулд энэхүү үйл явцыг төсөл бэлтгэх шатны эхэн үед эхэлнэ. Төсөл, хөтөлбөрийн бүтэц дизайн нь хэрэгжилтийн явцад оролцогч талууд өөрсдийн саналыг өгөх боломжтой байдлаар боловсруулагдсан байх тал дээр АХБ ажиллана. АХБ нь мөн төслийн хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлт болон үүнээс үүдэж болзошгүй нөлөөллийн талаарх холбогдох мэдээллийг нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад сонирхсон талуудад олгогдсон байхаар ажиллана.

48. 47 дугаар зүйл дэх шаардлагуудыг дэмжихийн тулд АХБ нь ХБГО болон

хувийн хэвшлийн түншүүддээ төсөл, хөтөлбөрийн олон нийттэй харилцах бодлогыг боловсруулахад тусална. Төсөл, хөтөлбөрийн олон нийттэй харилцах бодлого нь нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад талуудтай хийх зөвлөлгөөний нэгэн хэсэг байх бөгөөд зээлдэгч, түншүүдэд АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж буй үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэх явцад нөлөөлөлд өртсөн иргэдийг оролцуулах болон тэдэнтэй хэрхэн харилцах, олон нийтэд хэрхэн илүү их мэдээлэл олгох зэрэгт иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд туслах юм. Ингэхдээ зөвлөлгөө, оролцооны төлөвлөгөө эсхүл төсөл хэрэгжүүлэх гарын авлага зэрэг баримт бичгүүдэд доорх мэдээллийг оруулах замаар хийнэ. Үүнд: (i) олон нийттэй ил гаргах мэдээллийн төрөл, (ii) олон нийтэд мэдэгдэл гаргах арга зам, үүнд мэдэгдэл гаргах цаг болон хэл орно, (iii) мэдээллийг олон нийтэд ил гаргах болон түгээх ажиллагааг хэрэгжүүлэх, хянах үүрэг хариуцлага зэрэг орно.

### Төслийн хамгааллын бодлогын баримт бичиг

49. АХБ-ны байгаль орчин болон нийгмийн хамгааллын мэдээллийг төслийн нөлөөлөлд өртсөн иргэдэд ил гарган мэдээллэх шаардлагууд нь төв засгийн газрын хүрээний болон хүрээний бус төслүүдийн хувьд ижил байна.

50. Зээлдэгч болон түнш нь 51–53 дугаар зүйлд дурьдагдсан баримт бичгүүд дээрх мэдээлэл болон байгаль орчин, нүүлгэн шилжүүлэлт, нутгийн уугуул иргэдийн мэдээллийг нөлөөлөлд өртсөн иргэдэд цаг хугацааны дагуу, тэдний ойлгох хэл, загвар, байдлаар гаргаж өгнө.<sup>12</sup>

### Байгаль орчин

51. Хамгааллын бодлогын баримт бичигт заасан шаардлагын дагуу АХБ нь зээлдэгч эсвэл түншийн хүлээлгэн өгсөн дараах баримт бичгийг өөрийн цахим хуудсанд байршуулна:

- (i) Байгаль орчны хувьд А ангилалд багтсан төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангийн төслийг Захирлуудын зөвлөлөөр хэлэлцэхээс дор хаяж 120 хоногийн өмнө,
- (ii) Байгаль орчны үнэлгээний төслийг боломжтой тохиолдолд батлагдахаас өмнө,<sup>13</sup>
- (iii) байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангийн эцсийн хувилбарыг АХБ хүлээн авсан цагаас эхлэн,
- (iv) байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангийн шинэ эсвэл шинэчилсэн хувилбар бөгөөд шаардлагатай тохиолдолд засан залруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг АХБ хүлээн авсан цагаас эхлэн болон
- (v) байгаль орчны хяналтын тайланг АХБ хүлээн авсан цагаас эхлэн тус тус байршуулна.

### Нүүлгэн шилжүүлэлт

52. Хамгааллын бодлогын танилцуулгад багтсан шаардлагуудын дагуу, АХБ өөрийн зээлдэгч ба/эсвэл түншийн илгээсэн дараах бичиг баримтыг өөрийн цахим хуудсанд байршуулна:

- (i) Зээлдэгч ба/эсвэл түншийн батлан зөвшөөрсөн нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө ба/эсвэл нүүлгэн шилжүүлэлтийн баримт бичгийн

<sup>12</sup> Энэхүү мэдээллийг нөлөөлөлд өртсөн иргэдэд ойлгомжтой хэл дээр хөрвүүлэн брошур, танилцуулах хуудас зэрэг хэлбэрээр олгож болно. Бичиг үсэг тайлагдаагүй хүмүүст бусад тохиромжтой арга хэрэгслийг ашиглана.

<sup>13</sup> Төслийг батлуулахаар дахин ажиллах шаардлагагүй бол, тухайн баримт бичгийг төв засгийн газрын хүрээний төслүүдийн хувьд удирдлагуудын хянан шалгах уулзалт эсвэл ажилчдын хянан шалгах анхны уулзалтаас өмнө, төв засгийн газрын хүрээний бус төслүүдийн хувьд хөрөнгө оруулалтын зөвлөлийн эцсийн уулзалтаас өмнө байршуулна.

- төсөл, үнэлгээнд орохоос өмнө байршуулна (мөрийн тайлбар 13),
- (ii) Нөлөөлөлд өртсөн иргэдээс мэдээлэл цуглуулах үйл явц дууссаны дараа зээлдэгч ба/эсвэл түнш батлан зөвшөөрсөн нүүлгэн шилжүүлэлтийн эцсийн төлөвлөгөө ба/эсвэл нүүлгэн шилжүүлэлтийн баримт бичиг,
  - (iii) Төслийн хэрэгжилтийн үед боловсруулагдсан нүүлгэн шилжүүлэлтийн шинэ эсвэл шинэчлэгдсэн төлөвлөгөө болон засан залруулах үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа бол эдгээрийг АХБ хүлээж авсны дараа байршуулна
  - (iv) Нүүлгэн шилжүүлэлтийн мониторингийн тайлан, АХБ хүлээж авсны дараа байршуулна.

#### Нутгийн уугуул иргэд

53. Хамгааллын бодлогын танилцуулгад багтсан шаардлагуудын дагуу, АХБ өөрийн зээлдэгч ба/эсвэл түншийн илгээсэн дараах бичиг баримтыг өөрийн цахим хуудсанд байршуулна:

- (i) Зээлдэгч ба/эсвэл түншийн батлан зөвшөөрсөн нутгийн уугуул иргэдийн тухай төлөвлөгөө ба/эсвэл нутгийн уугуул иргэдийн тухай төлөвлөгөөний хүрээ, үнэлгээнд орохоос өмнө байршуулна (мөрийн тайлбар 13),
- (ii) Нутгийн уугуул иргэдийн тухай эцсийн төлөвлөгөө, АХБ-ийг хүлээж авсны дараа байршуулна,
- (iii) Төслийн хэрэгжилтийн үед боловсруулагдсан нутгийн уугуул иргэдийн тухай шинэ эсвэл шинэчлэгдсэн төлөвлөгөө болон засан залруулах үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа бол эдгээрийг АХБ хүлээж авсны дараа байршуулна,
- (iv) Нутгийн уугуул иргэдийн тухай төлөвлөгөө, үйл ажиллагааны мониторингийн тайлан, АХБ хүлээж авсны дараа байршуулна.

#### Улс орны хамгааллын тогтолцоо

54. АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж буй төслүүдэд улс орны хамгааллын тогтолцоог хэрэгжүүлэхтэй холбоотой Хамгааллын бодлогын танилцуулгад багтсан шаардлагуудын дагуу, АХБ дараах бичиг баримтыг өөрийн цахим хуудсанд байршуулна:

- (i) Ижил тэнцүү болон хүлээж авах боломжтой эсэх талаар гаргасан үндэсний, салбарын эсвэл байгууллагын түвшний үнэлгээ, хийгдэж дууссан үед нь,
- (ii) Ижил тэнцүү болон хүлээж авах боломжтой эсэх талаар гаргасан үнэлгээний эцсийн тайлан, хийгдэж дууссан үед нь,
- (iii) Улс орны хамгааллын тогтолцоонд орсон өөрчлөлтүүдийг тусгахаар хийгдсэн шинэчилсэн үнэлгээ байгаа бол тэдгээрийг мөн хийгдэж дууссан үед нь байршуулна.

55. Төслийн түвшинд хүлээж авах боломжтой эсэх талаар гаргасан үнэлгээг олон нийтэд ил гаргахтай холбоотой асуудлуудыг 51–53 дугаар зүйлүүдэд тусгагдсан, төслийг бэлтгэх үед баримталсан хамгааллын баримт бичгүүдийг олон нийтэд ил гаргах журмыг баримтална.

#### Ядуурал, нийгмийн анхан шатны шинжилгээ

56. Ядуурал, нийгмийн анхан шатны шинжилгээ (ЯНАШШ)-г зөвлөлгөөн, олон нийтийн оролцоо, жендэр болон хөгжил болон нийгмийн хамгаалал болон төслийн боловсруулах үед тооцох шаардлагатай нийгмийн бусад эрсдэлүүд зэрэг асуудлуудын тухайн үеийн үнэлгээ болон ядуурлын хүрээг тодорхойлох зорилгоор хөрөнгө оруулалтын бүх төсөл, хөтөлбөрүүдэд хийдэг. Засгийн газрын хүрээний төслүүдийн хувьд ЯНАШШ-г тухайн төсөл, хөтөлбөрийн анхны концепц батлагдсаны дараа өөрийн цахим хуудсанд байршуулна. Засгийн газрын бус

хүрээний төслийн хувьд, ЯНАШШ-г зээлийг батлах үйл ажиллагаа дууссаны дараа АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

### Техникийн туслалцааны тайлан ба техникийн туслалцааны доор боловсруулагдсан баримт бичгүүд

57. ТТ-ны тайлан гэж АХБ-наас олгосон ТТ болон түүний санхүүжилтийн талаарх нөхцлүүдийг тайлбарласан баримт бичиг юм.<sup>14</sup> ТТ-ны төслийн доор гаргасан зөвлөхүүдийн эцсийн тайланг бэлэн болсны дараа АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Бодлого болон зөвлөмж боловсруулах ТТ, чадавх бэхжүүлэх ТТ нь зарим асуудалтай хүрээг хамраж болох тул, АХБ эдгээр ТТ-ны доор гарсан зөвлөхүүдийн эцсийн тайланг олон нийтэд ил гаргахад татгалзах боломжийг холбогдох улс орнуудад олгоно. Мэдээллийг олон нийтэд ил гаргахыг илүүд үзэх үзэл баримтлалын дагуу эдгээр баримт бичгүүдэд орж болзошгүй аливаа өөрчлөлт эсвэл олон нийтэд ил гаргахгүй байх тохиолдлуудыг Олон нийттэй харилцах бодлогын онцгой тохиолдлуудад тооцогдох үед хийнэ.

### Ерөнхийлөгчийн тайлан зөвлөмж болон холбогдох баримт бичгүүд

58. Ерөнхийлөгчийн тайлан зөвлөмж (ЕТЗ) нь Захирлуудын зөвлөлөөр батлуулахаар танилцуулдаг АХБ-ны төсөл, хөтөлбөрүүдийн шийдлийн баримт бичиг юм. Засгийн газрын хүрээний төслүүдийн хувьд, АХБ холбогдох гишүүн улс орнууд зөвшөөрсөн бол ЕТЗ-ийг Захирлуудын зөвлөлд өргөн барихтай нэгэн АХБ-ны цахим хуудсанд байршуулна. Гишүүн орон ЕТЗ-ийг ийнхүү эрт шатанд олон нийтэд ил гаргахаас татгалзсан бол Захирлуудын зөвлөл баталсны дараа

өөрийн цахим хуудсанд байршуулна. Мэдээллийг Захирлуудын зөвлөл болон олон нийтэд ийнхүү нэгэн зэрэг ил гаргах энэхүү шаардлага нь тухайн төслийн Зээлийн хэлэлцээр Олон нийттэй харилцах бодлогын хүчин төгөлдөр болох өдөр эсвэл өдрөөс хойш хийгдсэн төсөл хөтөлбөрүүдэд хамаарна. Зарим баримт бичгүүдийн хувьд бодлогод өөрөөр тусгагдаагүй бол Засгийн газрын хүрээний төслүүдийн ЕТЗ-ийн холбогдох баримт бичгүүд болон төсөл хэрэгжүүлэх гарын авлага буюу төслийн хэрэгжилтийн үйл явцыг тодорхойлсон баримт бичиг зэргийг ЕЗТ-г АХБ-ны цахим хуудсанд байршуулахтай нэгэн зэрэг, тус тусад нь болон ЕТЗ-тай холбоос баримт бичгүүд маягаар байршуулна.<sup>15</sup> Засгийн газрын бус хүрээний төслүүдийн хувьд, ЕТЗ-ийг Захирлуудын зөвлөл баталсны дараа уг баримт бичгийн товчилсон хувилбарыг өөрийн цахим хуудсанд байршуулна. Төсөл болон үйл ажиллагааны эрсдэлийн тухай АХБ-ны хийсэн үнэлгээ болон бизнесийн нууц чанартай мэдээллийг үүнд оруулахгүй.

### Хуулийн гэрээ хэлэлцээр

59. Олон нийттэй харилцах бодлого хүчин төгөлдөр болсон өдрөөс эсвэл өдрөөс хойш биелсэн Засгийн газрын хүрээний төслүүдийн хуулийн бүх гэрээ, хэлэлцээрийг өөрийн цахим хуудсанд байршуулах ба ингэхдээ зээлийн хэлэлцээрийн үеэр 97 дугаар зүйлд заагдсан бодлогын хүрээнд орохгүй онцгой тохиолдлууд хэмээн тогтсон бол тухайн хамааралтай мэдээллийг гарган авна.<sup>16</sup> Зээлдэгч зөвшөөрвөл, гэрээ хэлэлцээрийн төслийг хүсэлтийн дагуу ил гаргаж болно. Хуулийн гэрээ хэлэлцээрт өөрчлөлт орсон бол эдгээр өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болсон өдрөөс 2 долоо хоногт багтаан АХБ өөрийн цахим хуудсанд байршуулна.

<sup>14</sup> \$1.5 сая хүртэлх төсөл бэлтгэх ТТ-ны хувьд, ТТ-ны тайланг үндсэн төслийн концепцийн баримт бичигтэй хавсран уг баримт бичгийг батлагдах үеэр цахим хуудсанд байршуулна.

<sup>15</sup> Жишээ нь, гэрээ хэлэлцээрүүд.

<sup>16</sup> АХБ нь Засгийн газрын бус хүрээний төслүүдийн хувьд хийсэн гэрээ хэлэлцээрүүдийг ил гаргахгүй. Үүнд мөн арилжааны хамтран санхүүжүүлэх гэрээнүүд хамаарна.

Ингэхдээ зээлийн хэлэлцээрийн үеэр 97 дугаар зүйлд заагдсан бодлогын хүрээнд орохгүй онцгой тохиолдлууд хэмээн тогтсон бол тухайн мэдээллийг гарган авна.

60. 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2005 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хооронд хийгдсэн Засгийн газрын хүрээний төслүүдийн хуулийн гэрээ, хэлэлцээр болон эдгээр гэрээ, хэлэлцээрт орсон аливаа өөрчлөлтийг хүсэлтийн дагуу ил гаргана. Ингэхдээ зээлийн хэлэлцээрийн үеэр 97 дугаар зүйлд заагдсан бодлогын хүрээнд орохгүй онцгой тохиолдлууд хэмээн тогтсон бол тухайн мэдээллийг гарган авна.

61. 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө хийгдсэн Засгийн газрын хүрээний төслийн хуулийн гэрээ, хэлэлцээр болон тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүдийг хүсэлтийн дагуу олон нийтэд ил гаргахаас өмнө АХБ холбогдох гишүүн улс орны Засгийн газраас зөвшөөрөл авна.<sup>17</sup>

### Аудитанд орсон төслийн данс

62. Зээлийн хэлэлцээр хийх урилга Олон нийттэй харилцах бодлого хүчин төгөлдөр болсон өдөр болон түүнээс хойш гарсан урилгуудтай Засгийн газрын хүрээний төслүүдийн аудитанд орсон дансны жилийн тайланг АХБ өөрийн цахим хуудсанд байршуулна.<sup>18</sup>

### Томоохон өөрчлөлтүүд

63. Төслийн хүрээнд гарсан том хэмжээний өөрчлөлттэй холбоотой Захирлуудын зөвлөлд танилцуулсан баримт бичгүүдийг тухайн өөрчлөлт батлагдсан үед АХБ өөрийн цахим хуудсанд байршуулна. Засгийн газрын бус хүрээний төслүүдийн хувьд, бизнесийн нууцлалын чанартай мэдээллийг хассан товчилсон хувилбарыг байршуулна.

### Бодлогод суурилсан зээл болон буцалтгүй тусламжийн төслүүдийн зээлийн шатлалуудын талаарх явцын тайлан

64. Зээлийн шатлалуудын талаарх явцын тайлангууд нь хөгжиж буй гишүүн орнуудад олгож буй бодлогод суурилсан зээл болон буцалтгүй тусламжийн нөхцлүүдийн хэрэгжилтийг хянан үнэлгээ хийдэг. Эдгээрийн явцын тайланг АХБ өөрийн цахим хуудсанд Захирлуудын зөвлөл эсвэл Удирдлагууд баталсны дараа байршуулна.

### Эцсийн тайлан

65. АХБ нь төсөл, хөтөлбөр, ТТ-ны эцсийн тайланг Захирлуудын зөвлөлд өргөн барих үетэй нэгэн зэрэг өөрийн цахим хуудсанд байршуулна. Засгийн газрын хүрээний бус төслийн эцсийн тайланг уртасгасан жилийн хяналтын тайлан гэж нэрлэдэг ба худалдаа, бизнесийн нууц мэдээллийг хасан товчилсон хэлбэрийг нь байршуулдаг.

### Төсөл, хөтөлбөрүүдэд хамаарах бусад мэдээлэл

#### Хараат бус үнэлгээ

66. АХБ-ны Хараат бус үнэлгээний газрын (ХБҮГ) хийхээр төлөвлөсөн хараат бус үнэлгээнүүдийг жагсаалтыг өөрийн цахим хуудсанд байршуулна. Уг жагсаалтыг Захирлуудын зөвлөлийн баталсан 3 жилийн ажлын хөтөлбөрт үндэслэн гаргадаг.

67. Захирлуудын зөвлөлийн Хөгжлийн үр нөлөөний хороогоор хэлэлцүүлсний дараа АХБ-ны цахим хуудсанд байршуулах ХБҮГ-ын жилийн үнэлгээний тайлангаас бусад хараат бус үнэлгээний тайлангуудыг Удирдлага болон Захирлуудын зөвлөлд

<sup>17</sup> АХБ хүсэлт явуулснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор АХБ-нд мэдээллийг ил гаргахыг татгалзсан хариуг ирүүлэхгүй бол, эдгээр гэрээг АХБ ямар ч хүсэлт гаргагчид хуанлийн 60 хоногийн дотор олгоно.

<sup>18</sup> Жил бүрийн аудитанд орсон төслийн дансуудыг ил гаргах журмыг зээлдэгч тус бүртэй зээлийн хэлэлцээрийн үеэр хэлэлцэн тохиролцоно.

танилцуулах үетэй нэгэн зэрэг цахим хуудсанд байршуулна. Засгийн газрын бус хүрээний төслүүдийн үнэлгээний тайлангуудаас худалдаа, бизнесийн нууц мэдээллийг хасан, товчилсон хувилбарыг АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

68. Хөгжлийн үр нөлөөний хороогоор хэлэлцүүлэх үнэлгээний тайлангуудын хувьд хурлын протоколын хураангуйг Захирлуудын зөвлөлд танилцуулах үед өөрийн цахим хуудсанд тавина. Мөн хараат бус үнэлгээний талаар Удирдлагын зүгээр гаргасан хариу санал, түүнд ХБҮГ-аас ирүүлсэн хариу зэрэг байвал мөн тэдгээрийг цахим хуудсанд байршуулна.

### Хамтран санхүүжилтийн талаарх мэдээлэл

69. АХБ нь хамтран санхүүжилттэй төслүүдийн жагсаалтын өөрийн цахим хуудсанд тавина. Төслийн ерөнхий нөцөл зэргийг тусгасан албан ёсны хамтран санхүүжилтийн талаар мэдээлэл байвал түүнийг АХБ-ны цахим хуудсанд тавигддаг тухайн төслийн тайлан эсвэл ЕТЗ-д оруулна. Хамтран санхүүжүүлэгч тал татгалзахгүй бол АХБ нь эдгээр төслийн хамтран санхүүжилтийн гэрээ хэлэлцээр, ерөнхий гэрээ, тусгай сан байгуулах тухай гэрээ зэрэг албан ёсны хамтран санхүүжилтийн гэрээ хэлэлцээрийг хүсэлтийн дагуу гарган өгнө.

### Авлигын эсрэг арга хэмжээний тухай мэдээлэл

70. АХБ-ны Авлигын эсрэг болон шударга байдлын алба (АШБА)-ны жилийн тайлан эцэслэн гарсан үед АХБ-ны цахим хуудсанд байршуулна.<sup>19</sup> АШБА-ны жилийн тайлан нь явуулсан шалгалтуудын тухай статистик тоо

баримт болон мөрдөн байцаалт, төслийн худалдан авах ажиллагаатай холбоотой хийсэн шалгалтаас гарсан томоохон зөвлөмжүүд, асуудлуудыг багтаадаг. АХБ нь АШБА-наас төслийн худалдан авах ажиллагаатай холбоотой хийсэн шалгалтуудын тайланг эцэслэн гарах үед нь өөрийн цахим хуудсанд байршуулна. АШБА-ны тайлангуудаас энэхүү бодлогод олон нийтэд мэдээллийг ил гаргахгүй байх онцгой тохиолдлуудад хамаарах мэдээллийг хасна. АХБ нь гишүүн орнуудынхаа засгийн газруудтай мөрдөн байцаалт, шалгалтуудын хариуг хуваалцаж болно.

71. АХБ нь өөрийн хориг жагсаалтанд орсон аж ахуйн нэгжүүдийн тухай мэдээллийг гишүүн орнуудынхаа засгийн газрууд, бусад хөгжлийн банк, хоёр талт санхүүжүүлэгч нар болон мэдэх шаардлага бүхий бусад этгээдүүдтэй хуваалцана. АХБ нь хориг жагсаалтын талаарх мэдээллийг цахим хуудсан дээрээ тавих ба үүнд: (i) хориг арга хэмжээг цуцулсан хориг жагсаалтанд орсон этгээдүүд, (ii) АХБ-ны Авлигын эсрэг бодлогыг (1998 он, тухай бүрт нь шинэчилдэг) зөрчсөн хориг жагсаалтад орсон этгээдүүд, (iii) тодорхой хичээл зүтгэл гаргасан ч холбоо тогтоож болохгүй хориг жагсаалтанд орсон этгээдүүд, (iv) бусад хөгжлийн банкуудтай хамтран хориг жагсаалтанд оруулахаар тохирсны дагуу жагсаалтанд орсон этгээдүүд багтана.<sup>20</sup>

## Бодлого ба стратеги

### Олон нийттэй зөвшилцөх шаардлагатай бодлого, стратегиуд

72. АХБ нь хамгааллын бодлого, салбар болон сэдэвчилсэн бодлого, стратегиудыг боловсруулах, хянахад холбогдох талууд

<sup>19</sup> Авлигын эсрэг ёс зүйн алба нь авлига, хээл хахууль болон АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагаа, эсвэл АХБ-ны ажилтнуудтай холбоотой АХБ-ны Авлигын эсрэг бодлогыг зөрчсөн хэргүүдийн таамаглалыг хүлээн авч, судалдаг АХБ-ны гол алба юм.

<sup>20</sup> АХБ, Африкийн Хөгжлийн Банк, Америк Дундын Хөгжлийн Банк, ЕСБХБ болон Дэлхийн Банкны 2010 оны 4 сарын 9-ний өдөр хийсэн Хориотой жагсаалтыг харилцан мөрдөх гэрээ: <http://www.adb.org/documents/agreement-mutual-enforcement-debarment-decisions>



болон сонирхлоо илэрхийлсэн бусад талуудыг оролцоог хангахаар ажилладаг. Ирэх 12 сарын хугацаанд боловсруулагдах болон хянан үзэх бодлого, стратегиудын жагсаалтыг АХБ өөрийн цахим хуудсанд байршуулдаг. АХБ нь тухайн төлөвлөгөө эцэслэн гарсан үед гадны талуудтай хийх уулзалтууд зэрэг зөвлөлгөөний төлөвлөгөөг өөрийн цахим хуудсанд байршуулна. АХБ нь тухайн бодлого, стратегийн хамгийн багадаа нэг төслийг олон нийттэй зөвлөлдөх үүднээс өөрийн цахим хуудсанд тавидаг. АХБ олон нийттэй зөвлөлдсөн бодлого, стратегийн эцсийн хувилбар болон ажлын баримт бичгүүдийг Захирлуудын зөвлөлд танилцуулах үетэй нэгэн зэрэг өөрийн цахим хуудсанд байршуулна. Энэ шаардлага нь Олон нийттэй харилцах бодлого хүчин төгөлдөр болсон өдөр эсвэл өдрөөс хойш Захирлуудын зөвлөлд танилцуулах ажлын баримт бичгүүд болон бодлого, стратегийн эцсийн хувилбарт хамаарна.

### Бусад бодлого, стратеги

73. АХБ бусад бодлого, стратегийн баримт бичгүүдийг батлагдсан үед нь өөрийн цахим хуудсанд байршуулна.

### Хурлын протокол

74. Захирлуудын зөвлөлийн албан хурал дээр Захирлуудын зөвлөлийн баталсан бодлого, стратегийн баримт бичиг болгоны хурлын протоколыг АХБ-ны цахим хуудсан дээр уг протоколыг Захирлуудын зөвлөлд танилцуулах үетэй нэгэн зэрэг тавина.

### Үйл ажиллагааны дүрэм журам

75. АХБ нь Үйл ажиллагааны гарын авлагууд (банкны бодлогын баримт бичиг болон үйл ажиллагааны дүрэм журам), Төсөл хэрэгжүүлэх удирдамж, АХБ-ны үйл

ажиллагааны талаарх ажилчдад зориулсан гарын авлагууд зэргийг ажилчдад олгох үед өөрийн цахим хуудсанд байршуулна.

## Бусад мэдээлэл

### Худалдан авах ажиллагаа

76. АХБ нь дараах мэдээлэл, баримт бичгийг өөрийн цахим хуудсанд байршуулна:

- (i) анх тодорхойлсноос эхлээд Захирлуудын зөвлөлөөр батлагдах хүртэлх хугацаанд АХБ-ны санхүүжилт авахаар бэлтгэгдэж байгаа Засгийн газрын хүрээний бүх төслүүдийн хүрээн дэх бизнесийн боломжуудын жагсаалт;
- (ii) төсөл хэрэгжүүлэх гарын авлагын нэг хэсэг болох зээлдэгчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө,<sup>21</sup> үүнд (а) төслийн эхний 18 сарын хугацаанд хийх бараа, ажил, зөвлөх болон бусад үйлчилгээний гэрээ тус бүр, (b) гэрээ тус бүрийн худалдан авах ажиллагааг хийхээр санал болгосон арга барил болон (c) АХБ хянан шалгахад ашиглах журам зэргийг тусгасан;
- (iii) худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зээлдэгчийн зүгээс оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (төсөл хэрэгжих хугацаанд жилд хамгийн багадаа нэг удаа);
- (iv) сонирхлоо илэрхийлэх, урьдчилсан шалгуурт тэнцэх, худалдан авах ажиллагаа болон зөвлөх үйлчилгээ авахад олон улсын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцохоор төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон АХБ-ны мэдэгдэл болгон гаргасан бүх урилгууд;
- (v) гэрээлэгчийн нэр, гэрээний тайлбар, АХБ-наас санхүүжүүлэх гэрээний дүн, АХБ-ны нягтлан бодох бүртгэлд орсон гэрээ байгуулах бүх эрх;

<sup>21</sup> ЕТЗ болон холбогдох баримт бичгүүд, үүн дотор төслийн удирдлагын гарын авлага орно, зэргийг ил гаргах цагийн хуваарийг 58 дугаар зүйлээс харна уу.

- (vi) АХБ-ны байгууллагын худалдан авах ажиллагааны хүрээнд томоохон тендерийн санал, гэрээ байгуулах эрх, тендерийн баримт ирүүлэх урилга.

### Азийн хөгжлийн сангаас санхүүжилт авдаг улс орнуудын гүйцэтгэлийн үнэлгээ

77. Азийн хөгжлийн сан (АХС)<sup>22</sup>-аас санхүүжилт авах эрхийг АХБ-ны улс орнуудын ангиллын дагуу тогтоодог. Санхүүжилт авах эрхтэй улс орнуудын хувьд, гүйцэтгэлд суурилсан хуваарилалтын бодлогын дагуу санхүүжилт олгох зарчим, шалгуурыг тодорхойлно.<sup>23</sup> АХС-аас санхүүжилт авах эрхтэй улс орон бүрийн гүйцэтгэлийн тоон үзүүлэлтийг оруулсан үнэлгээг эцэслэн боловсруулагдсаны дараа АХБ өөрийн цахим хуудсанд байршуулна. Улс орны бодлого болон институцийн үнэлгээний заавар зөвлөмжийг мөн АХБ-ны цахим хуудсанд тавина.

### Жилийн тайлан, эдийн засгийн тоо баримт болон судалгаа

78. АХБ нь Жилийн тайлан, Азийн хөгжлийн төлөв болон Гол үзүүлэлтүүд зэрэг эдийн засаг, нийгмийн тоо баримт, шинжилгээ болон судалгааг оруулсан тайланг өөрийн цахим хуудсанд байршуулна.

79. АХБ нь өөрийн цахим хуудсанд мөн цахим ном товхимол, хурлын баримт бичиг, тогтмол хэвлэл, тайлан, судалгааг тавина.

### Захиргааны болон бусад мэдээлэл

80. АХБ дараах баримт бичиг болон мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулна:

- (i) Азийн Хөгжлийн Банкныг байгуулах гэрээ (Чартер);
- (ii) АХБ-ны дотоод дүрэм журам;

- (iii) Азийн Хөгжлийн Банкны Захирагч нарын зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- (iv) Азийн Хөгжлийн Банкны Захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- (v) Азийн Хөгжлийн Банк болон Филиппин Улсын Засгийн газрын хооронд Азийн Хөгжлийн Банкны Төв байрны талаар байгуулсан гэрээ;
- (vi) гишүүн орны зөвшөөрсний дагуу АХБ болон гишүүн орны хооронд байгуулсан АХБ-ны Суурин төлөөлөгчийн газрын тухай гэрээ;
- (vii) АХБ-ны гишүүн орнуудын жагсаалт, тэдгээрийн нийслэл болон улс орнуудын санал өгөх эрх;
- (viii) АХБ-ны бүтэц зохион байгуулалт;
- (ix) Захирагч нарын зөвлөлийн гишүүдийн жагсаалт;
- (x) Захирлуудын зөвлөлийн гишүүдийн жагсаалт, тэдгээрийн санал өгөх эрх;
- (xi) Захирлуудын зөвлөлийн хороодын жагсаалт, тэдний гишүүд;
- (xii) АХБ-ны Удирдлага болон ахлах албан хаагчдын жагсаалт болон;
- (xiii) дээр дурьдсан бүгдийн холбоо барих мэдээлэл.

81. АХБ-ны жилийн уулзалтын хураангуй дүгнэлт, Захирагч нарын зөвлөлөөс гаргасан шийдвэрүүд, болон тэдний хэлсэн үг зэргийг жилийн уулзалт болж өнгөрснөөс 60 хоногийн дотор АХБ өөрийн цахим хуудсанд байршуулна. Захирлуудын зөвлөл зөвшөөрвөл мөн уг бодлогын хүчин төгөлдөр болох өдрийн дараа Захирагч нарын зөвлөлийн гаргасан бусад шийдвэрүүдийг мөн АХБ цахим хуудсандаа тавина.

82. Захирлуудын зөвлөл хэлэлцсэний дараа АХБ-ны үйл ажиллагааны хөтөлбөр болон төсвийн хүрээг АХБ өөрийн цахим хуудсанд байршуулна.

<sup>22</sup> АХБ. Азийн Хөгжлийн Банкны 1998 онд баталсан Зэрэглэл солигдох тухай бодлогын хяналт. Манила; АХБ. 1998. АХБ-ны ХБГО-уудын Зэрэглэл солигдох тухай бодлогын хяналт. Засвар 1. Манила.

<sup>23</sup> АХБ. 2008. Азийн Хөгжлийн сангийн нөөцийн гүйцэтгэлд суурилсан хуваарьлалтыг сайжруулах нь. Манила.

83. АХБ улс орнуудын ангиллыг Захирлуудын зөвлөл баталсны дараа өөрийн цахим хуудсанд байршуулна.

84. Захирлуудын зөвлөлийн хурлын тэмдэглэлүүд нууц байна.<sup>24</sup> Гэсэн хэдий ч, Захирлуудын зөвлөлийн хурлууд уг бодлогын хүчин төгөлдөр болох өдөр эсвэл өдрийн дараа хийгдсэн бөгөөд олон нийтэд ил гаргахгүй байх онцгой тохиолдлуудыг оруулаагүй ба хэлэлцээгүй бол тодорхой хүсэлтийн дагуу хурлын тэмдэглэлийг бүтэн эхээр нь 10 жилийн дараа ил гаргаж болно.

85. АХБ дараах мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулна: (i) ирэх 3 долоо хоногт Захирлуудын зөвлөлөөр хэлэлцэгдэх асуудлуудын урьдчилсан хуваарь, (ii) Захирлуудын зөвлөлийн байнгын хурлын протоколыг Захирлуудын зөвлөлөөр батлагдсаны дараа бөгөөд хурал болж өнгөрснөөс 60 хоногийн дотор багтаж тавина.

86. Захирлуудын зөвлөлийн хороодын Захирлуудын зөвлөлд тайланг зөвлөлийн зөвшөөрсний дагуу АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

### Санхүүгийн мэдээлэл

87. АХБ нь АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэр болон Тусгай сангуудын<sup>25</sup> аудитанд орсон санхүүгийн тайлангуудыг<sup>26</sup> Захирагч нарын жилийн уулзалтаас өмнө өөрийн цахим хуудсанд байршуулна.

88. Дараах мэдээллийг Захирлуудын зөвлөлөөр батлагдсаны дараа цахим хуудсанд байршуулна:

- (i) АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэр болон Тусгай сангуудын талаарх Сан тус бүрийн санхүүгийн тоо баримтыг оруулсан Удирдлагын хийсэн шинжилгээ болон хэлэлцүүлэг;

- (ii) аудитанд ороогүй улирал тутмын хураангуй санхүүгийн тайлан;
- (iii) хөгжиж буй гишүүн орнуудын зээлийн үйлчилгээний талаарх жилийн тайлан болон
- (iv) санхүүгийн жил болгоны АХБ-ны төсөв.

89. Холбогдох санхүүгийн зах зээлийн дүрэм журмын дагуу олон нийтийн саналтай холбоотой аливаа нэг баримт бичгийг засгийн газрын агентлагт хүргүүлэхийг шаарддаг бол АХБ үүнийг өөрийн цахим хуудсанд байршуулна.

### Ажлын байрны тухай мэдээлэл

90. АХБ нь дараах мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулна: (i) АХБ-ны цалингийн ерөнхий бүтэц, (ii) Удирдлага болон ажилчдын цалингийн түвшин болон бусад орлогыг тогтооход ашигласан арга, (iii) Удирдлага болон Захирлуудын зөвлөлийн гишүүдийн жилийн суурь цалин болон (iv) АХБ ажилчдаа сонгон шалгаруулах, ажлын байранд тавих, шилжүүлэх болон ажилчдаа байгууллагтаа үргэлжлүүлэн ажиллуулах талаар баримталдаг ерөнхий зорилго болон бодлого. АХБ мөн ажлын орон тоонд шинэ хүн авахаас дор хаяж 2 долоо хоногийн өмнө ажлын байрны тодорхойлолтыг өөрийн цахим хуудсанд байршуулна. АХБ-ны Захиргааны шүүхээс гаргасан шийдвэр болгоныг Захиргааны шүүхээс Нарийн бичгийн даргад шийдвэр гаргах мэдэгдэл өгсний дараа АХБ-ны цахим хуудсанд тавина.

### АХБ-ны Хариуцан тайлагнах механизмын доор гарсан мэдээлэл

91. Тухай бүрт нь шинэчилдэг АХБ-ны Хариуцан тайлагнах механизмын бодлогод тусгасны дагуу Хариуцан тайлагнах

<sup>24</sup> АХБ. 1966. Азийн Хөгжлийн Банкны Захирлуудын зөвлөлийн баримтлах дүрэм журам. Манила. 9 дүгээр хэсэг. Мөн энэхүү бодлогын 97 дугаар зүйлийг харна уу.

<sup>25</sup> Жишээ нь, АХС болон Техник туслалцааны тусгай сан.

<sup>26</sup> Захирагч нарын зөвлөл аудитанд орсон санхүүгийн тайлангуудыг Жилийн уулзалтан дээр хүлээн авдаг.

механизмын доор гарсан мэдээллийг АХБ өөрийн цахим хуудсанд байршуулна.

### Азийн хөгжлийн сангийн хэлэлцээртэй холбоотой мэдээлэл

92. АХС-ийг эргэн нөхөх хэлэлцээрүүд болон дунд хугацааны хяналттай холбоотой мэдээллийг АХБ өөрийн цахим хуудсанд байршуулдаг. Доноруудын уулзалтын санхүүгийн бус асуудлаарх хэлэлцэх баримт бичгүүдийг доноруудад хэлэлцүүлгийн өмнө танилцуулах үед өөрийн цахим хуудсанд тавина. Доноруудад зориулсан тайланг Захирлуудын зөвлөл баталсны дараа цахим хуудсанд байршуулна.

### Захирлуудын зөвлөлд танилцуулдаг бусад баримт бичгүүд

93. Захирлуудын зөвлөлд мэдээлэл болгох болон батлуулахаар танилцуулж буй уг бодлогод дурьдаагүй баримт бичгүүдийг Удирдлагын зүгээс өөрөөр зааварчлаагүй бол мөн Захирлуудын зөвлөл зөвшөөрвөл АХБ-ны цахим хуудсанд байршуулна.

### Мэдээллийг олон нийтэд ил гаргах бодлогод үл хамаарах онцгой тохиолдлууд

94. Мэдээллийг олон нийтэд ил гаргах АХБ-ны бодлогод үл хамаарах онцгой тохиолдлуудыг 97 болон 101 дүгээр зүйлд тусгасан болно. Уг жагсаалтыг АХБ мэдээллийг ил гаргахад тодорхой сонирхлын бүлгүүдэд үүсэх хор хөнөөл нь ил гаргахаас үүдэх үр ашгийг давна гэж тодорхойлсны үндсэн дээр гаргасан болно.

95. Хэрэв АХБ-ны цахим хуудсанд байршуулах баримт бичиг (эсвэл түүний нэг хэсэг) бодлогод үл хамаарах онцгой тохиолдлуудад хамаарч байгаа учраас цахим хуудсанд тавигдахгүй бол, АХБ тухайн баримт бичиг эсвэл түүнээс гарган гарган авсан мэдээллийг<sup>27</sup> дурьдсанаар онцгой тохиолдлуудыг зөрчихгүй бол тэдгээрийг дурьдана. Хэрэв хүсэлтийн дагуу олгох байгаа аливаа нэг баримт бичиг доторх мэдээллийн тодорхой хэсэг нь онцгой тохиолдлуудад хамаарч байвал, тухайн мэдээллийг баримт бичгээс гаргах ба үүнийг хийсэн шалтгааныг хүсэгчид мэдэгдэнэ.<sup>28</sup>

96. АХБ нь нэг хувь хүн, байгууллага, эсвэл бүлгээс давтан эсвэл утга учиргүй ирж буй мэдээллийн хүсэлтэд урьд нь хариу илгээсэн эсвэл мэдээллийг гаргах боломжгүй шалтгаанаа тайлбарласан бол тэдгээрт хүссэн мэдээллийг өгөх эсвэл хариу илгээх албагүй юм.

### Одоогийн мэдээлэл

97. 99 дүгээр заалтын дагуу АХБ нь дараах мэдээллийг ил гаргахгүй болно:

#### Хянан үзэх болон шийдвэр гаргах үйл ажиллагааны үеэр

- (i) Ил гаргасан тохиолдолд дотоод Захирагч нар, тэдний орлогчид, Захирлуудын зөвлөлийн гишүүд, захирлуудын зөвлөхүүд, Удирдлага, АХБ-ны ажилтан, албан хаагчид болон АХБ-ны зөвлөхүүдийн хооронд баримт бичиг, санамж бичиг эсвэл ижил төрлийн өөр мэдээ мэдээлэл, санааг чөлөөтэй солилцоход саад учруулах замаар АХБ-ны хянан үзэх болон шийдвэр гаргах үйл

<sup>27</sup> Буцаан татсан баримт бичиг буюу мэдээллийг иш татан дурьдахдаа холбогдох цахим хуудсанд тус мэдээллийг байршуулах ба ингэхдээ буцаан татсан баримт бичиг, мэдээллийн нэрийг оруулна.

<sup>28</sup> 84 дүгээр зүйлд дурьдсанчлан, Захирлуудын зөвлөлийн уулзалтын тэмдэглэлийг буулган тавихгүй. Бодлогод хамаарахгүй онцгой тохиолдлуудад хамаарах мэдээлэл багтсан бол үүнийг ил гаргахгүй.

ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх дотоод мэдээлэл.

- (ii) Олон нийтэд ил гарвал АХБ болон түүний гишүүн орнууд, АХБены хамтран ажилладаг бусад байгууллагуудын хооронд хэлэлцээр хийх болон шийдвэр гаргах явцад, ялангуяа хөгжиж буй гишүүн орнуудтай бодлогын яриа хэлэлцээр явуулах үед санаа, харилцаа холбоог ил тод нээлттэй бус болгох замаар саад учруулж болзошгүй, АХБ, түүний гишүүн орнууд, хамтран ажилладаг байгууллагуудын хоорондын хэлэлцээр хийх, шийдвэр гаргахад зориулан бэлтгэсэн мэдээлэл.
- (iii) Захирлуудын зөвлөлийн баримт бичгүүд.<sup>29</sup> Үүнд хурлын үгчлэн буулгасан тэмдэглэл (84 дүгээр зүйлд тусгагдсаны дагуу), Зөвлөлийн хурлын протокол болон Зөвлөлийн зарим хурлын ахлагчийн тэмдэглэлийн хураангуй (40 болон 74 зүйл) орохгүй.

#### **Нууц байдлаар олгосон мэдээлэл**

- (iv) Гишүүн орон эсвэл бусад олон улсын байгууллагаас нууц байдлаар АХБ-нд олгосон бөгөөд ил гарвал тухайн улс орон, байгууллагатай харьцах АХБ-ны харилцаанд бодитоор сөрөг нөлөө учирч болзошгүй мэдээлэл.
- (v) АХБ-нд аливаа этгээдээс олгосон бөгөөд хэрэв ил гарвал тухайн этгээдийн арилжаа, санхүүгийн сонирхол бөгөөд өрсөлдөх чадварыг бууруулж болзошгүй мэдээлэл (үүнд өмчлөлтэй холбоотой мэдээлэл орно) эсвэл өөр аливаа нэг бизнес мэдээлэл (АХБ-ны түнш эсвэл бусад холбогдох байгууллагатай хийсэн нууцлалын гэрээ эсвэл мэдээлэл ил гаргахгүй байх тохиролцоо).

- (vi) АХБ-нд нууц байдлаар олгосон, авлига, хээл хахууль эсвэл АХБ-ны Авлигын эсрэг бодлогыг өөр байдлаар зөрчсөн байж болзошгүй тухай мэдээлэл, хэрвээ АХБ-ны ажилчдын дүрэм болон мөрдөх ажиллагааны дүрэм, болон тухайн мэдэгдлийг хийсэн этгээдийн мэдээллийн дагуу зөвшөөрөгдсөн хэмжээнд.

#### **Хувийн мэдээлэл**

- (vii) Захирлуудын зөвлөлийн гишүүд, Захирлуудын зөвлөх, Удирдах багийн гишүүд, АХБ-ны ажилчид болон зөвлөхүүдтэй холбоотой хувийн мэдээлэл, учир нь ийм мэдээллийг ил гаргах нь тухайн хувь хүний хууль ёсны хувийн эрх чөлөөнд халдсан эсвэл халдаж болзошгүй байх юм. Уг мэдээлэлд хөдөлмөрийн гэрээний нөхцөл, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ болон Захирлуудын зөвлөлийн гишүүд, Захирлуудын зөвлөх, Удирдах багийн гишүүд, АХБ-ны ажилчид болон зөвлөхүүдийн хувийн эрүүл мэндийн мэдээлэл, ажилтнаар орсон болон шалгарсантай холбоотой мэдээлэл, хувийн харилцаа холбоо болон дотоод зөрчлийг шийдвэрлэх, санал гомдол, мөрдөн байцаалттай холбоотой тухайн ажилчны зөвшөөрсөн хэмжээнээс, эсвэл ажилчдын дүрэм, Захирлуудын зөвлөлийн дүрэм журмаар зөвшөөрөгдснөөс бусад мэдээлэл.

#### **Санхүүгийн мэдээлэл**

- (viii) Ил гарсан тохиолдолд АХБ болон түүний үйл ажиллагааны хууль ёсны санхүү, худалдааны ашиг сонирхлыг зөрчих буюу зөрчиж

<sup>29</sup> Энэ бодлогын зорилгод нийцүүлэхээр, Захирлуудын зөвлөлийн хурлын тэмдэглэл гэдэг нь Захирлуудын зөвлөл эсвэл тэдгээрийн салбар зөвлөлийн хурлыг илтгэх бөгөөд Захирлуудын зөвлөлийн хурлын үеэр хийгдсэн үгчлэн буулгасан тэмдэглэл, хурлын протокол% АХБ-ны удирдлага, газрууд, Нарийн бичгийн дарга болон Захирлуудын хооронд харилцсан цахим, бичгэн зэрэг бүхий л харилцаа холбоо зэрэг бүх мэдэгдэл, тэмдэглэлүүдийг багтаана.

болзошгүй санхүүгийн мэдээлэл эсвэл хөрөнгө, санхүүгийн зах зээлүүд мэдрэмтгий байж болзошгүй санхүүгийн мэдээлэл. Үүнд АХБ-ны ирээдүйд авах зээл, санхүүгийн урьдчилсан таамаг, АХБ-ны сангийн үйл ажиллагаа, зээлийн үнэлгээ, зээлжих чадварын дүн шинжилгээ, зээлжих зэрэглэл болон зээлдэгч нар болон бусад түншүүдийн эрсдэлийн үнэлгээ зэрэг мэдээлэл үүнд орно.

- (ix) Ил гарсан тохиолдолд холбогдох гишүүн орны эдийн засгаа удирдах чадварт сөрөг нөлөө үзүүлэх эсвэл үзүүлж болзошгүй санхүүгийн мэдээлэл.

#### **Аюулгүй байдал**

- (x) Олон нийтэд ил гаргасан тохиолдолд аливаа нэг хүний амь нам, эрүүл мэнд, аюулгүй байдал болон АХБ-ны хөрөнгөд аюул ачруулах буюу учруулж болзошгүй, гишүүн орны батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдалд хор хөнөөл учруулах буюу учруулж болзошгүй мэдээлэл.

#### **Хууль зүй болон мөрдөн байцаах үйл ажиллагаа**

- (xi) Хуульч, өмгөөлөгч болон үйлчлүүлэгчийн давуу эрхээс хамаарах аливаа мэдээлэл (үүнд АХБ-ны хуулийн зөвлөх эсвэл АХБ-ны хөлсөлсөн хуулийн зөвлөх), болзошгүй луйвар, авилга, мөрдөн байцаах үйл ажиллагааны тухай

АХБ-ны дүрэм журмын дагуу буюу түүнд зөвшөөрөгдсөн хэмжээнээс давах сахилгын зөрчлийн мөрдөн байдаах ямарваа нэг үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл; эсвэл ил гарсан тохиолдолд мөрдөн байцаах үйл ажиллагаа, хуулийг биелүүлэхэд саад учруулах буюу учруулж болзошгүй, холбогдох хууль зөрчих мэдээлэл.<sup>30</sup>

#### **Дотоод аудитын тайлангууд болон тусгай сангуудын аудитын тайлангууд<sup>31</sup>**

- (xii) (a) Гурав дагч талууд АХБ-ны эсрэг ашиглаж болзошгүй АХБ-ны дотоод бүтцийн талаар мэдээлэл агуулж болзошгүй байдаг<sup>32</sup> тул АХБ-ны Ерөнхий аудиторын зүгээс гаргасан дотоод аудитын тайлангууд болон (б) АХБ-ны захиран зарцуулдаг тусгай сангуудад гаргасан бөгөөд олон нийтэд ил гаргавал тухайн аудитын хэм хэмжээг зөрчих хөндлөнгийн аудитын зарим тайлангууд.<sup>33</sup>

#### **Түүхэн мэдээлэл**

98. АХБ-ны дэмжлэгтэй төсөл, хөтөлбөр, бодлого, стратеги болон ерөнхий үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл АХБ-аас анх гаргасан эсвэл АХБ-нд олгосноос хойш 20 жил өнгөрсөн тохиолдолд тухайн мэдээллийг түүхэн мэдээлэл гэж үзнэ. Захирлуудын зөвлөлийн хурлын тэмдэглэлээс бусад түүхэн мэдээллийг хүсэлтийн дагуу ил гаргана.<sup>34</sup> Үүнд 97 дугаар зүйлийн (iv)–(vii), (ix)–(xi), болон (xii)(б) хэсэгт заасан онцгой тохиолдлууд хамаарахгүй.

<sup>30</sup> Секюритиз болон банкны тухай хууль, зохиогчийн эрхийн тухай хууль үүнд хамаарч болно.

<sup>31</sup> АХБ-ны Жилийн тайлангийн нэг хэсэг болон олон нийтэд ил гаргасан аудитын санал болон аудитанд орсон санхүүгийн баримт бичиг нь энэ онцгой тохиолдолд хамаарахгүй (87 дугаар зүйл).

<sup>32</sup> АХБ-ны дотоод аудит болон өндөр, дунд зэргийн эрсдэдтэй гэсэн аудитын дүгнэлтүүдийн гол хэсгийг Захирлуудын зөвлөлийн Аудитын Хороотой хуваалцана.

<sup>33</sup> Хэрэв төслийг өөр шат дамжлагаар батлах шаардлагагүй бол, уг баримт бичгийг Засгийн газрын хүрээний төслүүдийн хувьд удирдлагын хяналтын уулзалт эсвэл ажилчдын хяналтын уулзалтын өмнө, Засгийн газрын бус хүрээний төслүүдийн хувьд хөрөнгө оруулалтын хорооны эцсийн уулзалтын өмнө тавина.

<sup>34</sup> Захирлуудын зөвлөлийн хурлын тэмдэглэл нь 40, 74, 84 болон 85 дугаар зүйлийн заалттай нийцүүлэн олон нийтэд ил гаргана.

### Олон нийтийн эрх ашиг давамгайлах (Эерэг давамгайлах)

99. Олон нийтэд ил гаргах мэдээллийн төрлийн талаарх 97 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан, холбогдох талууд АХБ-ыг аливаа мэдээллийг олон нийтийн эрх ашгийн төлөө ил гаргахыг шаардаж болно. МНХЗХ эдгээр хүсэлтийг хүлээн авна. Мэдээллийг ил гаргаснаар олон нийтэд гарах эрх ашиг нь ил гаргаснаар гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс давамгайлсан байвал АХБ тухайн мэдээллийг ил гаргаж болно. Тухайн мэдээллийг ил гаргах эсвэл хүсэлтийг няцаах аливаа нэг зөвлөмжийг МНХЗХ гаргахдаа Захирлуудын зөвлөлийн баримт бичгийн хувьд Захирлуудын зөвлөлийн зөвшөөрлийг, бусад баримт бичгэн дээр Ерөнхийлөгчийн зөвшөөрлийг авна.

100. Гэхдээ АХБ аливаа нэг мэдээллийг олон нийтэд ил гаргахгүй гэсэн амлалтыг аливаа нэг тал хуулийн хүрээнд хүлээсэн бөгөөд тухайн тал ил гаргахыг зөвшөөрөөгүй тохиолдолд олон нийтийн эрх ашиг давамгайлах тохиолдол үйлчлэхгүй.

### Мэдээллийг хязгаарлах АХБ-ны эрх (сөрөг давамгайлах)

101. АХБ нь мөн тухайн мэдээллийг ил гаргаснаар гарах эсвэл гарч болзошгүй сөрөг нөлөөлөл нь мэдээллийг гаргаснаар гарах эерэг нөлөөллөөс илүү байна гэдгийг тогтоовол бусад тохиолдолд ил гаргадаг мэдээллээ ил гаргахгүй байх эрхтэй. Энэхүү эрхийг зөвхөн Захирлуудын зөвлөл эдэлнэ. ■

# Олон нийттэй харилцах арга барил

## 7

Олон нийттэй харилцах бодлого 2011

102. Энэхүү бодлогын зорилтуудад хүрэхийн тулд олон нийттэй харилцах идэвхтэй арга барил барих нь чухал. Харилцагч талуудтай доорх арга барилаар харилцвал зүйтэй.

103. АХБ-ны тэргүүлэх зорилт болон харилцагч талуудын хүлээлт өөрчлөгдөхийн хэрээр АХБ өөрийн олон нийттэй харилцах бодлогыг үргэлжлүүлэн сайжруулна. Үүнд:

- (i) хүрэх талуудынхаа хэрэгцээ шаардлагад тохирсон үр дүнтэй, тогтвортой, нэгдмэл олон нийттэй харилцах арга барилыг хэрэгжүүлнэ,
- (ii) ядуурлыг бууруулах, хүртээмжтэй өсөлтийг дэмжих хэтийн зорилгоо бусдад таниулах, болон мэдлэгийг түгээгч банк болон бүс нутагт хөгжлийн асуудлаар тэргүүлэгч дуу хоолой болохыг харуулах,
- (iii) Төрөл бүрийн арга, туршлагыг ашиглах, үүнд сүүлийн үеийн технологи болон мэдээллийн хэрэгсэл болон уулзалт, орчин үеийн техник технологи шаардахгүй арга хэрэгсэл багтана,
- (iv) Олон улс, бүс нутаг болон улс орны мэдээллийн хэрэгслүүдээр олон цацагдах,
- (v) Төслийн хүрээнд олон нийттэй харилцах харилцааг сайжруулан, стратегийн харилцааг (үүнд гамшгийн харилцаа багтана) бэхжүүлэх болон хамтарсан төслүүдийн хувьд түншлэгч талуудтай олон нийттэй харилцах ажлыг хамтран зохион байгуулах, мөн
- (vi) Байгууллагын дотоод харилцаа болон ажилчдын гадаад харилцааны ур чадварыг дээшлүүлэх зэрэг орно.

## Зорилтот харилцагч талууд

104. АХБ нь ХБГО болон зээлдэгч бус гишүүн орнуудынхаа олон талуудтай харилцахыг зорьдог. АХБ-ны гол зорилтот харилцагч талуудад: (i) ХБГО болон зээлдэгч бус гишүүн орнуудын засгийн газрууд, оюун санааны удирдагч, парламентын гишүүд зэрэг шийдвэр гаргагч нар, (ii) хэвлэл мэдээллийн байгууллагынхан, (iii) нөлөөлөлд өртсөн иргэд зэрэг иргэний нийгмийн байгууллагууд, болон (iv) эрдэмтэн судлаач нар багтана. АХБ нь эдгээр талуудад гарсан өөрчлөлт, тэдний санаа бодол, хүлээлтийг хянаж, олон нийттэй харилцах өөрийн бодлогод шаардлагатай өөрчлөлтийг хийнэ.

## Зорилтот харилцагч талуудад хүрэх арга барил

105. АХБ нь гурван жилд нэг удаа хийдэг АХБ-ны талаарх ойлголтын талаарх судалгаа зэрэг олон нийтийн санал бодлыг авах судалгаа, асуулгыг үргэлжлүүлэн авах ба олон нийттэй харилцах өөрийн үйл ажиллагааг цаашид тасралтгүй сайжруулахын тулд албан болон албан бус байдлаар санал авах төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглана.

106. АХБ нь зорилтот талуудтай харилцах, тэдгээрт хүрэхийн тулд харилцаа холбооны төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглах ба үүнд олон нийтийн болон цахим мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас, сошиал медиа зэрэг мэдээллийн шинэ хэрэгсэл, орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, гар утас, цахим видео, дүрс бичлэг, зураг, ном товхимол болон тусгай үйл ажиллагаа орно.



107. Уулзалт, танилцуулга, прэзэнтэшн зэрэг нүүр тулсан, уламжлалт харилцааны арга зам болон зурагт хуудас, танилцуулах хуудас, брошур зэрэг хэрэгсэл нь мөн техник технологи, олон нийтийн мэдээллийн хэрэгслээс хол байгаа талуудтай харилцах чухал арга зам хэвээр байна. АХБ нь олон нийттэй харилцах өөрийн бодлогыг мөн харилцах талуудынхаа уламжлал, ёс заншилд нийцүүлнэ.

108. АХБ нь өөрийн үйл ажиллагаа, хэтийн зорилго, бодлого, төсөл хөтөлбөр болон мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийн талаарх мэдээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд мэдээллэхийн тулд хэвлэл мэдээлэлтэй харилцах идэвхтэй бодлого баримтлан өөрийн мэдээг олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр их хэмжээгээр цацагдсан байхыг зорино. Үүний зэрэгцээ, АХБ нь өөрийн үйл ажиллагааг бүс нутаг болон улс орнуудын мэдээллийн хэрэгслээр цацах хүрээг нэмэхээр ажиллана.

109. АХБ нь төслийн хүрээний олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулж, хамтарсан төслүүдийн хувьд түнш байгууллагатайгаа энэ тал дээр нягт хамтран ажиллана.

110. АХБ нь өөрийн гадаад цахим хуудсанд АХБ болон түүний үйл ажиллагааны талаар аль болох их хэмжээний мэдээллийг тавина. Цахим хуудсыг хэрэглэгчдийн хүлээлт, шаардлагад нийцүүлэхийн тулд байнга сайжруулна. АХБ мөн өөрийн гаргадаг ном товхимол, хөгжлийн тухайн мэдлэг мэдээллийг аль болох өргөн хүрээнд хүргэхийн тулд болон бүс нутагт мэдлэгт суурилсан эдийн засгуудыг хөгжүүлэх зорилгын хүрээнд тэдгээрийг ХБГО-уудын хэл рүү хөрвүүлэх зэрэг замаар өөрийн ном товхимол хэвлэх хөтөлбөрийг сайжруулна. АХБ нь мэдлэгийн гол бүтээгдэхүүнүүдээ өөрийн гэрээт номын

сангуудын хөтөлбөрөөр дамжуулан түгээх ажлыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ АХБ-ны ном товхимлуудын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үр нөлөөтэй арга замыг эрэлхийлнэ. Мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг цахим болон хэвлэмэл байдлаар түгээхийн дээр АХБ мөн бүс нутаг болон улс орны хэмжээний хурал зөвлөлгөөн болон бусад арга хэмжээгээр дамжуулан мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг түгээн, засгийн газрын албан хаагч, бусад гол харилцагч талуудтай санал бодол солилцоно.

## Орчуулга

111. Англи хэл бол АХБ-ны ажлын хэл юм.<sup>35</sup> Гэсэн хэдий ч АХБ-ны дэмжлэгтэй үйл ажиллагааны талаарх харилцагч талууд болон бусад хүмүүсийн ойлголтыг сайжруулах, тэдгээрийн дэмжлэгийг авах, оролцоог дэмжих зорилгоор баримт бичиг болон бусад мэдээллийг нэлээд тохиолдолд бусад хэл рүү хөрвүүлэх шаардлагатай байдаг.<sup>36</sup>

112. АХБ нь 2007 онд баталсан орчуулгын хүрээний дагуу орчуулга хийнэ. Ийнхүү орчуулах баримт бичигт: (i) АХБ-ны ерөнхий үйл ажиллагаа, бодлого болон стратегийн чиглэлийг хамарсан бөгөөд олон улсын хэмжээний өргөн хүрээний харилцагч талуудад чиглэсэн, (ii) олон нийттэй зөвлөлдөх үйл ажиллагаанд, тэр дундаа төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвлөлдөхөд зориулагдсан (47 дугаар зүйл), (iii) тодорхой улс орон, төсөл, хөтөлбөртэй холбогдсон, (iv) АХБ-ны цахим хуудсанд зориулагдсан мэдээллийг оруулж болно. Аливаа баримт бичгийг орчуулах эсэх шалгуурт зорилтот талуудын бичиг үсэг тайлагдсан байдал, тэдгээр талын мэдэх хэл, орчуулгыг орлуулж болох өөр арга зам, орчуулгад шаардлагатай цаг хугацаа болон зардал зэргийг оруулан тооцно. ■

<sup>35</sup> АХБ. 1966. Азийн Хөгжлийн Банкнийг байгуулах тухай гэрээ. Манила (39.1. дүгээр зүйл).

<sup>36</sup> Англи хэл дээрх болон аливаа хэл рүү орчуулсан хувилбарын хооронд ямарваа нэг зөрөө гарвал Англи хэл дээрх хувилбарыг зөв гэж үзнэ.

# Хэрэгжүүлэх арга зам

## 8

Олон нийттэй  
харилцах  
бодлого 2011

### Үүрэг ба хариуцлага

#### Удирдлага

113. АХБ-ны олон нийттэй харилцах хүчин чармайлтын үр дүнг сайжруулахын тулд үүнийг хянах болон манлайлан чиглүүлэхэд удирдлагын гүйцэтгэх үүрэг нь нэн чухал билээ. Удирдлага нь олон нийттэй харилцах үйл ажиллагаанд оролцох бөгөөд ажилтан албан хаагчид Удирдлагын үзэл бодол болон байр суурийг мэдэж байхын тулд байгуулага доторх харилцааг нээлттэй бөгөөд үр нөлөөтэй байлгахыг хөхиүлэн дэмжинэ. ОНИТБЗХ нь бодлогын олон нийтэд ил гаргах шаардлагуудыг тайлбарлах, хянах болон эргэн харахад Удирдлагад мэдээлэл олгох үүрэгтэй.

#### Бүх газар, алба

114. АХБ-ны бүх газар, алба энэхүү бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. АХБ-ны олон нийттэй харилцах гол хүмүүс болох газар, албадын дарга болон улс орон дахь суурин төлөөлөгч, төлөөлөгчийн газруудын тэргүүн нар гадны түнш, харилцагч нартай идэвхтэй харилцаж, АХБ-ны үйл ажиллагааны сэдэл болон зорилгын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, харилцагч талуудын итгэлийг бий болгох хүчин чармайлтыг тэргүүлэх хэрэгтэй. Үйл ажиллагааны газруудын ажилчид төслийн холбогдолтой харилцагч нартай харилцах, мэдээллийг олон нийтэд ил гаргах шаардлагын биелэлтийг хангахад гол үүргийг гүйцэтгэнэ. Тэд мөн олон нийт, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудын хүмүүсийн дунд АХБ-ны

олон нийттэй харилцах бодлого болон бодлогын дагуу АХБ-с мэдээллээ олж авах олон нийтийн эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ. АХБ-ны ТББ болон Иргэний нийгмийн төв нь иргэний нийгэмтэй харилцах харилцааг дэмжин ажиллана. Мэдлэг хариуцсан газрууд болон Гадаад харилцааны газар нь мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг түгээх ажлыг илүү оновчтой болгоход хамтран ажиллана.

#### Гадаад харилцааны газар

115. ГХГ нь бодлогын хэрэгжилт болон тогтвортой хэрэглээг хангах үүрэгтэй. ГХГ нь олон нийттэй харилцах ажиллагааг идэвхтэй явуулах болон гадаад түнш, харилцагч нартай үр нөлөөтэй харилцах чиглэлээр Удирдлага, газар, албад болон төлөөлөгчийн газруудтай ойр хамтран ажиллана. Бодлогын хэрэгжилтийг илүү сайн дэмжихээр боломжит нөөцийнхөө хүрээнд өөрийн үр нөлөөг хамгийн дээд түвшинд авчрахын тулд ГХГ нь өөрийн дотоод ажил үүргийг сайжруулан, функцийг эрэмбэлнэ.

#### Олон нийтэд ил гаргах

116. ГХГ нь АХБ-ны ажилчид хоорондоо нээлттэй харилцах соёлыг дэмжин, мэдээллийг идэвхтэй хуваалцах урамшууллыг хөгжүүлнэ.

117. ГХГ-ын доторх Олон нийтийн мэдээлэл, мэдээллийг ил гаргах нэгж нь АХБ-ны бүх газар, албад зөвлөгөө өгч, бодлогын мэдээллийг олон нийтэд ил гаргах шаардлагуудын хэрэгжилтийг хянана. Энэхүү нэгж нь мөн үйл ажиллагааны газарт ажилладаг албан хаагчдад зориулж

мэдээллийг олон нийтэд ил гаргах шаардлагуудын талаар зайлшгүй хамрагдах шаардлагатай сургалтыг боловсруулан явуулж, АХБ-ны зүгээс ОНХ бодлогыг мөрдөх түлхэцийг ажилчдад өгсөөр байх болно. ГХГ нь мөн ОНИТБЗХ-ын ажилд дэмжлэг үзүүлэн, бодлогын хэрэгжилтийн тухай явцын хяналтын тайлангуудыг ОНИТБЗХ-д олгоно (142 дугаар зүйл). Уг нэгж нь АХБ-ны цахим хуудсанд байгаа үйл ажиллагааны баримт бичгүүдийн талаар олон нийтэд мэдээллэхээс гадна бодлогын шаардлагуудын дагуу хүсэлтүүдийг бүртгэх тогтолцоог хэрэгжүүлнэ.

118. Цахим хуудас хариуцсан баг нь дээрх нэгж болон АХБ-ны газар, албадтай хамтран баримт бичгүүдийг цахим хуудсанд байршуулах, АХБ-ны цахим хуудасны мэдээлэл хайх функцийг сайжруулна.

### Орчуулга

119. 2007 онд мөрдөж эхэлсэн орчуулгын систем нь АХБ англи хэлээс бусад хэл дээрх мэдээллийн олдцыг нэмэгдүүлэх арга замуудыг тодорхойлжээ. Энэхүү систем болон түүнд хамаарах нөөцийг 2011 онд эргэн үзнэ.

120. ГХГ нь АХБ доторх орчуулгын төслүүдийг удирдан хэрэгжүүлж, орчуулсан баримт бичгүүдийг олон нийтэд нээлттэй болгох болон ГХГ-аар дамжуулан орчуулсан баримт бичгүүдийн нэрсийг бүртгэх ажлыг хийнэ. Суурин төлөөлөгчийн газар ГХГ-ын дэмжлэгтэйгээр шаардлагад нийцсэн орчуулагч болон тухайн улс оронд хэрэглэгддэг хэл(үүд)-ний мэдлэгтэй хоёр хэлний редактор нарын жагсаалтыг гарган хадгална. ГХГ нь АХБ доторх газар, албадын хэрэглэж болох орчуулгын үйлчилгээний талаарх тэдний мэдлэгийг дээшлүүлнэ.

### Мэдээллийг олон нийтэд ил гаргах гарын авлага болон мэдээлэл олгох ном товхимлууд

121. ГХГ нь Олон нийттэй харилцах бодлогын дагуух Ажилчдад зориулсан мэдээллийг олон нийтэд ил гаргах талаар гарын авлагыг<sup>37</sup> үйл ажиллагааны тухай мэдээлэл болон баримт бичгийг олон нийтэд ил гаргах АХБ-ны ажилчдад зориулсан шат нэг болгоны зааварчилгааг оруулан шинэчилнэ. АХБ-ны зээлдэгч, түншүүдэд бодлогыг хэрэгжүүлэх зааварчилгааг өгөх, бусад сонирхож буй харилцагч талуудад бодлогын тухай мэдээлэл олгох ном товхимлуудыг боловсруулан шаардлага гарсан тухай бүрт нь шинэчилнэ. Эдгээр бүх баримт бичгийг АХБ-ны цахим хуудсанд байршуулж, тухайн улс оронд түгээнэ.

### Улс орны түвшний мэдээллийг түгээх

122. АХБ нь мэдлэгийн гол бүтээгдэхүүнүүдээ АХБ-ны гэрээт номын сангийн хөтөлбөрөөр дамжуулан цаашид олон нийттэй үргэлжлүүлэн хуваалцана. АХБ-ны олон нийттэй харилцах үйл ажиллагааны гол тулх нь АХБ-ны ном товхимлуудын талаарх ойлголт мэдлэг, олон нийтэд хүрэх хүртээмжийг сайжруулах болон АХБ-ны үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэмэгдүүлэх юм. Судалгаа шинжилгээний байгууллага, их дээд сургуулиуд болон хөгжлийн бусад түншүүдтэй шинэ түншлэлийг бий болгохыг АХБ хөгжиж буй гишүүн орнууддаа чухалчилна.

### Мэдээллийг авах журам

123. Төлөөлөгчийн газрууд болон суурин төлөөлөгчийн газрууд нь харилцагч талуудтай ойр байдгийн зэрэгцээ үйл ажиллагаа болон эдийн засгийн чадавх болон тухайн орон,

<sup>37</sup> Ажилчдад зориулсан мэдээллийг олон нийтэд ил гаргах талаар гарын авлага: <http://www.adb.org/Documents/Handbooks/Disclosure/>

бүс нутгийн соёл, харилцааны онцлогийг ойлгодог учраас олон нийттэй харилцах үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулахад тэргүүн зэргийн үүрэгтэй.

124. Төлөөлөгчийн газрууд болон суурин төлөөлөгчийн газруудын тэргүүн нар нь олон нийттэй харилцах АХБ-ны гол хүмүүс бөгөөд АХБ-ны хэвлэл мэдээлэл, бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагч нартай харьцах харилцааг өргөжүүлэн бэхжүүлэх ажлыг манлайлна.

125. АХБ нь суурин төлөөлөгчийн газрууд дахь олон нийттэй харилцах ажилтнуудын тоог нэмэгдүүлэх бүхий л хүчин чармайлтыг гаргана. Тэд суурин төлөөлөгчийн газруудын тэргүүн нарт мэргэжлийн дэмжлэг, зөвлөгөө өгч, суурин төлөөлөгчийн газрын удирдлагын багийн нэг хэсэг болж, тэнд болж байгаа бүхий л үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээлэлтэй байна. Суурин төлөөлөгчийн газрууд дахь олон нийттэй харилцах ажилтнуудын ажлын тодорхойлолт болон мэргэжлийн шаардлага ижил байх бөгөөд тогтмол, тодорхой бүтэц төлөвлөгөө бүхий сургалтанд хамрагдана.

126. Суурин төлөөлөгчийн газрууд дахь олон нийттэй харилцах ажилтнуудын гол ажил үүрэгт дараах ажил орно: (i) АХБ-ны өндөр албан тушаалтнуудын төр, хувийн хэвшлийн өргөн хүрээний харилцааг зохицуулан чиглүүлэхийн тулд тэдгээр бүлэгтэй харилцаа тогтоож, хөгжүүлнэ, (ii) АХБ-ны төлөөлөгч болон АХБ-ны тухай мэдээллийг тухайн улс орон болон олон улсын хэвлэлийхэнд тогтмол нээлттэй хүртээмжтэй байлгах, (iii) АХБ-нд хамааралтай асуудлуудын тухай орон нутгийн, үндэсний болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Англи болон тухайн улс орны хэлээр гарсан мэдээлэлд мониторинг хийх, (iv) энэхүү бодлогын мэдээллийг олон нийтэд ил гаргах шаардлагын биелэлтийг хангахад суурин төлөөлөгчийн газруудын ажилтан болон тухайн орны иргэд, олон нийтэд тусална. Мэдээлэл солилцохын ашиг

тусыг дээд хэмжээнд хүргэн нэмэгдүүлэх болон нэгэн жигд үйл ажиллагааг хангах үүднээс төлөөлөгчийн газрууд дахь олон нийттэй харилцах ажилчид болон тэдгээртэй харилцдаг ГХГ-ын ажилчид биечлэн, видео хурлаар болон цахим арга хэрэгслийг ашиглан тогтмол уулзана. Суурин төлөөлөгчийн газрын олон нийттэй харилцах ажилчид тухайн улс орон эсвэл бүс нутаг хариуцсан захирал бөгөөд ГХГ-д давхар тайлагнан ажиллана.

### Олон нийтэд ил гаргах асуудлаарх зөвлөх хороо

127. ОНИГАЗХ нь бодлого доторх мэдээллийг олон нийтэд ил гаргах шаардлагад тайлбар гаргах, хянан, эргэн үзэх зэрэг үүрэгтэй. ОНИГАЗХ нь Удирдах ерөнхий дарга (хорооны дарга), ГХГ-ны Ерөнхий захирал, нарийн бичгийн дарга болон ерөнхий зөвлөхөөс бүрдэнэ. Уг хороо нь шууд Ерөнхийлөгчид тайлагнана. Уг хороо нь АХБ-ны бусад газар, албадуудын олгохоос татгалзан хүсэлтийг эргэн үзэх шаардлага гарах үед цуглана. ОНИГАЗХ нь мэдээллийг олгохгүй байх шийдвэрийг баримтлах эсвэл эргүүлэх эрх мэдэлтэй бөгөөд харин үүнд Захирлуудын зөвлөлөөс нэвтрэхийг хориглосон шийдвэрүүд багтахгүй болно (101 дүгээр зүйл). ОНИГАЗХ нь мөн бодлогод хамаарахгүй онцгой тохиолдлуудын доорх мэдээллийг ил гаргах хүсэлтийг бодолцон үзнэ (99 дүгээр зүйл). ГХГ дахь Олон нийтийн мэдээлэл болон ил гаргах асуудал хариуцсан хэлтэс нь мөн ОНИГАЗХ-д нарийн бичгийн үүрэг гүйцэтгэн дэмжлэг үзүүлнэ. ОНИГАЗХ нь Олон нийттэй харилцах бодлогын мэдээллийг олон нийтэд ил гаргах шаардлагын хэрэгжилтийг үнэлэхээр Олон нийттэй харилцах бодлогын жилийн тайланг хянан, батална. Уг жилийн тайланд мэдээллийг олон нийтэд ил гаргах аас татгалзсан тохиолдлуудын хураангуй болон бодлого, Үйл ажиллагааны гарын авлагын түүнтэй холбоотой хэсгүүд, эсвэл мэдээллийг олон нийтэд ил гаргахыг дэмжиж буй байгууллагын бүтцэд өөрчлөлт оруулах санал тавина.

## Санал гомдол хүлээж авах хараат бус хороо

128. СГХАХБХ нь бодлогын доор энгийн үед олон нийтэд ил гаргах мэдээллийг авах боломжийг хааснаар АХБ олон нийттэй харилцах бодлогыг зөрчиж байна хэмээн үзэж гаргасан гомдлыг хүлээн аван бодолцоно. СГХАХБХ нь ОНИГАЗХ-с гаргасан мэдээлэл олгохгүй байх шийдвэрийг дагах эсвэл эргүүлэх эрх мэдэлтэй. АХБ-нд 99 болон 101 дүгээр заалтуудын хүрээнд гаргасан ямарваа нэг шийдвэрийн талаарх санал гомдлыг бодолцон үзэх эрх мэдэл байхгүй болно. СГХАХБХ нь мэдээллийн ил гаргах асуудлаар мэргэшсэн хөндлөнгийн гурван мэргэжилтнээс бүрдэнэ.<sup>38</sup> Уг хороо нь тогтмол бус байдлаар ажиллах гэрээтэй байх бөгөөд ОНИГАЗХ-с гаргасан шийдвэрт гарсан санал гомдлыг авч үзэхээр ажилд дуудагдана. СГХАХБХ нь боломжийн хэрээр өөрийн хурлыг утас, цахим шуудан болон/эсвэл видео линкээр дамжуулан хийнэ. Нарийн бичгийн даргын алба нь СГХАХБХ-д нарийн бичгийн ажил хэргийг гүйцэтгэн, туслалцаа үзүүлэн ажиллана.

## Зээлдэгч болон/эсвэл үйлчлүүлэгч

129. АХБ-ны төслүүдийн хувьд мэдээллийг олон нийтэд ил гаргах үүргийн нэлээд их хэсгийг зээлдэгч буюу үйлчлүүлэгч үүрнэ. Зээлдэгч буюу үйлчлүүлэгч нь төслийн талаарх мэдээллийг олгох, төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүстэй харилцахын тулд үйл ажиллагаа хариуцсан газруудын ажилчидтай хамтран ажиллана (47 дугаар зүйл). Төслийн оноосон ажилтан нь төсөл болон улс орны талаарх мэдээллийг АХБ-ны цахим хуудсыг ашиглан авах, тухайн улс орны соёл, нөхцөл байдлыг бодолцсоны үндсэн дээр сонирхсон талуудад тухайн мэдээллийг ил гаргах боломжтой.

## Мэдээллийг авах журам

### Мэдээллийг идэвх санаачлагатай ил гаргах

130. Олон нийттэй харилцах бодлогын дагуу мэдээлэл, баримт бичгийг идэвх санаачилгатай ил гаргах гол хэрэгсэл нь АХБ-ны цахим хуудас байна. АХБ болон түүний зээлдэгч, үйлчлүүлэгч нар зорилтот хүлээн авагч, мэдээллийг ил гаргах зорилго, шалтгаанаас хамааран мэдээлэл, баримт бичгийг идэвх санаачлалатай ил гаргахад бусад арга хэрэгслүүдийг ашиглана (жишээ нь зөвлөлдөх үйл явцад дэмжлэг үзүүлэх мэдээлэл).

### Мэдээлэл хүсэх

131. Мэдээлэл болон баримт бичиг хүсэх бүх хүсэлт нь бичгээр тавигдсан байх шаардлагатай (цахим шуудан, шуудан, цахим санал, факс). Эдгээр хүсэлтийг АХБ-ны Олон нийтийн мэдээлэл болон ил гаргах асуудал хариуцсан хэлтэс рүү дараах хаягаар явуулж болно: Азийн Хөгжлийн Банк, 6 АХБ-ны өргөн чөлөө, Мандалуён хот, 1550 Метро Манила, Филиппин Улс, disclosure@adb.org цахим шуудан, эсвэл факс +63 2 636 2649. Хүсэлтийг мөн суурин төлөөлөгчийн газар, төлөөлөгчийн газар, АХБ-ны холбогдох газар, алба руу хаяглан явуулж болно. Авахыг хүссэн мэдээллийг боломжит хугацааны дотор олох боломжийг АХБ-нд олгохын тулд тухайн мэдээллийн тухай боломжит нарийвчлалыг заасан байх шаардлагатай.

132. АХБ-ны холбогдох газар болон алба нь 97 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу тухайн баримт бичиг ил гаргах боломжгүй мэдээлэл агуулсан эсэхийг шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд АХБ өөрийн зээлдэгч, үйлчлүүлэгч эсвэл хамтран

<sup>38</sup> СГХАХБХ-ны гишүүдийг Ерөнхийлөгч томилон, Захирлуудын зөвлөл батална. Хорооны гурван гишүүнд дараах хүмүүс томилогдох боломжтой: (i) мэдээллийг олон нийтэд хүргэх асуудлаар зохих мэдлэг туршлагатай ХБГО-ны төлөөлөл, (ii) мэдээллийг олон нийтэд хүргэх асуудлаар зохих мэдлэг туршлагатай, аль ч засгийн газрын харьяат биш мэргэжилтэн болон (iii) худалдааны орчинд мэдээллийг олон нийтэд хүргэх асуудлаар мэргэшсэн мэргэжилтэн.

санхүүжүүлэгч талтай зөвлөлдөнө. Олон нийтийн мэдээлэл болон ил гаргах асуудал хариуцсан хэлтэс нь шаардлагатай үед ажилчдыг чиглүүлнэ

133. 98 дугаар зүйлд заасны дагуу түүхэн мэдээллийг хүсэлтийн дагуу олгож болно. Түүхэн мэдээллийг хүсэхдээ хүссэн мэдээллээ нарийвчлан тодорхойлох ба түүхэн мэдээллийг гаргах хоосон хүсэлтийг хүлээж авахгүй болно.

### Одоогийн мэдээллийг авах хүсэлтийн цаг хугацааны хязгаар

134. АХБ нь мэдээллийг ил гаргах хүсэлт авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор уг хүсэлтийг авснаа нотолно. АХБ нь тухайн хүсэлттэй холбоотой шийдвэр гарсан даруйд хүсэлт гаргагчид мэдэгдэх ба энэ нь хүсэлт авснаас хойш 20 хоногоос хэтэрч болохгүй. АХБ хариултандаа хүссэн мэдээллийг олгох ба эсвэл хүсэлтийг хүлээж аваагүй бол ийнхүү хүлээж аваагүйн шалтгааныг бодлогын дагуу зүйл заалтуудыг тодорхой дурьдан оруулна. Хүссэн мэдээллийг олгохоос татгалзсан тохиолдолд бодлогын 136–141 дүгээр заалтуудын дагуу хүсэлт гаргагч нь гомдол гаргах эрхтэй болгохыг АХБ мэдэгдэнэ.<sup>39</sup> АХБ нь өөрийн цахим хуудсанд мэдээлэл авах хүсэлтийн жагсаалт, тухайн хүсэлтэд гаргасан хариу буюу мэдээллийг олгосон эсвэл олгохоос татгалзсан эсэх мэдээллийг, хэрэв татгалзсан бол ийнхүү татгалзсан шалтгааны хамт оруулна.

### Хүсэлт гаргасан хэл

135. Мэдээлэл авах хүсэлтийг АХБ-нд Англи эсвэл АХБ-ны гишүүн орнуудын аливаа нэг албан эсвэл үндэсний хэлээр тавьж болно. Англи хэлээс бусад хэлээр тавьсан мэдээлэл, баримт бичиг авах

хүсэлтийг холбогдох суурин төлөөлөгчийн газарт хаяглаж болно.

### Санал гомдол

136. Хүсэлт гаргагчийн тавьсан хүсэлтийг АХБ ОНХ бодлогоо зөрчих замаар гаргасан хэмээн үзэж байгаа бол АХБ санал гомдол хүлээн авах, гаргах хоёр шат дамжлагатай үйл ажиллагааг явуулна. Мөн хүссэн мэдээллийг ил гаргаснаар олон нийтийн хүртэх ашиг нь мэдээллийг ил гаргахгүй байснаар үүсэх хор хөнөөлөөс илүү гэж үзвэл тухайн мэдээллийг авах боломжийг хаасан Олон нийттэй харилцах бодлогод хамаарахгүй онцгой тохиолдлуудын тухайд гомдол гаргах боломжтой. Ийнхүү гаргасан гомдлыг хүлээн авсан тохиолдолд хүсэлт гаргагчид хүссэн мэдээллийг олгохоос өөр залруулах үйл ажиллагаа хийхгүй. Гомдол гаргах хоёр шаттай үйл ажиллагааг 137–141 дүгээр зүйлүүдэд тодорхойлсны дагуу байгуулна.

### Гомдлын эхний үе шат: Олон нийтэд ил гаргах асуудлаарх зөвлөлдөх хороо

137. Хүсэлт гаргагч нь хүссэн мэдээллээ аваагүй бол дараах тохиолдолд ОНИГАЗХ-д гомдол гаргах боломжтой: (i) мэдээллийг ил гаргахгүй байснаараа АХБ Олон нийттэй харилцах бодлогыг зөрчсөн гэсэн ул суурьтай байр суурь илэрхийлсэн, (ii) хүссэн мэдээллийг олгохгүй байх нөхцлийг бүрдүүлсэн бодлогод хамаарахгүй онцгой тохиолдлуудыг давах олон нийтийн эрх ашгийг хамгаалсан санал боловсруулсан.

138. ОНИГАЗХ нь гомдол хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор гомдол авснаа нотолно. Хороо нь гомдлыг аль болохоор хурдан авч хэлэлцэхээр цуглана. Гомдлыг авч хэлэлцэж байхдаа 97 дугаар зүйлд заасан бодлогод хамаарахгүй онцгой

<sup>39</sup> АХБ ердийн тохиолдолд ил гаргах мэдээллийг 101 дүгээр зүйлийн дагуу ил гаргахгүй байх эрхээ ашигласан тохиолдолд энэхүү цаг хугацааны шаардлага мөрдөгдөхгүй. Ийм тохиолдолд, АХБ энэ асуудлаар эцсийн шийдвэр гаргуулахаар Захирлуудын зөвлөлд хэргийг танилцуулна.

тохиолдлуудыг бодолцон үзнэ. Хэрэв гомдлыг 99 дүгээр зүйлд заасан олон нийтийн эрх ашиг давамгайлсны үндсэн дээр тавьсан бол, ОНИГАЗХ нь эдгээр хүсэлтийг бодолцон үзэх боловч тухайн мэдээллийг ил гаргах эсвэл ил гаргахаас татгалзах аливаа санал нь Захирлуудын зөвлөлийн баримт бичгийн хувьд Захирлуудын зөвлөлийн зөвшөөрөл, бусад баримт бичгийн хувьд Ерөнхийлөгчийн зөвшөөрлийг шаардах ба тэдгээр шийдвэр нь эцсийх байх болно. ОНИГАЗХ нь Захирлуудын зөвлөл 99 дүгээр зүйлийн дагуу шийдвэр гаргаагүй тохиолдолд хүсэлт гаргагчид өгөх хариултыг гарсан даруйд нь эсвэл гомдол хүлээж авснаас 20 ажлын хоногийн дотор бичгээр гаргах ба ингэхдээ тухайн шийдвэрийг гаргах болсон шалтгааныг дурьдана. Тэр тохиолдолд Захирлуудын зөвлөлийн шийдвэр гарсны дараа гомдол гаргагчид мэдэгдэнэ.

**Гомдлын хоёр дахь үе шат:  
Хараат бус гомдлын хороо**

139. ОНИГАЗХ нь мэдээлэл авах хүсэлтийг няцаах анхны шийдвэрээ хадгалан үлдвэл, хүсэлт гаргагч нь ХБГХ-д гомдол гаргах боломжтой. ХБГХ нь мэдээллийг авах эрхийг хязгаарласнаараа АХБ Олон нийттэй харилцах бодлогыг зөрчсөн хэмээн үзэн гомдлыг хүлээн авна. Гомдлыг нягтлан үзэхдээ, ХБГХ нь гомдол, бодлогод хамаарахгүй онцгой тохиолдлууд, мөн АХБ мөн/эсвэл холбогдох мэдээллийг ил гаргахыг эсэргүүцсэн гурав дагч талаас гаргасан мэдэгдэл байвал тэдгээрийг бодолцон үзнэ. ХБГХ нь ОНИГАЗХ-с гаргасан холбогдох шийдвэрийг хадгалах эсвэл эргүүлэх эрх мэдэлтэй ба ХБГХ-с гаргасан шийдвэр нь эцсийх байна. ХБГХ нь гомдол хүлээж авсан өдрөөс 45 хуанлийн өдрийн дотор хүлээн авсан бүх гомдлыг хянан үзэх шаардлагатай. ХБГХ нь 99 дүгээр зүйлд заасан олон нийтийн эрх ашиг давамгайлсан хэмээн гомдол гаргасан нь Захирлуудын зөвлөл эсвэл Ерөнхийлөгчийн гаргасан шийдвэрийн эсрэг байвал эсвэл 101 дүгээр зүйлийн дагуу ердийн үед ил гаргадаг мэдээллийг

Захирлуудын зөвлөл өөрийн эрхийг ашиглан ил гаргахгүй байх шийдвэр гарсны эсрэг гомдлыг авч хэлэлцэхгүй.

**Гомдол гаргах ба шийдвэрийг мэдэгдэх**

140. ОНИГАЗХ-д гаргасан гомдол нь хүссэн мэдээллийг ил гаргахгүй байх анхны шийдвэрийг АХБ гаргасан өдрөөс хойш хуанлийн 90 хоногийн дотор бичгээр хийгдсэн байх ёстой. ХБГХ-д гаргасан бүх гомдол нь хүссэн мэдээллийг ил гаргахгүй байхаар АХБ-ны гаргасан эхний шийдвэрийг ОНИГАЗХ хадгалах шийдвэрийг гаргаснаас хуанлийн 90 хоногийн дотор бичгээр хийгдсэн байх ёстой. Гомдлыг ОНИГАЗХ руу хаягласан имэйл хаягаар дамжуулан эсвэл ХБГХ руу Азийн Хөгжлийн Банк, 6 АХБ-ны өргөн чөлөө, Мандалуён хот, 1550 Метро Манила, Филиппин Улс, disclosure@adb.org цахим шуудан, эсвэл +63 2 636 2649 факсаар Олон нийтийн мэдээлэл болон ил гаргах асуудал хариуцсан нэгжээр дамжуулан хүргүүлж болно. Гомдол хүлээж авах хүчинтэй хугацаа болох 90 хоногоос хэтэрсэн гомдлыг хоцорсон хэмээн үзэж хүлээн авахгүй. Бүх гомдлыг богино хэмжээний захиа хэлбэрт оруулан явуулах хэрэгтэй бөгөөд үүнд дараах зүйлс орно:

- (i) анх хүссэн мэдээллийн тайлбар,
- (ii) АХБ Олон нийттэй харилцах бодлогыг зөрчсөн эсвэл олон нийтийн эрх ашиг давамгайлсан (99 дүгээр зүйл) гэсэн хүсэлт гаргагчийн саналд нотлох баримт болох баримт мэдээлэл, үндэслэлийг гаргасан тайлбар.

141. Дараах шалтгааны улмаас гомдлыг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд гомдол гаргагчид мэдэгдэнэ. Үүнд: (i) шаардлагатай хугацааны дотор гомдлоо гаргаагүй, (ii) гомдлыг тодорхой хэмжээнд баталгаажуулах хэмжээний хангалттай мэдээлэл өгөөгүй эсвэл (iii) ОНИГАЗХ эсвэл ХБГХ нь гомдол гаргасан тухайн хэргийг хэлэлцэн үзэх эрх мэдэл байхгүй тохиолдлууд орно. ОНИГАЗХ эсвэл ХБГХ нь мэдээллийг олгохгүй байх

өмнөх шийдвэрийг хадгалан үлдвэл, АХБ энэхүү шийдвэрийг гомдол гаргагчид ингэх болсон шалтгаануудын хамт мэдэгдэнэ. Хэрэв АХБ эсвэл ХБГХ нь мэдээлэл олгохгүй гэсэн өмнөх шийдвэрийг сөрсөн шийдвэр гаргасан бол АХБ ийм шийдвэр гарсан тухай хүсэл гаргагчид мэдэгдэн, хүссэн мэдээллийг олгоно. АХБ нь хүлээж авсан гомдлын жагсаалтыг өөрийн цахим хуудсанд байршуулж, үүндээ гомдлын ерөнхий утга, гомдолтой холбоотой гарсан шийдвэр бүрийг оруулна. Шийдвэр гарсан тухай бүрт нь жагсаалтыг шинэчилнэ.

### **Эргэн хянах, тайлагнах**

142. АХБ нь Олон нийттэй харилцах бодлогын хэрэгжилтийн хянаж, үр нөлөөг үнэлнэ (4 дэх хавсралтанд бодлогоос гарсан үр дүнгийн хүснэгтийг тайлбарлан оруулсан). АХБ нь хяналтын үр дүнг харуулсан жилийн тайланг өөрийн цахим хуудсанд байршуулна.

143. Бодлогыг хэрэгжүүлэх явцад АХБ-тай хамтран ажилладаг талуудыг асуудал дэвшүүлэх, мэдээлэл авах болон АХБ-тай харилцахыг АХБ зөвшөөрдөг. Бодлогын хэрэгжилтийн талаар асуудал дэвшүүлсэн хувь хүн эсвэл бүлэг хүний нэрийг АХБ олон нийтэд ил гаргахгүй.

### **Бодлого хүчин төгөлдөр болох өдөр болон бодлогыг эргэн дүгнэх**

144. Бодлого нь 2012 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. АХБ нь бодлого хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш 5 жилээс хэтрэлгүйгээр эргэн дүгнэнэ. Эргэн дүгнэх үйл ажиллагаанд сонирхсон хувь хүмүүс болон байгууллагыг оролцуулна. ■



## НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

145. Бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт шаардагдана. Төслийн мэдээллийн тайлангуудыг орчуулахын тулд орчуулгын ажлын жилийн төсвийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Орчуулгын ажлыг 2011 онд шинэчилэх үеэр мөн бусад орчуулгын үйлчилгээнд санхүүжилт хэрэгтэй эсэхийг дүгнэнэ.

146. АХБ-ны ажилчид, засгийн газрын албан хаагчид болон бусад сонирхсон талуудад бодлогын шинэ заалтууд болон тэдгээр нь АХБ-ны үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар мэдээлэл олгоно. Мэдээллийг түгээх төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглах ба үүнд АХБ-ны төв оффис болон улс орнууд дахь төлөөлөгчийн газруудад нүүр тулсан сургалт болон боломжтой бол видео хурал орно. Улс орон дахь мэдээлэл хүргэх уулзалтуудыг зохион байгуулах ба энэ нь нэн ялангуяа том болон дунд хэмжээний суурийн төлөөлөгчийн газар болон төлөөлөгчийн газруудад хамааралтай. Бодлого батлагдсаны дараа ГХГ-т сургалтын төсвийг суулгах шаардлагатай.

147. ХБГХ-ны төсөв нь уг хороонд ирэх гомдлын тооноос хамаарах ба шаардлагатай төсвийг жилийн төсөв хүсэх үеэр суулгана. ХБГХ-ны гишүүд нь гомдол хүлээн авч, түүнийг судлахаар дуудагдсан үед л ажиллах ба ажилласан өдрийхөө тоогоор хөлсөө авна.

148. 145–147 дугаар зүйлд тайлбарласны дагуу уг бодлогыг дараагийн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхийн тулд ойролцоогоор 700,000 ам.долларын нэмэлт төсөв шаардагдах ба үүнээс 120,000 ам.доллар орчим нь сургалт, мэдээлэл олгох үйл ажиллагаанд зарцуулагдана. Уг тооцооллыг жилийн төсөв хэлэлцэх үеэр эргэн харж, төсвийн нарийвчилсан хэрэгцээ шаардлагыг тооцоолно. Дэлхий нийтийн ойлголтыг тандах судалгааг 3 жил тутам хийхийн тулд санхүүжилтийг үргэлжлүүлэн гаргана.

149. Мөн үүний дээр орон нутгийн харилцагч талуудад мэдээлэл хүрч байгаа эсэхт ихээхэн анхаарал тавьдаг болсон, АХБ-ны төслүүдийн тоо сүүлийн жилүүдэд нэлээд нэмэгдсэн зэргээс үүдэн үйл ажиллагааны газрууд төслүүдийн олон нийттэй харилцах төлөвлөгөөг боловсруулахад дотоод хүн хүчийг нэмэгдүүлэх шаардлагатай болно. Улс орнуудад олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхийн тулд гадаад харилцаа хариуцсан бүтэн цагийн ажилтан байхгүй жижиг болон дунд хэмжээний суурин төлөөлөгчийн газруудад нэмэлт ажилтан, туслах ажилтан авах асуудлыг анхаарч үзнэ. Хүн хүчний талаарх асуудлуудыг мөн жилийн төсөв бэлтгэх үеэр нарийвчлан судална. ■

# Хэрэгжилтийг эргэн хянах

# 10

Олон нийттэй  
харилцах  
бодлого 2011

150. Олон нийттэй харилцах бодлогын мэдээллийг олон нийтэд ил гаргахтай холбоотой шаардлагуудын хэрэгжилтийг АХБ-ны Хариуцлагын механизмын дагуу эргэн хянана. 26–34 дүгээр зүйлд тусгагдсан бодлого, 35–101 дүгээр зүйлд тусгагдсан мэдээллийг олон нийтэд ил гаргах журам болон 113–144 дүгээр зүйлд тусгагдсан хэрэгжүүлэх арыг мөн АХБ-ны Хариуцлагын механизмын дагуу эргэн хянана. ■

## Хавсралт 1

# Гадны харилцагч талуудтай зөвлөлдөх үйл явц

1. Олон нийттэй харилцах бодлогыг эргэн хянах үйл явц 2010 оны 2 дугаар сард Удирдах ерөнхий захирлаар ахлуулсан удирдах дотоод ахлах хороо байгуулагдсанаар эхэлсэн. Азийн Хөгжлийн Банк нь эргэн хянах үйл явц эхэлснийг зарлахын тулд ОНХБ-ыг эргэн хянахад тусгайлан зориулсан цахим хуудас нээсэн. Мөн энэ мэдээг АХБ-наас гаргадаг, иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн судлаачид болон бусад олон улсын байгууллагуудаас голдуу бүрдсэн 1000 гаруй хүлээн авагчтай *Түншлэлийн мэдээ* нэртэй Цахим сонингийн тэргүүн мэдээ болон орсон.
2. ОНХБ-ыг эргэн хянахад зориулсан цахим хуудсаар дамжуулж 2005 оны бодлогын талаарх олон нийтийн санал бодлыг АХБ авсан. Олон нийтийн саналыг авах энэхүү үйл явц 2 сарын турш үргэлжилсэн ба 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр дууссан. Энэ хугацаанд АХБ доторх болон гадны саналыг нэгтгэн бодлогын эхний хэлэлцүүлэх төслийг боловсруулахад ашигласан. Хүлээн авсан саналуудыг эдгээр саналуудад АХБ-наас өгсөн хариултын хамт ОНХБ-ын эргэн хянах цахим хуудсанд байршуулсан.
3. Хэлэлцүүлэх төслийг АХБ-ны цахим хуудсанд 2010 оны 6 дугаар сарын 2-ны өдөр байршуулсан. Үүнд голчлон найруулгын өөрчлөлт болон АХБ-ны бизнесийн явцад гарсан шинэчлэлүүдийг тусган оруулсан. Энэхүү төсөл болон бодлогод өгсөн саналыг дараа нь улс орнуудад хийсэн зөвлөлгөөний суурь болсон ба Бахаса Индонез, Хятад, Хинди, Хмэр болон Орос хэл рүү орчуулсан.
4. 2010 оны 7 дугаар сарын 15-с 8 дугаар сарын 2-ныг хүртэл зөвлөлгөөнүүдийг эрчимтэй хийсэн. Олон нийттэй зөвлөлдөх төлөвлөгөө болон цагийн хуваарийг АХБ-ны цахим хуудсанд байршуулсан. Зөвлөлгөөний үеэр урьдчилсан суурь мэдээлэл олгохын тулд PowerPoint танилцуулга, урьдчилсан бэлтгэсэн хэлэлцэх асуудлын багц болон бодлогын эхний төслийг ашиглаж байв.
5. Нийт 12 оронд 20 зөвлөлдөх уулзалт хийсэн ба үүнд Австрали, Бангладеш, Камбодж, Канад, БНХАУ, Герман, Энэтхэг, Япон, Филиппин, Таджикистан болон АНУ зэрэг орнууд багтан, 500 гаруй оролцогчдыг хамарсан нь иргэний нийгэм, төслийн үр нөлөөнд өртсөн хүмүүс, ижил үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, эрдэмтэн судлаачид болон хувийн хэвшлийн төлөөллөөс орсон. Зөвлөлдөх уулзалтуудыг Англи хэл, мөн тухайн орны хэл дээр явуулж, орчуулагч, хөтлөгч нарыг шаардлагатай үед авсан.

6. Бодлогын зорилго болон чиглэл нь зөв болсон гэдгийг ихэнх оролцогчид хүлээн зөвшөөрч байсан хэдий ч дараах голлох зөвлөмжүүдийг өгөв:

- (i) Бодлогыг бусад олон талт хөгжлийн банкуудын мэдээллийг олон нийтэд ил гаргах хамгийн шилдэг туршлагатай нэг эгнээнд авчрах,
- (ii) Мэдээлэл авах хүсэлт няцаагдсан тохиолдолд үүнтэй холбоотой гомдол хүлээн авах хараат бус үйл явцыг бий болгох,
- (iii) Мэдээллийг олон нийтэд ил гаргах тохиолдолд хамаарахгүй онцгой тохиолдлуудыг эргэн харах,
- (iv) Төсөл хэрэгжиж буй газар төслийн нөлөөнд өртсөн хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх,
- (v) Захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааг илүү тунгалаг болгох
- (vi) Хувийн хэвшлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд ил гаргах байдлыг сайжруулах
- (vii) Орчуулгыг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах,
- (viii) Аудитын тайлан болон хорионд орсон компани, хувь хүмүүсийн талаарх бүх мэдээллийг ил гаргах

7. Зөвлөлдөх уулзалтуудын бүх дүгнэлт, оролцогчдын жагсаалтыг ОНХБ-ыг эргэн хянах цахим хуудсанд байршуулсан.

8. Бодлогын хоёр дахь зөвлөлдөх төсөл болон гадны санал, түүнд АХБ-ны зүгээр өгсөн хариу зэргийг 2010 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр дахин нэг сарын турш санал авахаар тусгайлсан цахим хуудсанд байршуулсан. Эдгээрийг мөн Бахаса Индонез, Хятад, Хинди, Хмэр болон Орос хэл рүү орчуулсан. Зөвлөлдөх үйл явцын үеэр авсан саналуудыг боломжийн хэрээр хоёр дахь төсөлд тусган оруулахыг оролдсон.

9. Хоёр дахь төсөлд ирсэн саналыг авсны дараа Захирлуудын зөвлөлд 2011 оны 2 дугаар сарын 16-ны өдөр гэхэд танилцуулах ажлын баримт бичгийг бэлтгэв. Үүнийг АХБ-ны зүгээс өгсөн хариултуудын хамт ОНХБ-ыг эргэн хянахад зориулсан цахим хуудсанд байршуулав.

10. Зөвлөлдөх үйл явцын үеэр ОНХБ-ыг эргэн хянах баг мөн хэд хэдэн тохиолдолд АХБ-нд чиглэсэн ТББ-уудын Форум болон Манила дахь Дэлхийн Транспэрэнси Санаачилгын төлөөллүүдтэй уулзаж, тэдний санал, зөвлөмжийг авсан. Вьетнамын Ханой хотноо 2011 оны 5 дугаар сард болсон АХБ-ны 44 дэх жилийн уулзалтын үеэр АХБ-нд чиглэсэн ТББ-уудын Форумаас зохион байгуулсан ОНХБ-ын хэлэлцүүлэгт АХБ оролцсон. Эдгээр тохиолдлуудын аль алинд нь АХБ ОНХБ болон түүнийг эргэн хянах үйл явцын талаар танилцуулга хийж, оролцогчдын асуултуудад хариулсан.

## Хавсралт 2

# Олон талт хөгжлийн бусад банкуудын мэдээллээ олон нийтэд ил гаргаж буй байдал

1. Олон талт хөгжлийн банкуудын мэдээллийг олон нийтэд ил гаргах тал дээр баримталдаг нийтлэг зарчим бол үйл ажиллагааг илүү нээлттэй тунгалаг болгох явдал юм. Азийн Хөгжлийн Банктай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд тунгалаг байдал, тайлагнах чадвараа сайжруулах зорилгоор саяхан мэдээллийг олон нийтэд ил гаргах талаар баримталдаг бодлогоо шинэчилсэн эсвэл шинэчилэх явц дундаа байна. Эдгээр байгууллага болгонд хийгдсэн бодлогын шинэчлэлийн дотор олон нийтэд ил гаргаж буй мэдээллийн хүрээг нэмэгдүүлэх, тэрхүү мэдээллийг олж авах явцыг илүү хялбар болгох өөрчлөлтүүд орсон.

## Африкийн Хөгжлийн Банк

2. Африкийн Хөгжлийн Банк 2004 оны 3 дугаар сард Мэдээллийг ил гаргах бодлогыг баталж, 2005 оны 10 дугаар сард шинэчилсэн. Уг бодлогын дагуу АфХБ нь өөрийн үйл ажиллагааны тухай бүхий л мэдээллийг ил гаргахгүй байх дорвитой шалтгаан байхгүй бол ил гаргаж байхаар туссан байна.

3. Үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн хувьд баримт бичиг болгоны тухай товч тайлбар болон уг баримт боловсруулагдаж байх хугацаанд аль шатад нь ил гарах боломжтойг тусгасан өргөн хүрээний баримт бичгүүдийн тусган оруулжээ. Мөн бодлогод АфХБ-ны бүлгийн олон нийтэд ил гарах тухай санхүү, захиргаа болон хуулийн мэдээллийг тусгайлан оруулсан.

4. Жишээ нь, үйл ажиллагааны бодлогын баримт бичиг болон улс оронтой хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн төслүүдийг олон нийт болон холбогдох талуудын оролцоог хангах үүднээс Захирлуудын зөвлөл хэлэлцэхээс дор хаяж 50 хоногийн өмнө олон нийтэд ил гарган хэмээн тусгажээ.

5. Нууц хэвээр үлдэх мэдээллийн төрөлд АфХБ-ны бүлгийн үйл ажиллагаанд хөрөнгө болон санхүүгийн зах зээлүүд дээр нөлөөлж болзошгүй санхүүгийн дотоод мэдээлэл, тухайн талууд өөрсдөө зөвшөөрөөгүй тохиолдолд зээлийг судлах, хэлэлцээр хийхэд хувийн байгууллагуудаас АфХБ-ны авсан санхүү, бизнес болон өмчийн мэдээлэл орно.

6. АфХБ-ны Захирлуудын зөвлөл нь Мэдээллийг олон нийтэд ил гаргах бодлогоо эргэн хянаж байгаа ба энэхүү үйл явцыг 2011 онд дуусгахыг зорьж байна.

## Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк

7. Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ) нь 2011 оны 7 дугаар сард Олон нийтийн мэдээллийн бодлогыг шинэчилсэн ба шинэчилсэн бодлого нь 2011 оны 11 дүгээр сард хүчин төгөлдөр болно.

8. Төслийн мэдээлэл нь хувийн хэвшлийн төслүүдийн хувьд тухайн төсөл нууцлалын хязгаарлалттай биш бол ЕСБХБ-ны цахим хуудсанд Захирлуудын зөвлөлөөр хэлэлцэхээс хамгийн багадаа хуанлийн 30 хоногийн өмнө олон нийтэд ил болно. Хэрэв нууцлалын хязгаарлалд орсон бол тухайн төслийн мэдээллийг аль болох эрт эсвэл мөнгө зарцуулахаас өмнө ил гаргана. Засгийн газрын хүрээний төслүүдийн хувьд төслийн мэдээллийг тухайн төсөл Захирлуудын зөвлөлөөр хэлэлцэгдэхээс дор хаяж 60 хоногийн өмнө олон нийтэд ил гаргана. Төслийн мэдээллийг англи хэл болон төсөл хэрэгжих улс орны албан ёсны хэлээр гаргана. Төсөлд бодит өөрчлөлд орсон үед төслийн мэдээллийг шинэчилнэ.

9. 2011 оны шинэчилсэн бодлогын дагуу улс орны стратегийн баримт бичгүүд дээр хуанлийн 45 хоногийн хугацаанд олон нийтийн саналыг авна. Шинэчилсэн бодлого хэрэгжиж эхлэсэн үеэс улс орны стратегийн төслийг олон нийтийн саналыг авах зорилгоор холбогдох улс орны албан ёсны хэл рүү орчуулан гаргана. Олон нийтээс авсан санал болон ЕСБХБ-ны ажилчдын хариултуудын багцыг улс орны стратегийг эцсийн байдлаар батлагдахаас өмнө Захирлуудын зөвлөлд танилцуулна. Захирлуудын зөвлөл стратегийг баталсны дараа, олон нийтээс авсан саналын багцыг ЕСБХБ-ны цахим хуудсанд байршуулж, эцсийн байдлаар батлагдсан стратегийг улс орны албан ёсны хэл рүү орчуулан тавина. Салбарын бодлогын төслийг мөн олон нийтийн санал авахаар хуанлийн 45 хоногийн хугацаанд ЕСБХБ-ны цахим хуудсанд байшуулна хэмээн бодлогод заажээ. Захирлуудын зөвлөл стратегийг баталсны дараа, олон нийтээс авсан саналын багцыг ЕСБХБ-ны цахим хуудсанд байршуулна.

10. 2011 оны Олон нийтийн мэдээллийн бодлогод байгаль орчин, нийгмийн нөлөөний үнэлгээг хувийн хэвшлийн төслүүдийн хувьд Захирлуудын зөвлөл хэлэлцэж эхлэхээс дор хаяж хуанлийн 60 хоногийн турш, Засгийн газрын төслийн хувьд дор хаяж хуанлийн 120 хоногийн өмнө ЕСБХБ-ны төв оффис байрлах Лондон хотод болон төсөл хэрэгжих улс оронд ил гаргана хэмээн тусгажээ.

11. ЕСБХБ нь Олон нийтийн мэдээллийн бодлогоор хүлээсэн үүрэг бөгөөд тэдгээр нь өнгөрсөн жил хэрхэн биелэгдсэнийг дүгнэсэн хэрэгжилтийн тухай жилийн тайланг өөрийн цахим хуудсанд байршуулдаг.

## Европын Хөрөнгө Оруулалтын Банк

12. Европын Хөрөнгө Оруулалтын Банк (ЕХОБ) нь харилцагч талууддаа өөрийн үйл ажиллагааны засаглал, стратеги, бодлого, үйл ажиллагаа, хэв маяг, гүйцэтгэл, үр нөлөө болон үр дүнг ойлгуулах мэдээллийг өгөхийг зорьсон.

ЕХОБ-ны Тунгалаг байдлын тухай шинэ бодлого нь 2010 оны 2 дугаар сард хүчин төгөлдөр болсон. ЕХОБ-нд байдаг бүх мэдээллийг ил гаргахгүй байх онцгой шалтгаан байхгүй бол хүсэлтийн дагуу ил гаргаж болдог. ЕХОБ нь үйл ажиллагаагаа банкны журмаар явуулдаг учир олон нийтэд ил гаргах мэдээлэл нь тодорхой хязгаарлалттай байдаг.

13. Мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд ЕХОБ нь олон нийтийн хэрэгцээ шаардлагыг бодолцсон хэлний тогтолцоог баримталдаг.

14. Тодорхой хууль, журмаар тогтоогдсон хязгаарын хүрээнд олон нийтэд аль мэдээлэл хүрч болох мөн аль мэдээллийг хэвлэмэл байдлаар харин аль мэдээллийг цахим хуудсаар дамжуулан ил гаргах талаар эцсийн шийдвэрийг ЕХОБ гаргадаг. Ерөнхийдөө олон нийтийн эрх ашгийг хөндсөн мөн/эсвэл олон тооны харилцагч талууд мөн/эсвэл олон нийтийн төлөөллийн сонирхлыг татаж болзошгүй мэдээллийг хэвлэнэ.

15. ЕХОБ нь мэдээллийг олон нийтэд ил гаргах, тунгалаг байдлын зарчмыг даган мөрддөг боловч мөн Европын хуулиудын дагуу мэргэжлийн нууцуудыг хүндэтгэх үүрэгтэй. Бизнес гэрээ хэлэлцээр болон зах зээлийн үйл ажиллагааг хамарсан үндэсний дүрэм журам болон банкны салбарын хэм хэмжээнүүд мөн ЕХОБ-нд хамааралтай байж болно. ЕХОБ-ны бизнес түншүүдтэйгээ харилцах нууц харилцааны нэг хэсгийг хамарсан мэдээлэл үүнд хамрагдахгүй.

16. ЕХОБ нь тодорхой бодлогуудын хүрээнд олон нийтийн албан ёсны зөвлөлгөөнд өөрийн сайн дураар үргэлжлүүлэн оролцох үзэл баримтлалтай.

17. Олон нийтийн гишүүн төлөөлөл болгон цаг тухайд нь ЕХОБ-с мэдээлэл хүсэх болон авах эрхтэй.

18. Тунгалаг байдлын тухай бодлогыг байгууллага даяар хэрэгжүүлэх төсвийг хуваарилсан. ЕХОБ-ны үйл ажиллагааны тухай орон нутгийн иргэдэд мэдээллийг олгох зорилгоор тус банкны бүс нутгийн оффис болгонд мэдээллийн ширээ гарган ажиллуулна.

19. ЕХОБ өөрийн Тунгалаг байдлын тухай бодлогын дагуу үйл ажиллагаагаа явуулж чадаагүй хэмээн харилцагч талууд үзсэн бол гомдол гаргах боломжийг ЕХОБ-ны гомдол хүлээн авах механизм олгоно.

## **Америк дундын Хөгжлийн Банк**

20. Америк дундын Хөгжлийн Банкны Гүйцэтгэх захирлуудын зөвлөл 2009 оны 12 дугаар сард өөрийн тунгалаг байдлын тухай бодлогыг эргэн үзэх зөвшөөрлийг олгосон юм. Захирлуудын зөвлөл 2010 оны 5 дугаар сарын 12-нд Мэдээлэл хүртээмжтэй байх тухай бодлогыг баталж, уг бодлого 2011 оны 1 дүгээр сард хүчин төгөлдөр болов.

21. Мэдээллийг олон нийтэд ил гаргахыг илүүд үздэг болохыг тодотгохын тулд АДХБ нь байнга ил гаргадаг мэдээллийн “эерэг жагсаалтыг” дахин гаргахгүй болсон. Уг бодлого нь АДХБ-с гаргасан эсвэл эзэмшдэг тусгай мэдээлэлд хамаарах ба ингэхдээ эдгээр нь олон нийтэд ил гаргахгүй онцгой тохиолдлуудыг бодолцоно. Үүний дээр бодлогод олон нийтэд ил гаргахгүй тодорхой мэдээллийн жагсаалт орно.

22. Бодлогын хүрээнд өмнө гаргаж байснаас илүү мэдээллийг олон нийтэд ил гаргах боломжтой болсон ба энэ нь Захирлуудын зөвлөлийн үйл ажиллагаа болон хэрэгжиж буй төслүүдийн талаар мэдээлэлд илүү хамааралтай. Захирлуудын зөвлөлийн хороодын хуралдааны хэлэлцэх асуудал болон хуралдааны протокол нээлттэй болсон. Захирлуудын хэлсэн мэдэгдлүүдийг тэд өөрсдөө зөвшөөрсөн тохиодолд ил гаргана. Төслийн мониторинг, үнэлгээний зарим баримт бичгүүд анх удаагаа олон нийтэд ил гарна. Холбогдох улс орон татгалзаагүй тохиолдолд Захирлуудын зөвлөлөөр орон баримт бичгүүд болон улс орны стратегиуд, зээл болон техникийн хамтын ажиллагааны саналыг ил гаргах боломжтой болсон.

23. Бодлогын дагуу олон нийтэд зориулагдаагүй мэдээллийг тодорхой цаг хугацаа өнгөрсний дараа ил гаргана. Мэдээлэл авах хүсэлтийг няцаавал хүсэлт гаргагч нар хоёр дахь шатны хараат бус хороонд гомдол гаргах боломжтой.

## Дэлхийн Банкны Групп

### Олон Улсын Санхүүгийн Корпораци

24. Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) нь 2009 оны 9 дүгээр сард өөрийн Тогтвортой байдлын хүрээг эргэн үзэх ажлын хүрээнд 2006 оны мэдээллийг олон нийтэд ил гаргах бодлогыг эргэн харж эхэлсэн. ОУСК-ын Захирлуудын зөвлөл нь шинэчилсэн Тогтвортой байдлын тухай хүрээ болон түүний нэг хэсэг болох Мэдээлэл авах бодлогыг 2011 оны 5 дугаар сарын 12-нд баталсан юм. Шинэ бодлогын дагуу мэдээллийг олон нийтэд ил гаргахгүй байх тодорхой шалтгаан байхгүй бол бодлогод хамаарах мэдээллийг олон нийтэд ил гаргахыг илүүд үзсэн байр суурьтай байна. Уг бодлого нь ОУСК өөрийн төсөл, хөрөнгө оруулалтын талаар төслийн бүхий л үе шатын үеэр мэдээллийг гаргах чадварыг нэмэгдүүлж байгаа юм. Мөн санхүүгийн зуучлагч нар болон зөвлөх үйлчилгээний талаар ОУСК тунгалаг зарчмыг баримтлах боломжийг нэмэгдүүлэн, мэдээлэл авахыг хүсэлтүүд няцаагдсан тохиолдолд хоёр шат дамжлагаар гомдол гаргах боломжийг нэвтрүүлсэн.

### Олон талт хөрөнгө оруулалтын батлан даалтын агентлаг

25. Олон талт хөрөнгө оруулалтын батлан даалтын агентагийн (ОТХОБДА) Мэдээллийг олон нийтэд ил гаргах бодлого нь 2007 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон ба уг бодлогоор ОТХОБДА-ийн 1991 оны 7 дугаар сард батлагдаж байсан мэдээллийг олон нийтэд ил гаргах бодлогыг тэр чигт нь давсан.



26. ОТХОБДА-ийн бизнес үйл ажиллагаа, ерөнхий хөгжил болон үйл ажиллагааны бусад үр нөлөө, хөгжилд оруулсан хувь нэмрийг түнш, үйлчлүүлэгч болон сонирхсон бусад талууд илүү сайн ойлгох, ОТХОБДА-ын тухай илүү сайн мэдээлэл аван харилцах боломжийг олгох мэдээллийг олон нийтэд ил гаргадаг. Эдгээр зармчын хүрээнд ил гаргах мэдээллийг ОТХОБДА-ын тухай байгууллагын мэдээлэл болон ОТХОБДА-ын дэмжлэгтэй хэрэгжих үйл ажиллагааны талаарх мэдээлэл хэмээн ангилж болно. ОТХОБДА-ын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа үйл ажилаагааны талаарх мэдээллийг ил гаргах үүргийн ихэнхийг ОТХОБДА-ын холбогдох түншүүд үүрэх боловч зарим тодорхой мэдээллийг өөрийн бодлогын дагуу ил гаргадаг.

27. Бодлогод тайлбарласан мэдээллийг олон нийтэд ил гаргахгүй байх хүндэтгэх шалтгаан байхгүй бол уг мэдээллийг ил гаргахыг илүүд үздэг.

### Дэлхийн Банк

28. Дэлхийн Банкны Мэдээллийн хүртээмжтэй байдлын тухай бодлогыг Захирлуудын зөвлөл нь 2009 оны 11 дүгээр сарын 17-нд баталсан бөгөөд уг бодлого 2010 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Шинэ бодлого нь Дэлхийн Банкны мэдээллийг ил гаргах арга барилд томоохон өөрчлөлт авчирсан бөгөөд өмнө нь ямар мэдээллийг ил гаргаж болох тухай тодорхой байсан бол одоо Дэлхий Банк ил гаргаж болохгүй онцгой тохиолдлуудаас бусад тохиолдолд бүх мэдээллийг ил гаргана хэмээн өөрчлөгдсөнд оршино.

29. Бодлогын дагуу бэлтгэгдэж буй болон хэрэгжиж байгаа төслүүдийн талаар, шинжилгээ болон зөвлөмж олгох үйл ажиллагаа болон Захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны талаар илүү их мэдээллийг ил гаргах боломжтой болсон. Мөн бодлогын дагуу зарим бодлого, стратегийн баримт бичиг, төслийн баримт бичгүүдийг Захирлуудын зөвлөлд оруулахтай нэгэн зэрэг ил гаргах боломжтой болсон. Гэсэн хэдий бодлогын дагуу гишүүн орнуудтайгаа итгэлцэлтэй харилцааг хамгаалахын төлөө гаргасан шийдвэр, үйл ажиллагааг хэлэлцэн шийдвэрлэсэн болон ажилчид өөрийн үзэл бодол, зөвлөмжийг байгууллага дотроо болон түншүүдтэйгээ нээлттэй, чөлөөтэй илэрхийлэхийн тулд хийсэн хурлуудын тэмдэглэлийг нууц хэвээр хадгална.

30. Уг бодлого нь мэдээллийг хамгийн их нээлттэй авах болон тодорхой ашиг сонирхлыг сөрөг нөлөө үзүүлэх боломжтой нууц мэдээллийг хүндэтгэх хоёрын хооронд тэнцвэрийг олохыг зорьсон. Бодлогын дотор олон нийтэд ил гаргахгүй байх онцгой мэдээллийн жагсаалт орно. Гэсэн хэдий ч ил гаргахгүй байх жагсаалтанд хамрагдсан мэдээллийг олон нийтэд ил гаргаснаар гарах үр ашиг нь гаргаснаар гарах сөрөг үр дагавраас их гэж үзсэн онцгой тохиолдолдлуудад ил гаргах эрх Дэлхийн Банкинд байгаа. Үүнтэй ижил, ердийн үед ил гаргах мэдээллийг гаргаснаар гарах сөрөг үр дагавар ил гаргаснаар гарах үр ашгаас илүү гэж үзвэл тухайн мэдээллийг ил гаргахгүй байх эрх Дэлхийн Банкинд байгаа.

31. Шинэчилсэн бодлогын хүрээнд Дэлхийн Банк боломжийн хэрээр их хэмжээний мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулан, мэдээлэл хүсэх, түүнд хариу өгөх ойлгомжтой, үр ашигтай арга барилыг баримтална: Мөн Дэлхийн Банк мэдээллийг олгохгүй гэсэн зохимжгүй шийдвэр гаргасан гэж үзвэл гомдол гаргах хоёр шат дамжлагатай механизмтай болох ба хоёр дахь шат нь банкны Удирдлагуудаас хараат бус үйл ажиллагаа явуулдаг байна. Мөн эцэст нь мэдээлэл цаг хугацааны аясаар өөрийн ярвигтай, асуудал үүсгэх чанараа алддаг гэдгийг ухамсарлан тул хязгаарлагдмал төрөлд хамаарагдах мэдээллийг нууцлалаас гарган ил болгох цаг хугацааны тойм олгодог.

### Хавсралт 3

## 2005 оны Олон нийттэй харилцах бодлого, Олон нийттэй харилцах бодлогыг эргэн хянасан баримт бичиг болон Дэлхийн Банк, Америк дундын Хөгжлийн Банкны Мэдээлэл авах тухай бодлогуудын харьцуулалт

2011 оны 9 дүгээр сар

Асуудал	АХБ-ны хэрэглэж буй арга хэрэгсэл	ОНХБ-ыг эргэн харсан баримт бичигт орсон байдал	Бусад олон талт хөгжлийн банкууд
1. Бодлогын нэр?	Азийн Хөгжлийн Банкны Олон нийттэй харилцах бодлого: Мэдээллийг олон нийтэд ил гаргах болон солилцох	Бодлогын нэрийг хэвээр үлдээсэн	Дэлхийн Банк: Мэдээлэл авах талаар Дэлхийн Банкнаас баримтлах бодлого  АДХБ: Мэдээлэл авах талаарх бодлого
2. Бодлогын хэрэгжилтийн байдал	2005 онд батлагдсан. Одоогоор эргэн хянагдаж байгаа.	Байхгүй	Дэлхийн Банк: бодлого 2009 оны 11 сарын 17-нд батлагдан, 2010 оны 7 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон.  АДХБ: Бодлого 2010 оны 5 сарын 12-нд батлагдан, 2011 оны 1 сарын 11-нд хүчин төгөлдөр болсон.
3. Бодлогод гадаад харилцааны бодлого тусгагдсан эсэх	Тийм. ОНХБ нь мэдээллийг олон нийтэд ил гаргах болон гадаад харилцааны стратегийн нийлбэр.	Олон талын харилцагч нартай үр нөлөөтэй харилцахын тулд гадаад харилцааны бодлогыг арай зорилтот нарийвчилсан аргачлалаар сольсон.	Дэлхийн Банк болон АДХБ: Үгүй, зөвхөн мэдээллийг авах талаар асуудлыг хөндсөн. Гадаад харилцаа болон олон нийттэй харилцах асуудлыг өөр баримт бичигт тусгасан.
4. Зарчимд суурилсан аргачлалтай эсэх	ОНХБ-д ерөнхий хэдэн зарчмыг оруулсан (28–38 дугаар бүлэг) боловч эдгээрийг нарийвчлан гаргаагүй.	ОНХБ-ын суурь зарчмуудыг мэдэгдлийг хэсэгт оруулсан (27–33 зүйл).	Дэлхийн Банк болон АДХБ нь илүү зарчимд суурилсан аргачлал руу шилжсэн.
5. Мэдээллийг олон нийтэд ил гаргахыг илүүд үзсэн эсэх.	Тийм.	Мэдээллийг олон нийтэд ил гаргахыг илүүд үзэх баримтлалыг хадгалж үлдсэн.	Дэлхийн Банк болон АДХБ: Тийм.

Үргэлжлэл дараагийн хуудсанд

Үргэлжлэл

Асуудал	АХБ-ны хэрэглэж буй арга хэрэгсэл	ОНХБ-ыг эргэн харсан баримт бичигт орсон байдал	Бусад олон талт хөгжлийн банкууд
6. Мэдээллийг олон нийтэд ил гаргахад цаг хугацаа зааж өгсөн эсэх	<p>Тийм. Баримт бичгүүдийг цахим хуудсаар дамжуулан ил гаргах дээр тодорхой цаг хугацааг зааж өгсөн (зарим баримт бичгийг Захирлуудын зөвлөлд танилцуулахын өмнө ио гаргах бол зарим баримт бичгийг танилцуулснаас хойш 2 долоо хоногоос хэтрэлгүй гаргана).</p> <p>Тийм. Мэдээлэл авах хүсэлтэнд 5 хоногийн дотор хүсэлт авсныг нотолж хариулах ба хүсэлтийн хариултыг 30 хоногийн дотор олгоно.</p>	<p>Тийм. Мэдээллийг олон нийтэд ил гаргахад цаг хугацаа заасан байдлыг хэвээр авч үлдсэн ба заримыг шинэчилсэн. Захирлуудын зөвлөлд танилцуулах ихэнх баримт бичгийг одоо танилцуулах үетэй нэгэн зэрэг олон нийтэд ил гаргадаг болсон.</p> <p>Тийм. Мэдээлэл авах хүсэлтэнд 5 хоногийн дотор хүсэлт авсныг нотолж хариулах ба хүсэлтийн хариултыг 20 хоногийн дотор олгоно.</p>	<p>Дэлхийн Банк болон АДХБ: Дэлхийн Банк болон АДХБ-ны бодлогын баримт бичгийн хувьд олон нийтэд ил гаргах тодорхой цаг хугацаа заагаагүй. Харин зарим баримт бичгийг Захирлуудын зөвлөлд танилцуулах үед олон нийтэд ил гаргасан байх ёстой.</p> <p>Дэлхийн Банк: Тийм, Мэдээлэл авах хүсэлтэнд 5 хоногийн дотор хүсэлт авсныг нотолж хариулах ба хүсэлтийн хариултыг 20 хоногийн дотор олгоно. Энэ хугацааг сунгах боломжтой.</p> <p>АДХБ: Гаднаас авсан хүсэлтэнд хариулах цаг хугацааны хязгаар байхгүй.</p>
7. Бодлогод “эерэг” жагсаалт буюу заавал ил гаргах ёстой баримт бичгийн жагсаалт орсон эсэх.	Тийм. АХБ-ны цахим хуудсанд байршуулж эсвэл зээлдэгч, түншүүд төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүст олгох ёстой мэдээллийг жагсаасан.	Тийм. Эерэг жагсаалтыг авч үлдэн шинэчилсэн ба ингэснээр харилцагч талууд мэдээллийг хэзээ ил гаргах талаар төсөөлөлтэй болно.	Дэлхийн Банк болон АДХБ: Өөрийн санаачлагаар олон нийтэд ил гаргах мэдээллийн жагсаалт байхгүй. “Сөрөг” жагсаалтанд орсноос бусад мэдээллийг ил гаргах ёстой.
8. Мэдээллийг олон нийтэд гаргахад хамаарахгүй онцгой тохиолдлууд (“сөрөг” жагсаалт) байгаа эсэх.	Тийм. 126–127 дугаар зүйл.	Онцгой тохиолдлуудын жагсаалтыг тодорхой болгосон (97 дугаар зүйл). Олон нийтэд ил гаргахгүй мэдээллийн 7 төрлийг тодотгохын тулд нэр өгсөн. Зарим тохиолдолд, тодорхой мэдээллийг олон нийтэд ил гаргаснаар онцгой тохиолдлын жагсаалтаар хамгаалагдсан талуудад учрах хохирлыг тодорхойлсноор онцгой тохиолдлуудын хүрээг чангалсан.	Дэлхийн Банк болон АДХБ: Тийм. Гэвч онцгой тохиолдлуудыг гаргахдаа ил гаргаснаар учрах хохирлыг ил гаргаагүйгээс гарах үр дүнтэй харьцуулдаггүй
9. Асуудлыг хэлэлцэх явцын мэдээллийг нууцалдаг эсэх.	Тийм. Онцгой тохиолдлуудын доор орсон мэдээллийг хэлэлцэх явц (126.1–126.3). 126.1–126.2 дугаар зүйлд орсон мэдээллийг олон нийтэд ил гаргаснаар тодорхой талуудад хохирол учрах бол ил гаргахгүй.	Тийм. 2005 оны ОНХБ-ын асуудлыг хэлэлцэх явцын мэдээллийг гаргах талаарх 97 (i)–(iii) дугаар зүйл хэвээр үлдсэн.	Тийм. Дэлхийн Банк болон АДХБ: Асуудлыг хэлэлцэх үеийн явцын мэдээлэл онцгой тохиолдлуудад хамаардаг.

Үргэлжлэл дараагийн хуудсанд

## Үргэлжлэл

Асуудал	АХБ-ны хэрэглэж буй арга хэрэгсэл	ОНХБ-ыг эргэн харсан баримт бичигт орсон байдал	Бусад олон талт хөгжлийн банкууд
	Онцгой тохиолдлуудад хамаарах Захирлуудын зөвлөлийн хурлын бичлэг (126.3 зүйл).	Захирлуудын зөвлөлийн хурлын бичлэгийг 10 жилийн дараа хүсэлтийн дагуу гаргаж болох ба ингэхдээ бодлогын онцгой тохиолдлуудад хамаарахгүй байвал гаргаж болно (84 дүгээр зүйл).	Дэлхийн Банк: Захирлуудын зөвлөл болон зөвлөлийн хороодын хурлын бичлэгийг 10 жилийн дараа хүсэлтийн дагуу гаргаж болох ба ингэхдээ бодлогын онцгой тохиолдлуудад хамаарахгүй байвал гаргаж болно.  АДХБ: Захирлуудын зөвлөл болон зөвлөлийн хороодын хурлын бичлэгийг ил гаргах эсэх талаарх мэдээлэл бодлогод тусгагдаагүй.
10. Банкинд байгаа бүх мэдээллийг аюулгүй байдлын үүднээс ангилсан эсэх.	Үгүй. Зөвхөн Захирлуудын зөвлөлийн баримт бичгүүдийг ангилсан.	Үгүй. Аюулгүй байдлын үүднээс хийсэн дотоод ангиллыг тусад нь эргэн харна.	Дэлхийн Банк болон АДХБ: Тийм.
11. Банкинд байгаа мэдээлэл, баримт бичгийг жагсаалтаас гаргах.	Тийм. Гэхдээ жагсаалтаас гаргах идэвхтэй тогтолцоо байхгүй. Мэдээлэл авах хүсэлт бүрийг тухайн үеэд нь ОНХБ-ын дагуу харан үнэлдэг. Онцгой тохиолдолд хамаараагүй бол тухайн мэдээллийг ил гаргаж болно. Түүхэн мэдээлэлд онцгой тохиолдолд байх нь цөөн.	Тийм. Одоогийн арга барилыг авч үлдсэн.	Дэлхийн Банк болон АДХБ: Баримт бичгийн төрөл зүйлээс хамааран 5, 10, 20 жилийн дараа ил гаргана.
12. Онцгой тохиолдолд хамаарах мэдээллийг олон нийтийн эрх ашгийн төлөө ил гаргах эрх Банкинд байгаа эсэх.	Тийм. Нууцлалыг хадгалах хуулийн үүрэг хүлээгээгүй л бол бүх мэдээллийг энэ үндэслэлээр ил гаргаж болно (129–130 дугаар зүйл).  Зөвлөлдөх хорооны шийдвэрээр ил гаргана.	Тийм. Одоогийн арга барилыг хадгалж үлдсэн (99-100 дугаар зүйл).  Захирлуудын зөвлөлд хамаарах баримт бичгийн хувьд шийдвэрийг Захирлуудын зөвлөл гаргана, бусад баримт бичгийн хувьд Ерөнхийлөгч гаргана.	Дэлхийн Банк: Тийм. Зөвхөн тодорхой захиргааны мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл болон санхүүгийн мэдээллийн хувьд хүчинтэй.  АДХБ: Тийм.

Үргэлжлэл дараагийн хуудсанд

Үргэлжлэл

Асуудал	АХБ-ны хэрэглэж буй арга хэрэгсэл	ОНХБ-ыг эргэн харсан баримт бичигт орсон байдал	Бусад олон талт хөгжлийн банкууд
13. Онцгой тохиолдолд хамаарахгүй мэдээллийг ил гаргахгүй байх эрх Банкинд байгаа эсэх.	Үгүй.	Тийм. Захирлуудын зөвлөл зөвшөөрсөн онцгой тохиолдлуудад.	<p>Дэлхийн Банк: Тийм, Захирлуудын зөвлөлийн баримт бичгийн хувьд Захирлуудын зөвлөл зөвшөөрсөн онцгой тохиолдлуудад болон Захирлуудын зөвлөл, бусад баримт бичгийн хувьд Дэд Ерөхийлөгч, дарга зөвшөөрсөн тохиолдолд.</p> <p>АДХБ: Тийм, Захирлуудын зөвлөлийн баримт бичгийн хувьд Захирлуудын зөвлөлийн бичгийн зөвшөөрөл байгаа, бусад баримт бичгийн хувьд Мэдээллийг авах тухай хорооны зөвшөөрлийг авсан онцгой тохиолдолд.</p>
14. Мэдээлэл авах хүсэлтийг няцаасан үед гомдол гаргах боломжтой эсэх.	Тийм (дотоод). Зөвлөлдөх хорооны доорх нэг шатлалт гомдол гаргах механизмтай ба үүнд Гүйцэтгэх ерөнхий захирал, нарийн бичгийн дарга, ерөнхий зөвлөх болон ГХГ-ын Ерөнхий захирал орно (158–159 дүгээр зүйл).	Тийм. Хоёр шатлалт гомдлын механизм (136–141 дүгээр зүйл). Эхний шат нь Зөвлөлдөх хороо хэвээр үлдэнэ (дотоод). Хоёр дахь шат нь мэдээллийг ил гаргах талаар гурван мэргэжилтнээс бүрдсэн хараат бус бүлэг.	<p>Дэлхийн Банк: Тийм. Хоёр шатлалт гомдлын механизм, хоёр дахь шатлал нь мэдээллийн эрх чөлөөний мэргэжлийн гурван хүнээс бүрдсэн хараат бус бүлэг.</p> <p>АДХБ: Тийм. Хоёр шатлалт гомдлын механизм ба хоёр дахь шатлал нь хараат бус бүлэг байна (хэнээс бүрдсэн талаарх мэдээлэл байхгүй).</p>
15. Гомдлуудыг эргэн хянах хүрээ.	Мэдээлэл авах хүсэлтийг ул суурьтай шалтгаангүйгээр няцаасан эсвэл бодлогыг буруу тайлбарласан гэсэн гомдлыг Зөвлөлдөх хороо бодолцон үзнэ.	<p>Эхний шат: Зөвлөлдөх хороо эдгээрийг үзнэ: нэгт, мэдээллийг авах хүсэлтийг няцааснаар бодлогыг зөрчсөн хэмээх гомдол, хоёрт, бодлогын онцгой тохиолдлуудыг даван гарч мэдээлэл авах хүсэлт (99 дүгээр зүйлд тусгагдсан олон нийтийн эрх ашгийн тухай).</p> <p>Хоёр дахь шат: Зөвлөлдөх хорооны нэг дэх хэсэгт хамааран гаргасан гомдлыг Хараат бус гомдлын хороо хүлээн авах.</p>	<p>Дэлхийн Банк болон АДХБ: Эхний шат: Эхлээд дотоод хороо дараах асуудлыг хүлээн авна: нэгт, мэдээллийг авах хүсэлтийг няцааснаар бодлогыг зөрчсөн хэмээх гомдол, хоёрт, олон нийтийн эрх ашиг давамгайлсан гэсэн үндэслэлээр гаргасан гомдол.</p> <p>Хоёр дахь шат: Дотоод хорооны нэг дэх хэсэгт хамааран гаргасан гомдлыг гомдлын хараат бус зөвлөл хүлээх авах.</p>

Үргэлжлэл дараагийн хуудсанд

## Үргэлжлэл

Асуудал	АХБ-ны хэрэглэж буй арга хэрэгсэл	ОНХБ-ыг эргэн харсан баримт бичигт орсон байдал	Бусад олон талт хөгжлийн банкууд
16. Захиргааны нарийвчилсан төсвийг ил гаргадаг эсэх.	Тийм. АХБ-ны захиргааны төсвийг санхүүжил жил бүр ил гаргадаг.	Тийм. АХБ-ны захиргааны төсвийг санхүүжил жил бүр ил гаргадаг.	Дэлхийн Банк болон АДХБ: Тийм.
17. Нэгэн зэрэг ил гаргах: (i) нэгт, бодлогын баримт бичиг болон стратегийн төслийг олон нийттэй зөвлөлдөх үе шатыг давсны дараа Захирлуудын зөвлөлд танилцуулахтай нэгэн зэрэг ил гаргах.	Үгүй.	Тийм. Бодлогын баримт бичиг болон стратегийн төслийг олон нийттэй зөвлөлдөх шатыг давсны дараа АХБ-ны цахим хуудсанд Захирлуудын зөвлөлд танилцуулахтай нэгэн зэрэг байршуулна (72 дугаар зүйл).	Дэлхийн Банк: Тийм. Олон нийттэй зөвлөлдөх үе шатыг давсан бодлогын баримт бичиг болон стратегийн төслийг Захирлууд үзсэн тохиолдолд ил гаргана.  АДХБ: Тийм, үйл ажиллагааны бодлого болон салбарын бодлогын өмнөх хувилбаруудыг Захирлуудын зөвлөлд танилцуулж байсан бол.
(ii) Хоёрт, улс орны стратегиудыг Захирлуудын зөвлөлд танилцуулахтай нэгэн зэрэг олон нийтэд ил гаргадаг эсэх.	Үгүй, гэхдээ улс орны стратеги батлагдахаас өмнө уг стратегийг хоёр удаа улс орон дахь талуудын саналыг авах зорилгоор хуваалцах шаардлагатай.	Тийм. Улс орны стратегийн эцсийн хувилбаруудыг тухайн орон эрт ил гаргахыг зөвшөөрсөн бол Захирлуудын зөвлөлд танилцуулахтай нэгэн зэрэг АХБ-ны цахим хуудсанд байршуулна (38 дугаар зүйл).	Дэлхийн Банк: Тийм, хэрэв гишүүн орон зөвшөөрсөн бол.  АДХБ: Тийм, холбогдох улс орон татгалзаагүй бол.
(iii) Гуравт, зээлийн саналыг Захирлуудын зөвлөлд танилцуулахтай нэгэн зэрэг ил гаргадаг эсэх.	Үгүй. Зээлийн саналыг Захирлуудын зөвлөлд баталснаас 2 долоо хоногийн дотор ил гаргана.	Тийм. Холбогдох улс орон зөвшөөрсөн тохиолдолд Засгийн газрын хүрээний төслүүдийн зээлийн саналууд болон холбогдох баримтуудыг Захирлуудын зөвлөлд танилцуулахтай нэгэн зэрэг ил гаргана (58 дугаар зүйл)	Дэлхийн Банк: Тийм, хэрэв гишүүн орон зөвшөөрсөн бол.  АДХБ: Тийм, Засгийн газрын баталгаа гаргасан төслүүдийн хувьд холбогдох улс орон зөвшөөрсөн бол.
18. Төслийн нарийн мэдээллийг ил гаргадаг эсэх.	Тийм. Төслийн ерөнхий мэдээллийг анхны болон шинэчилсэн төслийн мэдээллийн хуудсын хэлбэрээр гаргана.	Тийм. Төслийн хуваарь, байдал болон хэрэгжилтийн явц зэрэг ерөнхий мэдээллийг ТМТ-д тусгана (өмнө нь төслийн мэдээллийн хуудас гэдэг байсан).	Дэлхийн Банк: Тийм, төслийн мэдээллийн баримтын нэг хэсэг болон хэрэгжилтийн явц, үр зүнгийн тайлан хэлбэрээр.  АДХБ: Тийм.
19. 1Банкнаас санхүүжсэн төслүүдийн аудитад орсон санхүүгийн мэдээллийг ил гаргадаг эсэх.	Үгүй.	Тийм. Бодлого хүчин төгөлдөр болсон өдөр буюу өдрөөс хойш хэлэлцээр хийх урилга гарсан Засгийн газрын хүрээний төслүүдийн хувьд аудитанд орсон төслийн санхүүгийн тайлангуудыг АХБ-ны цахим хуудсанд байршуулна (62 дугаар зүйл).	Дэлхийн Банк: Тийм, хэлэлцээр хийх урилга 2010 оны 7 сарын 1-нд эсвэл түүнээс хойш гарсан төслүүдийн аудитанд орсон санхүүгийн тайлангуудыг олон нийтэд ил гаргана.

Үргэлжлэл дараагийн хуудсанд

Үргэлжлэл

Асуудал	АХБ-ны хэрэглэж буй арга хэрэгсэл	ОНХБ-ыг эргэн харсан баримт бичигт орсон байдал	Бусад олон талт хөгжлийн банкууд
			АДХБ: Тийм. Зээлдэгч эсвэл үр ашиг хүртэгч зөвшөөрсөн бол Засгийн газраас баталгаа гаргасан төслүүдийн хувьд аудитын тайлангуудын жилийн төслийг олон нийтэд ил гаргана.
20. Аудитын дотоод тайланг ил гаргадаг эсэх.	Үгүй, учир нь эдгээр тайланд АХБ-нд хохирол учруулахаар гурав дагч талууд ашиглаж болзошгүй мэдээлэл байх боломжтой.	Үгүй, одоогийн арга барилыг хэвээр үлдээсэн.	Дэлхийн Банк: Үгүй. Аудитын дотоод тайлан нь дотоод шинж чанартай мэдээлэл гэж үздэг тул олон нийтэд ил гаргахаас зайлсхийдэг.  АДХБ: Үгүй.
21. Төслийн хяналтын тайлан, төслийн хэрэгжилт, үнэлгээ болон ижил төстэй тайланг ил гаргадаг эсэх.	Тийм. Төслийн хяналттай холбоотой мэдээллийг төслийн мэдээллийн хуудсанд оруулдаг. Төслийн эцсийн болон үнэлгээний тайлангуудыг АХБ-ны цахим хуудсанд байршуулдаг.	Тийм, одоогийн арга барилыг хадгалж үлдсэн.	Дэлхийн Банк болон АДХБ: Тийм.
22. Нэгт, Захирлуудын зөвлөлийн хурлын протокол болон хоёрт, Захирлуудын зөвлөлийн хороодын жилийн тайланг ил гаргадаг эсэх.	(i) Тийм. Захирлуудын зөвлөлийн хурлуудын протоколыг ил гаргадаг. (ii) Үгүй. Захирлуудын зөвлөлийн хороодын мэдээллийг ил гаргадаггүй. (iii) Тийм. Захирлуудын зөвлөлийн хороодын жилийн тайланг хороод санал болгож, Захирлуудын зөвлөл зөвшөөрсөн бол ил гаргаж болно.	Тийм, одоогийн арга барилыг хадгалж үлдсэн.	Дэлхийн Банк болон АДХБ: Тийм, Захирлуудын зөвлөлийн хурлуудын протокол, Захирлуудын зөвлөлийн хороодын уулзалтын протокол болон хороодын жилийн тайланг ил гаргаж болно хэмээн тусгасан байдаг.
23. Орчуулга	2007 онд орчуулгын системийг нэвтрүүлсэн. АХБ нь зарим орнуудын түншлэлийн стратеги, хамгааллын баримт бичгийг төслийн эзэд шаардлагатай гэж үзвэл мөн 25 гаруй улс орны хэлээр мэдээллийн брошуруудыг орчуулдаг. Жилд дунджаар 2 сая орчим үг орчуулдаг.	Одоогийн арга барилыг хадгалж үлдсэн. Нэмж бүх зээл, буцалтгүй тусламж болон төсөл бэлтгэх ТТ-ны төслийн хувьд Төслийн мэдээллийн тайланг холбогдох улсын хэл рүү орчуулах болсон.  АХБ-ны орчуулгын системийг 2011 онд эргэн хянана.	Дэлхийн Банк: 2003 онд орчуулгын системийг нэвтрүүлж, 2006 онд хянасан. Дэлхийн Банк нь үйл ажиллагааны тухай болон мэдээллийг түгээх өргөн хүрээний материалыг 6 олон улсын хэл (Араб, Хятад, Франц, Португал, Орос болон Испани) болон бусад шаардлагатай бүх хэл рүү орчуулдаг (жилд ойролцоогоор 30 сая үг). Дэлхийн Банк нь орчуулгын системээ Вашингтон дахь төв оффисоос удирддаг ба мөн 6 бүс нутгийн төвтэй.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



### Хавсралт 3

#### Үргэлжлэл

Асуудал	АХБ-ны хэрэглэж буй арга хэрэгсэл	ОНХБ-ыг эргэн харсан баримт бичигт орсон байдал	Бусад олон талт хөгжлийн банкууд
			АДХБ: Банкны албан ёсны хэл нь Англи, Испани, Франц болон Португали. АДХБ нь жилд ойролцоогоор 13 сая үг орчуулдаг ба албан ёсны хэл болгоноор өөрийн цахим хуудсыг ажиллуулдаг. Захирагч нарын зөвлөлд танилцуулах бүх баримт бичгийг албан ёсны дөрвөн хэл рүү хөрвүүлдэг.

АХБ = Азийн Хөгжлийн Банк, УОХХТС = Улс оронтой хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги, ГХГ = Гадаад харилцааны газар, ХБҮХ = Хараат бус үнэлгээний хороо, АДХБ = Америк дундын Хөгжлийн Банк, ОТХБ = Олон талт хөгжлийн банк, ОНХБ = Олон нийттэй харилцах бодлого, МОНИГЗХ = Мэдээллийг олон нийтэд ил гаргах зөвлөлдөх хороо, ТМТ = Төслийн мэдээллийн тайлан, ЕТЗ = Ерөнхийлөгчид өгөх тайлан зөвлөмж, ТТ = Техник туслалцаа.

Эх үүсвэр: Азийн Хөгжлийн Банк.

# Хавсралт 4

## Олон нийттэй харилцах бодлогын үр дүнгийн хүрээ

Олон нийттэй  
харилцах  
бодлого 2011

Боловсруулсан хүрээ	Үзүүлэлт болон хүрэх зорилт	Мониторинг, хяналтын арга хэрэгсэл
<b>Үр нөлөө</b> Хөгжлийн үр нөлөө сайжирсан	Шинэчлэлийн төлөвлөгөөний явцын тайлангуудаар хяналт тавина	<i>Хөгжлийн үр нөлөөг эргэн харах нь жил тутмын тайлангууд</i>
<b>Үр дүн</b> Азийн Хөгжлийн Банкнд итгэх итгэл болон АХБ-тай харилцах чадвар нэлээд сайжирсан	АХБ-ны талаарх оролцогч талуудын сэтгэгдэл, АХБ-ны нээлттэй, эргэн тайлагнах болон түншлэх чадварын талаарх үнэлгээ сайжирсан	Шийдвэр, бодлого тодорхойлогчдын дунд хийсэн сэтгэгдлийн талаарх судалгаа (3 жил тутам хийдэг)  Үйлчлүүлэгч, түншүүдийн судалгаа болон бусад харилцагч талуудын үнэлгээ  Бодлогыг 5 жил тутам тэр чигээр нь эргэн харах
<b>Үр дүн</b> 1. АХБ олон нийттэй идэвхтэй харилцдаг	АХБ-ны гол санаачлагууд, төсөл, болон бодлогод зориулан олон нийттэй харилцах бодлогыг боловсруулан, хэрэгжүүлсэн  Олон улс, бүс нутуаг, улс орнуудын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол гардаг  АХБ-ны цахим хуудаснаас мэдээлэл олгоход хялбар, хэрэглэгчид ээлтэй  Сайн чанартай, гол товхимлуудыг гаргаж, тараадаг	Оролцогч талуудын сэтгэгдлийн талаарх судалгаа (3 жил тутам хийдэг)  Олон нийттэй харилцах бодлого (АХБ)-ын жилийн тайлан  Хэвлэл мэдээлэл болон АХБ-ны цахим хуудсын хянах арга хэрэгслүүд (цахим хуудсын талаарх жил тутмын тайлан г.м.)
2. АХБ-ны үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал сайжирсан	АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх үйл ажиллагаа нэг хэсэг болон орсон  Мэдээлэл авах хүсэлтүүдийн хариуг ажлын 20 хоногийн дотор 100 хувь олгосон  Мэдээллийг олон нийтэд ил гаргахтай холбоотой шаардлагуудыг 100 хувь биелүүлсэн  АХБ-ны цахим хуудсанд байршуулж буй баримт бичгүүд жил ирэх тутам нэмэгдсэн  Мэлээлэ олгох болон бусад баримт бичгүүдийн чанартай орчуулга жил тутам нэмэгдсэн	Боловсруулсан хүсэлтүүдийн талаарх мэдээллийг хянадаг систем болон ОНХБ-ын жилийн тайлан  Мэдээллийг олон нийтэд ил гаргах нэгжийн ажлын гүйцэтгэлийн тайлан болон ОНХБ-ын жилийн тайлан  ОНХБ-ын жилийн тайлан

*Үргэлжлэл дараагийн хуудсанд*

Хавсралт 4

Үргэлжлэл

Боловсруулсан хүрээ	Үзүүлэлт болон хүрэх зорилт	Мониторинг, хяналтын арга хэрэгсэл
<b>Тодорхой хүрэх зорилттой үйл ажиллагаа</b>		
1.1 Бодлогод зориулж олон нийттэй харилцах төлөвлөгөө бэлдэх	Бодлого идэвхтэй болох өдөр гэхэд	Олон нийттэй харилцах төлөвлөгөө
1.2 Хэрэглэгчдийн хүлээлт болон шаардлагад нийцүүлэхийн тулд АХБ-ны цахим хуудсын байнга сайжруулах (жишээ нь, хэрэглээ, хүртээмжтэй байдал)	Байнга	Хэрэглээний гаднаас авсан шалгалт эсвэл хэрэглэгчдийн цахим судалгаа
2.1 Хараат бус гомдлын хороог Байгуулах	Бодлого идэвхтэй болох өдөр гэхэд	Хараат бус гомдлын хороог байгуулан, холбогдох мэдээг хэвлэлийн мэдээ, АХБ-ны цахим хуудас болон ОНХБ-ын жилийн тайланд оруулсан
2.2 Ажилтан албан хаагчдад зориулсан үйл ажилаагааны гарын авлага болон бодлогын талаарх гарын авлагыг бэлтгэн, шинэчлэн, түгээх	Бодлого идэвхтэй болох өдөр гэхэд	Ажилчдад зориулсан үйл ажилаагааны гарын авлага
2.3 Зээлдэгч болон түншид зориулан бодлогын талаар мэдлэгийг сайжруулах материалуудыг боловсруулан түгээх	Бодлого идэвхтэй болсноос 3 сарын дотор	Мэдлэгийг дээшлүүлэх материалуудыг гаргасан
2.4 Ажилчид болон холбогдох оролцогч талуудад шинэчилэгдсэн ОНХБ-ын талаар мэдээлэл түгээх үйл ажиллагаа болон сургалт явуулах	Бодлого идэвхтэй болсноос 1 жилийн дотор	ОНХБ-ын жилийн тайлан
2.5 Орчуулгын хүрээг шинэчлэх	Бодлого идэвхтэй болох өдөр гэхэд дууссан	Орчуулгын хүрээг шинэчилсэн
2.6 Мэдээллийг ил гаргах талаарх шаардлагуудын хэрэгжилтийг хянах	Байнга (жилд хамгийн багадаа нэг удаа)	Мэдээллийн ил гаргах нэгжийн хяналтын тайлан болон ОНХБ-ын жилийн тайлан

АХБ. Хөгжлийн үр нөлөөг эргэн харах нь. <http://www.adb.org/defr>

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк.

## Азийн Хөгжлийн Банкны тухай

АХБ-ны алсын хараа бол ядуурлаас ангид Ази, Номхон далайн бүс нутаг. Банкны эрхэм зорилго нь өөрийн хөгжиж буй гишүүн улс орнуудыг ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааг сайжруулахад чиглэнэ. Ази Номхон далайн бүс нутгийн хувьд ихээхэн ахиц дэвшил гарсан хэдий ч дэлхийн ядуу хүн амын ойролцоогоор гуравны хоёр нь тус бүс нутагт амьдарч байна: тухайлбал, 1.8 тэрбум хүн өдөрт 2 хүрэхгүй ам.долларын орлотой байгаа бол 903 сая хүн өдөрт 1.25 хүрэхгүй ам.доллараар амиа зогоодог. АХБ хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, байгальд халгүй тогтвортой хөгжил, бүс нутгийн интеграцчиллыг дэмжих замаар ядуурлыг бууруулахаар тууштай ажиллаж байна.

Манила хотод төвтэй АХБ нь 67 гишүүнтэйгээс 48 нь тус бүс нутгийнх. АХБ нь бодлогын дэмжлэг, зээл, хөрөнгө оруулалтын хувьцаа, баталгаа, буцалтгүй тусламж, техникийн тусалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан өөрийн гишүүн хөгжиж буй улс орнуудад тусламж үзүүлэн ажилладаг.

Азийн Хөгжлийн Банк  
6 АХБ өргөн чөлөө, Мандалуонг хот  
1550 Метро Манила, Филиппин  
[www.adb.org](http://www.adb.org)  
ISBN 978-92-9257-795-7  
Хэвлэлийн дугаар. TIM178736-2

 Дахин боловсруулсан цаасан дээр хэвлэв.



Филиппин улсад хэвлэв.